Хайрт Монгол орноо мандуулъя!

ХИЛ СУДЛАЛ

Хилийн Цэргийн Дээд Сургууль-Монголын Хил Судлалын
Үндэсний Нийгэмлэгийн онол-мэдээллийн сэтгүүл

14 дэх жилдээ Улиралд нэг удаа гарна

01-02/26-27
2011 он

АГУУЛГА

ХИЛ СУДЛАЛ, ОНОЛ ПРАКТИК

Д.Дашдаваа *Хилийн аюулгүй байдал ба түүнд учрах аюул занал, тэдгээрийн агуулга, мөн чанар*

Х.Гөлгөө *Улсын хил хамгаалалтад шинжлэх ухааны ололтыг ашиглаж байгаа туршлага*

Ц.Ганболд *Монгол улсын үндэсний аюулгүй байдал ба дүрвэгсдийн асуудал*

П.Даш *Олон улсын терроризм, түүнтэй хийх тэмцлийг боловсронгуй болгох зарим асуудал*

Г.Дагважамц *Монгол улсын эрдэс баялгийн геополитик, хөрш гүрнүүдийн хүчин зүйл*

Г.Уламбаяр *Монгол улсын аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар хамгаалах нь*

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ СУДАЛГААНЫ АЖИЛ

Т.Сүхбаатар *Улсын хил хамгаалалтанд Зэвсэгт хүчний анги, салбарууд дэмжлэг үзүүлэх үндэслэл,*

Х.Гантулга *Олон улсын Зэвсэгт мөргөлдөөний хуулийн зарчим*

Б.Аманбек *Хилийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болох нь*

СУРГАЛТ АРГА ЗҮЙ

Н.Алтанзул *Дээд боловсролын хөгжлийн энэ зууны зорилго*

ХИЛИЙН ТҮҮХ

И.Саруул *Монгол улсын хилийн түүхийн үечлэлийн тойм*

Д.Одзаяа *Хүннүгийн морьт цэрэг*

ХИЛЧИН БА ХУУЛЬ

П.Даш *Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг түдгэлзүүлэх эрх зүйн хэм хэмжээг боловсронгуй болгох нь*

ТАНЫ БОЛОВСРОЛ, ТАНИН МЭДЭХҮЙН САНД

Д.Оюунцэцэг *Клоны этикийн асуудалд*

ЯРИЛЦЛАГА

Д.Оргилбаатар *Монголын зохиолчдын эвлэлийн гишүүн Л.Нямаатай хийсэн ярилцлага*

ХИЛЭЭС ТӨРСӨН УРАН БҮТЭЭЛ

Д.Хурц *Хилчний гэргий*

ШИНЭ НОМ

Ц.Ганболд, Д.Баатар *Штабын бэлтгэл*

Ч.Жазаг *Гэгээн судар*

ХИЛ СУДЛАЛ, ОНОЛ ПРАКТИК

Д.Дашдаваа. ХЦДС-ийн захирал, профессор хурандаа

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТҮҮНД УЧРАХ АЮУЛ ЗАНАЛ, ТЭДГЭЭРИЙН АГУУЛГА МӨН ЧАНАР

Хилийн аюулгүй байдал түүнд учрах аюул заналыг тодорхойлохын өмнө XXI зууны эхэн үеийн зүүн хойд Азийн олон улсын харилцааны өрнөлт, Монгол улсын аюулгүй байдлын талаар товч төсөөлөл хийх нь зүйтэй. Зүүн хойд ба зүүн Азийн цааш цаашдын геополитик Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал,тэр дундаа хилийн аюулгүй байдалд томоохон сорилт, сонголтыг тулгаж болзошгүй байна.

Энэ талын зарим төсөөллөөс дурьдвал: Хятад нь ирэх 10-15 жилд ДНБ-ний үйлдвэрлэлээрээ Америкийг гүйцэж түрүүлснээр дэлхийн хамгийн том эдийн засаг болох магадлалтай. Хятадын эдийн засгийн ийм хүч чадал нь Хятадын:

- Иргэншлийн (кунзийн) хүрээний улсуудтай хавсран нийлбэл түүний үүрэг, үзүүлэх нөлөө асар ихээр өснө
- Хятад нь орчин үеийн зэр зэвсэг,технологи, зэвсгийн системийг ашиглан арми, тэнгисийн цэргийн флотоо шуурхай шинэчилж байгаа нь айдас төрүүлэх шалтгаан мөн
- Спратлийн арал зэрэг бүс нутгийн маргаантай асуудлаар хүчирхэгжсэн Хятад улс ямар байр суурь эзлэх, хөрш орнуудтайгаа харилцахдаа ямар бодлого баримтлах гэдэг нь бүс нутгийн төдийгүй дэлхийн бодлогын хурц асуудлын нэг болж байна.

3.Бжезинский 2020 оны Хятадыг төсөөлөхдөө ирээдүйд "Берингийн хоолойгоос Тонкины булан хүртэлх шинэ эзэнт гүрэн" нь Оросын Lenolandыг бүхэлд нь эзэлнэ. 2020 он гэхэд Хятадын нөлөөний хүрээ тэлсээр "Их Хятадын" орон зай үүснэ.(Монголыг оролцуулсан, хил дагуух нийт 20 улс) гэсэн нь дээр өгүүлснийг нотлох мэт.

Хятад нь хүч чадал,нөлөөгөө өргөжүүлэхдээ дотооддоо тунхагладаг нутаг дэвсгэрийн өнгөлзлөгөө чанагш барьж эс чадах, хүн амын өсөлт нь хил залгаа орнууддаа нөлөөлбөл ямар аюул дэгдэхийг таахад бэрх гэж хил дамжин нүүрлэх аюулын талаар Оросын цэргийн ШУА-ийн прогнозчлолын хүрээлэнгийн төвийн дарга профессор Анатолий Цыганок бичсэнээс үзвэл Хятад улс цааш цаашдаа олон улсын хуулиар тогтоосон хэм хэмжээг мөрдөж "Хамтран ажиллах зарчим" баримтлах уу,эсвэл өөрийн хэм хэмжээг тулгахыг оролдох уу гэдэг асуулт хэвээр үлдэж байна.Монгол улсын үндсэн хуулийн 4 дүгээр зүйлийн 1-д "Монгол улсын хил халдашгүй дархан байна" гэжээ. Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 1-д "Монгол Улсад газар түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл,төрийн хамгаалалтад байна; мөн тэнд Монгол Улсын иргэн эрүүл аюулгүй орчинд амьдрах,орчны бохирдол,байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах (үндсэн) эрхтэй байна гэж заасан байдаг.

Тэгвэл манай хил орчим Үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалын 3.5-д заасан "Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал" алдагдвал үндсэн хуулийн дээрх заалтууд ноцтой зөрчигдөж,манай байгаль орчинд хүн амын эрүүл мэндэд асар их хор хохирол учирна. Хэрэв аюул гэж бодит үйл явдлын үр дүнг, эрсдэл гэж аюулын тодорхой бус (баталгаажаагүй) байдлыг аюул занал гэж бодит хор хохирол учруулж болох аюулыг хэлдэг бол манай хил орчимд

тийм аюул занал бий болж байна.

Сүүлийн үед олон улсын байгууллагаас гаргасан гол гол баримт бичигт аюулыг тодорхойлох дараах зүй тогтлыг тусгасан байдаг. **Үүнд:**

1. Гол анхаарлаа шинэ уламжлалт бус аюул заналд хандуулах
2. Уламжлалт бус аюул заналыг албан ёсоор ач холбогдлоор нь дараах байдлаар эрэмбэлэх.

- Олон улсын терроризм
- Гарвал нэгтний болон шашин хоорондын мөргөлдөөн
- Тусгаар улс болох бүтэлгүй оролдлого
- Үй олноор хөнөөх зэвсгийн тархалт
- Хууль бусаар засгийн эрхийг булаах санаархал
- Зохион байгуулалттай гэмт хэрэг
- Улс хоорондын дайн

Хамгийн хүнд аюул бол уламжлалт болон уламжлалт бус аюул хослон нүүрлэх явдал бөгөөд эдгээр аюулууд хил дамнасан шинжтэй байх тул глобал маягаар асуудлыг шийдэхээс өөр боломжгүй,аюулыг эрт илрүүлэх,урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарах ёстой болж байна.

Хүн төрөлхтөний үүсэл хөгжлийн бүх үе шатанд хувь хүн,нийгэм,улс орон,хамтын нийгэмлэгийн амьдрал, үйл ажиллагааны салшгүй дагуул нь аюул занал байсаар ирсэн. Аюулгүй байдлын тухай асуудалд анхаарал тавьж байгаагүйгээс улс орон бутран сөнөж, дайн самуун дэгдэж, гай гамшиг тарьж байв.

Аюул занал нь аюулгүй байдлын объектыг устгах,тонон дээрэмдэх,хүлцэнгүй захирагдах байдалд оруулах дарамтлан устгахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөн бэлтгэх болон уг үйлдлийг гүйцэтгэхийг санаархах зэрэг янз бүрийн хэлбэрээр илэрдэг байна.

Иймээс "занал" гэсэн ойлголт "аюул" гэсэн ойлголттой төстэй учраас аюул занал гэсэн хоршоо үгээр илэрхийлэгддэг.

Аюулын өөр нэг хэлбэр нь хэрэгжүүлэх ажиллагаа амжилтгүй болж,болзошгүй аюул буюу тийм аюултай холбоотой уг үйлдэл болох эрсдэл болдог.

Дэлхий нийтэд өрнөж байгаа даяаршил,нийгэм, улс төрийн байдал, манай орны гадаад, дотоод бодлого нь улсын хилийн аюулгүй байдал, хилийн хамгаалалтын асуудалд шинжлэх ухааны үүднээс хандахын чухлыг харуулж байна. Орчин үеийн дэлхий ертөнцөд гарч буй томоохон өөрчлөлтүүд, хил дамнасан гэмт хэрэг, нийгэм эдийн засгийн хямрал зэргээс үүдэн гарч буй сөрөг үзэгдлүүд нь улсын хил, түүний орчинд хурцаар илэрч Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд бодитоор нөлөөлөх болов .

Улсын хил зөрчих, зэвсгийн наймаа, алан хядах ажиллагаа, мансууруулах бодисын худалдаа, зохион байгуулалттай гэмт хэрэг хүрээгээ тэлж байгаа нь түүнтэй тэмцэх Хил хамгаалах байгууллагын ажиллагааг шинэ нөхцөл байдалд шинэлэг арга хэлбэрээр өөрчлөн сайжруулахыг шаардаж байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад Хил хамгаалах байгууллага, Хилийн цэргийн эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, ач холбогдол өсөн нэмэгдсээр байна. 2001 онд Улсын их хурлаар батлагдсан "Үндэсний аюулгүй байдлын тухай" Монгол Улсын хуулийн хоёрдугаар бүлгийн 6 дугаар зүйлд "Үндэсний аюулгүй байдлын тогтолцоо нь Монгол Улсын их хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний тэргүүлсэн Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй төрийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон холбогдох албан тушаалтнуудаас бүрдэнэ".

Мөн Монгол Улсын хилийн тухай хуулийн 10 дугаар зүйлд " .....үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах" гэж тэмдэглэжээ.

Энэ бүхэн Монгол Улсын Хил хамгаалах байгууллагын төрийн захиргааны байгууллага болон гүйцэтгэх үүргийн онцлогоор Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тогтолцоонд багтаж аюулгүй байдлыг хангах хэрэгт оролцон тодорхой үүрэг, хариуцлага хүлээх эрх

зүйн үндсийг бүрдүүлж байна.

Төрийн захиргааны нэгэн субъект Хил хамгаалах байгууллага Монгол Улсын хилийн баталгаажилт, халдашгүй дархан байдлыг хангах, улсын хилийг хамгаалахдаа үндэсний аюулгүй байдлыг хангах тодорхой үүрэг, зорилтыг хэрэгжүүлж байна гэж "Үндэсний аюулгүй байдлын тухай" хуулинд тодорхой заасан билээ.

Энэ хуулинд "Үндэсний аюулгүй байдал гэж Монгол улсын үндэсний явгуур ашиг сонирхлыг хангах гадаад дотоод нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ" гэж заажээ. Эндээс үүдэн Монгол Улсын Хил хамгаалах байгууллага,хилийн цэргээс хилийн аюулгүй байдал гэж юу болохыг тодорхойлох шаардлага гарч ирэв.

Тэгвэл хилийн аюулгүй байдал гэдэг нь "улсын хил,хил орчмын нутаг дэвсгэр, хилийн орон зайд үндэсний аюулгүй байдал найдвартай хангагдах гадаад дотоод нөхцөл баталгаатай хангагдах явдал гэж манай олон эрдэмтэд үздэг билээ. Үүнийг судлаачийн хувьд объектив шинжтэй зөв тодорхойлолт гэж үзэж байгаа юм. Монгол Улсын Хил хамгаалах байгууллага, хилчдийн үндсэн үүрэг нь улсын хилийн баталгаажилт хамгаалалтын найдвартай байдлыг ямарч нөхцөлд хангах явдал юм.

2010 онд батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын "Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам" гуравдугаар бүлэгт оршин тогтнохын аюулгүй байдлын үндэс нь "Монгол Улсын тусгаар тогтнол бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал,нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал юм гэжээ.Хилийн аюулгүй байдал гэж:

1. Монгол Улсын төр нийгэм, хувь хүний язгуур ашиг сонирхол хилийн орчинд хангагдсан байдал буюу энэ орчинд төр нийгэм, хувь хүнд ямар нэгэн аюул занал учрахгүй, харин улсын хилээр нэвтрэх бүх бололцоог хангасан, хилийн болон хил орчмын дэглэм сахиулах, зөрчлийг цаг алдалгүй таслан зогсоох, хилийн аюул заналын эсрэг буюу түүнийг гаргахгүй байх арга хэмжээг авах явдал.

2. Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах механизм, түүний үндсэн чиглэл, зарчим, үүрэг,зорилгын талаар албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн үзэл баримтлалын тогтолцоо юм.

Хилийн аюулгүй байдал нь Монгол Улсын төрийн, орон нутгийн засаг захиргааны болон төрийн бус байгууллагууд өөрсдийн эрх мэдлийн хүрээнд улс төр, эрх зүйн,дипломатын,батлан хамгаалах, цэргийн,хилийн,тагнуулын, оператив-эрлийн, гаалийн,экологийн, хүн-мал эмнэлгийн ба бусад арга хэмжээний хүрээнд явуулах үйл ажиллагаагаар хангагдана.

Хилийн аюулгүй байдлыг хангах гол зорилго нь хилийн орчинд Монгол улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалах, гадаад дотоодын аюул заналаас төр, нийгэм,хувь хүн, чухал объектын аюулгүй байдлыг хангах, хилийн талаар байгуулсан улсын болон олон улсын гэрээ хэлэлцээр, эрх зүйн хэм хэмжээг сахих, зэргэлдээ улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх бүх талын бололцоо олгоход оршино.

Энэхүү зорилгын хүрээнд:

* Улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн болон улсын хилийн аюулгүй байдлыг хангах бүх нөхцлийг бүрдүүлэх
* Улсын хилийн талаарх олон улсын эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох
* Улсын хил дээр болон хил орчмын нутаг дэвсгэрт цэргийн аюул,хурцадмал байдал, зэвсэгт болон зэвсэггүй мөргөлдөөн гарахаас урьдчилан сэргийлэх талаар улс хоорондын хэлэлцээр байгуулах
* Бусад улс орны /зэргэлдээ улс/зүгээс өөрийн орны нутаг дэвсгэрт хүчээр шилжин суурьших, эдийн засгийн түрэмгийллийн эсрэг чиглэсэн арга хэмжээг авах
* Улсын үндэсний эрх ашгийн үүднээс хилийн орон зайд цэрэг улс төрийн бүлэглэл болон бусад гадны улсын зүгээс тусгаарлагдмал байдалд орох аюулыг арилгах
* Ямарч хэлбэрийн гэмт хэргийн

үйлдлийг /санаатайгаар улсын хил зөрчих,хууль бусаар буу зэвсэг, мансууруулах бодис, эд зүйлс нэвтрүүлэх, хил дамнасан гэмт бүлэг орж ирэх г.м/ таслан зогсоох чадвартай болгохын тулд улсын хил хамгаалалтыг бэхжүүлэх

* Улсын тусгаар тогтнол, түүний материаллаг болон оюуны баялгийн эсрэг ямарч үйлдлийг таслан зогсоох
* Улсын хилийн баталгаажилт, хамгаалалт эрхэлсэн байгууллагуудыг хөгжүүлэн, ялангуяа улсын хилийн болон хил орчмын хамгаалалтыг сайжруулах
* Улсын хил болон хил орчмын нутаг дэвсгэрийг хамгаалах үүрэг бүхий субъектүүдийн нэгдмэл ажиллагааг хангах
* Хамгаалалт эрхлэх бүх субъектийн алба, байлдааны болон бусад боломжийг дээшлүүлэх, бэлэн байлгах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай болдог.

Улс үндэстний аюулгүй байдал алдагдах явдал юуны түрүүнд улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрээс эхлэх магадлал өндөр байдаг болохоор хилийн аюулгүй байдлыг хангах асуудлыг тэргүүн ээлжинд шийдвэрлэх нь чухал.

1994 онд Улсын Их хурал түүхэнд анх удаа "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал" хэмээх нэртэй баримт бичиг батлан гаргасан билээ. Үүнээс хойш 17 жил өнгөрлөө. Энэ хугацаанд үндэсний аюулгүй байдлын талаарх ойлголт онолын болон сэтгэлгээний агуулга талаасаа ихээхэн шинэчлэгдэж, Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчин, дотоод нөхцөл байдал, эдгээрт нөлөөлөх хүчин зүйлүүд танигдахын аргагүйгээр өөрчлөгдлөө.

Ялангуяа учирч болзошгүй аюулын тухай бидний төсөөлөлд ихээхэн өөрчлөлт орж, уламжлалт аюулын зэрэгцээ үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хүний наймаа,мансууруулах бодисын зөөвөр, цөмийн түүхий эд, материал дамжуулан худалдаалах, үйлдвэрлэх оролдлого, байгалийн гамшигт үзэгдэл, дэлхийн цаг уурын дулаарал, хүний амьдрах орчны бохирдол, нэн халдварт өвчний тархалт, олныг хамарсан ядуурал, эмх замбараагүй дүрвэлт гэх мэт улс орны хил хязгаараар зааглагддаггүй уламжлалт бус аюулын хүрээ өргөжиж байгаагийн дотор олон улсын терроризм дэлхий нийтийг хамарсан шинэ аюул занал болон хувирч байна.

Даяаршиж буй өнөөгийн нөхцөлд дэлхий дахины хөгжлийн ерөнхий хандлага, төлөв нь манай гадаад орчин, язгуур ашиг сонирхолд хир нөлөөлж болохыг урьдчилан харахад хэцүү билээ.

Хэдий тийм боловч бодит мэдээлэл, нарийн ажиглалт,судалгаанд үндэслэж Монгол улсын гадаад орчин, улс төр, нийгэм эдийн засгийн хөгжилд учирч болзошгүй аюул, саад тотгорыг зөв тооцоолон тодорхойлж урьдчилан сэргийлэх, аюулыг зайлуулах буюу хамгийн бага эрсдэлтэйгээр давж туулах зөв арга шийдлийг олж байх нь чухал юм.

Иймд манай аюулгүй байдлын тогтолцоо юуны өмнө бодит мэдээлэл, урьдчилан сэргийлэлт, шийдлийн хамгийн зөв сонголтыг олж тогтоон шийдлийг бүрэн гүйцэтгэхэд чиглэсэн байх учиртай.

Хилийн аюулгүй байдал хилийн хүрээнд явагддаг бүх харилцааг хамардаг учир түүнийг томъёолохын тулд энд хэрэглэгддэг ойлголтын аппаратыг тодотгох шаардлагатай.

Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого бол улс орны нийтлэг бодлого, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын бүрэлдэхүүн хэсэг юм. Албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн, улс орны хилийн аюулгүй байдлыг хангах зорилго, зорилт, зарчмууд, үндсэн чиглэл, хэрэгжүүлэх механизмуудын талаарх ойлголтууд энэ бодлогын үндэс болдог. Уг баримт бичиг бол хилийн аюулгүй байдлыг хилийн орчинд хангах чухал хэрэгсэл юм.

Хамгийн ерөнхий байдлаар хилийн талаар баримтлах бодлогыг, улсын хилийн хамгаалалтын найдвартай байдлыг хангах, тулгамдаж байгаа хилийн асуудлуудаар шаардлагатай

нэгдсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх, улсын хил, хилийн орон зайд төр, нийгэм, иргэдийн язгуур эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн хилийн орчинд харилцааг зохицуулах төрийн захиргааны байгууллага, бусад субъектүүдийн үйл ажиллагаа гэж тодорхойлж болох юм.

2002 онд батлагдсан Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогод хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхол тухайн нутаг дэвсгэрт хангагдсан байдлаар тодорхойлогдоно гэж заажээ.

Хилийн орон зай – энэ бол, одоо болтол нийтээр хүлээн зөвшөөрч, нэг мөр болгон тодорхойлж чадаагүй байгаа категори юм. Уг ойлголтыг шинжлэх ухааны ном хэвлэлд янз янзаар тайлбарласан байгаатай тааралдаж болно. Олон хувилбарууд байгаа ч хилийн орон зай "зэргэлдээх улсуудын улс төр, нийгэм, эдийн засгийн амьдралын өөр, өөр байдал, улсын хилийн хүчин зүйлүүдээр нөхцөлдсөн үйл ажиллагаа явагдаж байдаг, хоёр улсын зааг дээр үүсэх нийгмийн онцгой бүс" юм гэж тодорхойлж болохоор байна.

Уг тодорхойлолтоор дээрх бүсийг хилийн орон зайд хамааруулах тодорхой шалгуур тогтоож, зааглах хязгаарыг тогтоож өгсөнгүй. Иймд зэргэлдээ улсын хил орчмын нутаг дэвсгэр хилийн орон зайд орох уу ч гэдэг юм уу асуудлууд гарч ирж болох, тэгвэл энэ нь онол-арга зүйн талаасаа ч, олон улсын эрх зүйн талаасаа ч байж таарахгүй асуудал юм.

Судлаачдын үзэж байгаагаар хилийн орон зайн тодорхойлолт зөвхөн нийгэм, газар зүйн асуудлуудыг агуулаад зогсохгүй, улс төр, эрх зүйн тодорхой шалгууруудыг тусгаж өгөх нь зүйтэй санагдана. Олон улсын харилцаанд оролцогч улсуудын тусгаар тогтнол, мөрдөгдөж байгаа олон улсын эрх зүйн хэм хэмжээ, түүхэн эрх, үндэсний ашиг сонирхлыг харгалзах нь чухал юм. Энэ талаас нь авч үзвэл, "хилийн орон зайг үндэсний ашиг сонирхол, олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу эрх зүйн тусгай журам тогтоогдсон, төрийн тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор эрх бүхий байгууллагууд хяналт шалгалтын болон, хамгаалалтын журам сахиулж байгаа, хил орчмын нутаг, агаар, ус, нутаг дэвсгэрийн хэсгийг хэлнэ" гэсэн А.С. Щербаковын тодорхойлолт бол хилийн орон зайд нилээд зохицсон тодорхойлолт юм.

Монгол Улсын хилийн орон зай гэдэг бол, хамрах хүрээнд нь улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал хангагдаж байгаа, улсын хилийн дагуу байрласан, хил орчмын нутаг бусад физик-газар зүйн мужлалуудад харьяалагдах нутаг дэвсгэрийн хэсэг юм.

Хил судлалын ном, сурах бичгүүдэд бичсэнээс үзвэл хилийн орон зай бол улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр, шалган нэвтрүүлэх боомтууд, эдийн засгийн чөлөөт бүс, агаар мандал багтан ордог, хуурай газар, усан болон газрын доорх орон зай нь хилийн аюулгүй байдлыг хэрэгжүүлэх газар зүйн орчин болно.

Эдийн засгийн чөлөөт бүсүүд хилийн орон зайн хүрээнд онцгой байдлаар ашиглагддаг нь нэг талаас, тэндэхийн үйл ажиллагаа тусгай хуулиудаар зохицуулагддаг, нөгөө талаас, олон улсын эрх зүй, Монгол Улсын үндсэн хууль, бусад хуулиудаар баталгаажсан, тэнд хил хамгаалах байгууллагуудын хүч хэрэгслээр төрөл бүрийн хяналт-хамгаалалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн, төр, нийгэм, иргэдийн язгуур эрх ашгийг хамгаалж байдгаар тайлбарлагдаж байгаа юм.

Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу, эдийн засгийн чөлөөт бүсийн гадна орших газар нутагт хилийн хууль зөрчигдөх явдлыг таслан зогсооход шаардлагатай хяналт хийгддэг.

Уг бүсэд, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явагдана. Одоо бол улс орны нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд

учруулж болзошгүй аюул занал, эдийн засаг, хүн амын түрэмгийлэл, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг гэх мэтийн үндэсний шинжтэй голлох бэрхшээл, зөрчил бүхэн хилийн орон зайд л хуримтлагдаж байдаг билээ. Энэ бүхэн, улс орны хилийн орон зайд хуримтлагдаж байгаа аюулгүй байдалд учирч болзошгүй аюул заналаас төр, нийгэм, иргэдийн язгуур ашиг, сонирхлыг эн тэргүүнд хамгаалах шаардлагатайг харуулж байна.

Зөвхөн хилийн орон зайд байрлаж байгаа объектуудыг л манаж хамгаалаад хилийн аюулгүй байдлыг хангачихна гэвэл хараахан тийм биш юм. Бидний үзэж байгаагаар, хилийн орон зай, хилийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх физик-газар зүйн тодорхой хязгаар тогтоогддог байна.

Улс хоорондын гэрээг хэрэгжүүлэх, олон улсын хилийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, төрийн хилийн бодлогыг хэрэгжүүлэх салбарт, шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоог боловсронгуй болгох, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, хилийн төлөөлөгчийн ажиллагаа, хууль, эрх зүйн хэм хэмжээ тогтоох баримт бичгүүд боловсруулахад оролцох гэх мэтийн үйл ажиллагааны чиглэлүүд хилийн орон зай гэх ухагдахууны гадна талд нь үлдэж байгаа юм.

Ийм учраас хилийн аюудгүй байдлыг тодорхойлохдоо нилээд нийтлэг томъёолол болох "хилийн орчин"-г ашиглах нь зүйтэй юм. Улсын хил, хилийн орон зай; хилийн харилцаа; хилийн удирдлага, байгууллага, институцүүд; хилийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд; хилийн практик, алба ажиллагаа хилийн бодлого; хилийн шинжлэх ухаан; хилийн цэргийн стратеги, тактик, оператив урлаг; нийгэм, бүлэг бие хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл, ухамсар, хилийн талаарх санаа бодол гэх мэтийн үндсэн элментүүд хилийн орчныг бүрдүүлж байна. Үүнээс үндэслээд "хилийн орчин" хэмээх ухагдахуун, хилийн аюулгүй байдлыг хэрэгжүүлэх материаллаг болон оюун санааны талыг нь илүү тодорхой илэрхийлдэг гэж хэлж болох юм.

Шинжлэх ухааны ном, сэтгүүлд хилийн орчин хилийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдэн, төрийн хилийн бодлогыг хэрэгжүүлэхтэй шууд холбоотой, үндэсний аюулгүй байдлыг хангах систем, төрийн тусгай албаны байгууллагуудын үйл ажиллагаа, төр, нийгэм, иргэдийн амьдрал, улс орны хоорондын харилцааны хэсэг юм гэж тодорхойлжээ.

Хилийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх орон зай, газар зүйн хязгаарыг тогтоогоод, хилийн аюулгүй байдлын зарчим, зорилт, үндсэн бүрэлдвэрүүдийг тодотгож, хилийн аюулгүй байдлыг тодорхойлон томъёолох хэрэгтэй.

Хилийн аюулгүй байдлын үндсэн үүрэг зорилт бол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, төрийн тусгаар тогтнолыг хангах, улсын хил, хязгаар нутагт сайн хөршийн харилцаа, энх тайвнаар зэрэгцэн оршиход чиглэгдсэн, хилийг зөрчилгүй байлгах олон улсын зарчим, бусад улс хоорондын эрх зүйн хэм хэмжээг сахиулах, улсын хилийн шугамын явалтыг хууль бусаар өөрчлүүлэхгүй байх, хилийн дэглэм, журмыг хувь хүмүүс, хуулийн этгээдүүдээр сахиулах явдал юм.

Эцсийн эцэст хилийн аюулгүй байдал, төр, нийгэм, иргэдийн язгуур эх ашгийг хилийн орчинд хангах замаар үндэсний хийгээд, улс хоорондын аюулгүй байдлыг хангах тогтвортой урьдчилсан нөхцлийг бүрдүүлэх явдал юм.

Үүнээс үндэслэн улс орны нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангаж, тусгаар тогтнолыг бэхжүүлэн, улсын хил, хилийн орон зайд цагийн байдлыг тогтвортой байлгаж, төр, нийгэм, иргэдийн язгуур эрх ашгийг хилийн орчинд хэрэгжүүлэх таатай нөхцлийг хангах, учирч болзошгүй аюул заналыг арилгах, хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо бүрдүүлэх нь хилийн аюулгүй байдлын үндсэн зорилго байна.

Уг зорилгыг хангахад чиглэгдсэн үндсэн зорилтууд нь:

- Шаардаглах эрх зүйн хэм хэмжээ тогтоосон баримт бичгүүдийн багц бүрдүүлэх
- Улсын хилийн гэрээ эрхийг бүрдүүлж, хилийг дипломатын аргаар хамгаалах
- Улс хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Бусад улсын зүгээс Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулж байгаа эдийн засаг, хүн ам, шашин соёлын түрэмгийллийн эсрэг ажиллагаа явуулах
- Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хууль бусаар цагаачлах ажиллагааг таслан зогсоох
- Хариуцсан хэсэгтээ, хөрш улсуудтайгаа энх тайван, тогтвортой, сайн хөршийн харилцаа тогтоох
- Хилийн орон зайд аюулгүй байдлыг хангах хамтарсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Хилийн дэд бүтцийг хөгжүүлэх, шинэ заагууд дээр улсын хилийг тэхөөрөмжлөх
- Улсын хил дээрх хил, гааль, цагаачлал, эрүүл ахуйн болон бусад хяналтын үр дүнг нэмэгдүүлэх
- Хил орчмын нутаг дэвсгэрт эдийн засаг, улс төр, үндэстэн хоорондын тайван, тогтвортой байдлыг хангах явдал юм.

Миний бие төр, нийгэм, иргэдийн хилийн орчин дахь язгуур эрх ашгийг хилийн аюулгүй байдлын үндсэн объектуудаар онцолж байгаа бөгөөд улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийг тэдгээрийн тархах хүрээ, эхлэх цэг гэж үзэж байна.

Хилийн аюулгүй байдлыг, үндэсний аюулгүй байдалтай адилтган үзвэл түүнийг хангах үндсэн субъектүүд нь:

- Төрийн захиргааны байгууллагууд
- Орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд
- Улс орны ард иргэд юм.

Хилийн аюулгүй байдлын агуулга нь хилийн орчинд үндэсний ашиг сонирхол, эдгээрт учруулж болзошгүй аюул занал, түүнээс хамгаалах талаар хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны чиглэсэн зорилготой үйл ажиллагаагаар урьдчилан тодорхойлогддог байна.

Дээр тэмдэглэснээр "аюул занал" гэх ухагдахууныг "аюул" гэдэг категориор дамжуулах тодорхойлох нь зүйтэй. Аюулыг ямар нэг тогтолцоог эвдэн задлах, өөрөөр хэлбэл "уг тогтолцоонд хохирол учруулах, түүнийг жагсаалаас гаргах юм уу бүрэн устгах" чадвартай хүч (хүчин зүйл)-ний үйлчлэл юм гэж тодорхойлж болно.

Үүнээс үзвэл, хилийн орчинд Монгол Улсын ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдалд учруулж болзошгүй аюул заналыг, хилийн бодлогыг хэрэгжүүлэх явцад улс хоорондын хийгээд улс төрийн нөхцөл байдлыг тогтворгүйжүүлж чадах хүчин зүйлүүд, нөхцөл байдлын нийлмэл цогц гэж тодорхойлж болох байна.

Юуны түрүүнд хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны элментүүдийн үйл ажиллагааны үр дүнг бууруулах, хилийн орчинд иргэд, (төр, нийгэм, иргэд)-ийн язгуур эрх ашгийг хохироох, Монгол Улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулахад чиглэгдсэн, дайсагнагч хүчний төлөвлөгөө, практик алхам, хууль зөрчсөн үйлдлүүд, гадаад дотоод бүлэглэлийн хорлон сүйтгэх, хагалан бутаргах үйл ажиллагаа зэрэг нөхцөл байдлыг бүрдүүлж байгаа юм.

Монгол Улсын ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдалд орчин үеийн нөхцөлд учруулж болзошгүй нилээд ноцтой аюул заналуудад:

* Хөрш зэргэлдээ улсуудын цэргийн бүлэглэлүүдийн тоо нэмэгдэх
* Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт, гадаадын тусгай албадын тагнуул-хорлон сүйтгэх үйл ажиллагааны хүрээ өргөжих
* Хил залгаа улсуудын хилийн районд улс төр, үндэстэн хоорондын, шашны болон бусад сөргөлдөөн, орон нутгийн дайн, зэвсэгт мөргөлдөөн зэрэг гадаад, дотоод түгшүүрт байдлын голомтууд үүсэх
* Гурав дахь орны иргэд Монгол Улсын

нутаг дэвсгэрээр дамжин цагаачлах, тэдний зарим нь хилийн ойролцоо үлдэхийг оролдох

* Гадаадын иргэд, тэр дундаа хууль бус цагаачдыг улс орны эдийн засгийн орон зайд нэвтрүүлэх
* Хил орчмын улсуудтай холбоо харилцаагаа сулруулах
* Улс орон гадаад эдийн засгийн байр суурыа алдах, хил залгаа бүс нутагт гадаадын зах зээлд гарах нь багасах
* Гэмт хэргийн бүлэглэлийн контрбандын болон бусад хууль бус үйлдэл, ялангуяа улсын хилийн зарим хэсэгт олон улсын хар тамхины наймаа идэвхжих
* Олон улсын терроризм, өөрийн оронд болон зэргэлдээх улсад улс төрийн экстремист бүлэглэлүүдэд холбоо харилцаа тогтоох зорилгоор хилийн орон зайг ашиглуулах
* Дээрмийн бүлэглэлүүд хилийн зурвас, хил орчмын нутаг, дэвсгэрт байлдааны ажиллагаа явуулж, террорист ажиллагаа үйлдэх

Хилийн орчинд Монгол Улсын ашиг сонирхолд учруулж болзошгүй аюул занал өнөө хэр хадгалагдсаар байгаа төдийгүй хэмжээ далайц, эрчим төрөл нь ихсэх хандлагатай байгаа юм. Үүнтэй холбогдуулан дээр дурдагдсан аюул заналуудыг арилгах, саармагжуулах зорилгоор улсаас авч хэрэгжүүлж байгаа улс төр, нийгэм, цэргийн шинжтэй арга хэмжээнүүдийн зэрэгцээ "Монгол улсын ашиг сонирхолд хилийн орчинд, үндэсний аюулгүй байдалд учруулж болзошгүй аюул занал"-ын ерөнхий тодорхойлолт, тэдгээрийг тодорхойлох үндсэн шалгуур үзүүлэлтүүд (эдийн засаг, хүн ам зүй, зэргэлдээ улсаас манай улсын нутаг дэвсгэрт үйлдэж болзошгүй шашин-соёлын түрэмгийлэл, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл, гадаадын террорист байгууллагуудын үйл ажиллагаа, эдгээрийн үлэмж аюултай илрэлүүдийн жагсаалт) түүн дотроос газар нутгийн маргаан, зэргэлдээ улсад гарч байгаа цэргийн үйл ажиллагааны идэвхжил, улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт явагдаж буй тагнуулын хорлон гүйцэтгэх үйл ажиллагаа, нийгэм улс төрийн түгшүүртэй байдлын голомт, зэвсэгт мөргөлдөөн, контрбанд, гэмт хэргийн бүлэглэлүүдийн бусад ажиллагаа, ялангуяа олон улсын хар тамхины наймаа, терроризм үүсэх үндсийг боловсруулан төрөөс хилийн талаар баримтлах бодлогодоо тусган, албан ёсоор баталгаажуулах асуудал онцгой чухлаар тавигдаж байна.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг шинэчлэн гаргаж, эндээ тулгуурлан хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлж хөгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна. Энэ бүгдээс үндэслэн Монгол Улсын хилийн аюулгүй байдлын тодорхойлолтыг томъёолох боломжтой болж байгаа юм.

Хилийн аюулгүй байдлыг Монгол Улсын төрийн захиргааны байгууллагууд, хилийн аюулгүй байдлыг хангах зориулалттай бусад субъектүүдийн олгогдсон эрх мэдлийнхээ хүрээнд, хилийн орчинд явуулж байгаа харилцан зохицуулагдсан хамтарсан үйл ажиллагаагаар хангагддаг, төр, нийгэм, иргэдийн язгуур эрх ашиг, гадаад болон дотоод бодит хийгээд болзошгүй аюул заналаас хилийн орон зайд хамгаалагдсан байдал гэж тодорхойлж болох байна.

Улсын хилийн аюулгүй байдал бол өөрийн гэсэн харьцангуй биеэ даасан судлагдахуунтай байх агаад, иргэдийн баялаг, чинээлэг амьдралыг тэдний үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны амин чухал салбарт ханган хөгжүүлэх нөхцөл, улс орны амьдрах чадвар, үндэсний ашиг сонирхлыг хамгаалах явдал юм гэдэг нь энэ тодорхойлолтоос үзтэл илэрхий.

Монгол Улсын ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдалд хилийн орчинд учирч болзошгүй аюул заналыг арилгах зорилгоор хэд хэдэн зорилтуудыг шийдвэрлэх шаардлагатай бөгөөд, тэдгээр нь:

* Хилийн орон зайд улс төр, нийгэм, иргэдийн үйл ажиллагааг зохицуулан, бүрэн эрхийг тодорхойлсон, шаардлагатай эрх зүйн баримт бичгүүдийг батлуулан гаргаж,

боловсронгуй болгох

* Улс хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх

* Бусад улсын зүгээс Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэж болзошгүй эдийн засаг, хүн ам, шашин-соёлын түрэмгийллийн эсрэг арга хэмжээ авах

* Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл, хууль бусаар цагаачлах үйл ажиллагааг таслан зогсоох зэрэг болно.

Монгол Улсад эрх зүйт төрийг бүрдүүлж байгаа үеийн тэргүүн зэргийн зорилт бол, хилийн орчинд нийгмийн харилцааг зохицуулж буй, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон баримт бичгүүдийг гаргаж боловсронгуй болгох явдал юм. Эдгээр зорилтуудыг шийдвэрлэснээр, хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны үйл ажиллагааны бүх чиглэлүүдийг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх боломж бүрдэж хилийн орчинд Монгол Улсын үндэсний ашиг сонирхолд учирч болзошгүй голлох аюул заналыг сулруулахад туслан, улмаар үндэсний болон олон улсын аюулгүй байдал сайтар хангагдах хэмжээнд хүрнэ. Эндээс дараах дүгнэлтийг хийж болохоор байна.

Одоо "Монгол Улсын хилийн аюулгүй байдал" гэх нэр томъёо өргөн хэрэглэгдэх болж, шинжлэх ухааны ном, хэвлэл, эрх зүйн актуудын аль алинд нь ихээхэн ашиглагдаж байна.

Гэвч уг ухагдахууны томъёолол болон хилийн аюулгүй байдлын ойлголтын аппаратын талаар нэгдсэн ойлголтод хүрээгүй байгаа маань, түүнийг эрх зүйн талаас нь хангахад ихээхэн хүндрэл учруулж байна.

2."Хилийн аюулгүй байдал" гэх ухагдахууныг томъёолохдоо, хилийн аюулгүй байдал, аюулгүй байдлын тухайлсан төрлийн янз бүрийн тодорхойлолтод ихэвчлэн ашиглагддаг хилийн орон зайнаас өргөн хүрээнд хэрэгждэгийг иш үндэс болгох хэрэгтэй.

Хилийн орон зай, хилийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх тодорхой физик-газар зүйн хилийг тогтоож өгдөг учраас, дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны олонх чиглэлүүд үлгэрлэж хэлбэл хилийн орон зай хэмээх ухагдахууны гадна үлдэж байна.

Иймд хилийн аюулгүй байдлыг тодорхойлох нилээд нийтлэг ухагдахуун болох "хилийн орчин"-ыг ашиглах нь зүйтэй.

Хилийн орчин гэдгийг хилийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн, төрийн хилийн бодлогыг хэрэгжүүлэхтэй шууд холбоотой, үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо, төрийн тусгай албаны байгууллагуудын ажиллагаа, төр, нийгэм, иргэдийн алба үйл ажиллагааны улс хоорондын харилцааны хэсэг гэж ойлгож байна.

3."Хилийн аюулгүй байдал" гэх ухагдахууныг өнөөгийн байдлаар аюулгүй байдал, улс төр, эрх зүйд ажиглагдаж байгаа цаг үеийн нэн чухал категори юм.

Ихэнх нь хилийн орчинд хуримтлагдан өрнөж байдаг, гадаад, дотоод аюул заналаас Монгол Улсын үндэсний ашиг сонирхлыг хамгаалах бодит шаардлагаар нөхцөлдөж байна.

Хилийн аюулгүй байдлын мөн чанар нь Монгол Улсын төрийн захиргааны байгууллагууд,хилийн орчинд өөрийнхөө эрх мэдлийн хүрээнд хилийн аюулгүй байдлыг хангаж буй бусад субъектүүдийн урьдчилан зохицуулагдсан хамтын ажиллагаар хүрэх, хилийн орон зайд бодит болон болзошгүй гадаад, дотоод аюул заналаас төр, нийгэм, иргэдийн язгуур эрх ашиг хамгаалагдсан байдал юм.

Монгол Улсад эрх зүйт төрийг бүрдүүлж байгаа өнөөгийн нөхцөлд төр, нийгэм, иргэдийн язгуур эрх ашгийг хамгаалах тэргүүн зэргийн зорилт бол хилийн орчинд нийгмийн харилцааг зохицуулах, эрх зүйн баазыг буй болгох, одоо байгааг боловсронгуй болгох явдал юм.

Х.Гөлгөө. ХЦДС-ын ХАБФ-ын арга зүйч багш

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД ШИНЖЛЭХ УХААНЫ ОЛОЛТЫГ АШИГЛАЖ БАЙГАА ТУРШЛАГА

ОХУ-ын хил хамгаалалтанд нэвтрүүлж байгаа олон шинэ техник хэрэгсэлээс заримыг нь орчуулан хилчиддээ хүргэж байна. Тухайлбал орчин үеийн хяналтын нэн шинэ технологи болох электрон мөр хянах зурвас буюу дүрсийн локатор -Дозор, зайнаас удирдлагатай нисэгчгүй нисэх хэрэгслийн нэг төрөл "Аэробот" ын талаар судалгааны материалыг товчлон орууллаа.

Нисэгчгүй нисэх аппарат /ННА/ "Аэробот" нь нэг төрлийн маш өвөрмөц хийцтэй, орчин үеийн электрон-дурангийн цогцолбор хэрэгслээр бүрэн тоноглогдсон бөгөөд хилийн эрэл-тагнуулын үүргийг гүйцэтгэх боломжтой юм.

Улсын хил зөрчигч нууц далдуур нэвтэрч болох бартаа саадтай газар, хүрэхэд хүндрэлтэй гуу жалга, хавцал хөндийд богино хугацаанд үзлэг хийж, бодит нөхцөл байдлыг дүрст мэдээллээр дамжуулж, зайлшгүй шаардлагатай шийдвэрийг гаргахад хилийн албаны бүрэлдэхүүнд маш өргөн боломж олгож байгаа юм байна.

Энэхүү нисэх аппаратын гүйцэтгэж байгаа үүргийг ОХУ-ын ХХА-ны бүс нутгийн удирдах газрын бараг бүх удирдлагууд нь үзэж сэтгэгдэл маш өндөр байгаагаа илэрхийлсэн байна.

Нисэгчгүй нисэх аппаратын бас нэг давуу тал нь цаг агаарын тохиромжгүй нөхцөлд удирдахад хялбар байдгаараа бусад төрлийн загваруудаас онцлог юм.

Аппаратыг халаасны зөөврийн компьютерээр удирдах бөгөөд ашиглалтанд шилжүүлэхэд ердөө 3 минут шаардах ба холбоо тасрах, хөөргөсөн газраасаа хэт алс зайд очих бол өөрөө автомат байдлаар буцаж ирдэг онцлогтой.

Хэрвээ улсын хил дээр шугамын хяналтын хэсэг болох дүрсийн локатор -"Рубеж" аар тоноглогдсон бол радио үзэгдэх орчноосоо хамаарч 1 км хүртэл хэсэг тутамд нэг шугамын хяналтын байгууламж байрлуулна.

Хилийн заставыг нэг болон хэд хэдэн Аэроботоор хангаж болох бөгөөд хил дээр байгаа мэдрэгчээс түгшүүрийн дохиог хүлээн авмагц дүрсийн локаторын программ хангамж нь Аэроботыг нисгэх зөвшөөрлийг автоматаар хүсэж удирдлагаас зөвшөөрөл өгмөгц бие даан нислэгт гардаг байна.

Хилийн заставын жижүүр нь /оператор/ Аэроботоос дамжуулсан газар орны дүрсийг дэлгэцээр харж хяналт тавьж байх ба түгшүүрийн дохио өгсөн мэдрэгчийн районд нисэж хүрээд уг мэдрэгчээр төв цэг болгон хагас зууван дугуй хэлбэрийн цагираг нислэг хийж эхлэнэ.

Энэ үеэс эхлэн удирдлагыг заставын дарга болон жижүүрийн оператор хяналтанд авч ажиллах эсвэл автомат горимоор үргэлжлүүлэн ажиллуулна..

Аэробот нь сэжигтэй обьектыг тогтоомогц заставын жижүүрийн оператор түүнийг автомат горимоор дагах ба түгшүүрийн бүлгийг ирж саатуулах хүртэл тэдгээрийн ажиллагааг радиогоор болон халаасны компьютероор удирдна. Заставын удирдлагаас түүний нислэгийн автомат горимыг өөрчлөхгүй бол тогтоосон замналаар нислэг үйлдэн даалгавраа гүйцэтгээд өөрийнхөө байрлалд бие даан буцаж ирнэ.

Хил зөрчигчийг мөрдөн хөөх явцад байрлалаасаа хэт холдсоноос радио холбооны бүсээс гарч холбоо тасрах бол өөрөө бие даан радио холбооны боломжит бүсэд шилжин орж улмаар буцаж байрлалдаа ирэх, эсвэл даалгаврыг гар удирдлагаар үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжтой.

Нисэгчгүй нисэх аппарат (ННА)-

аас дамжуулж байгаа мэдээллүүдийг заставын удирдлагын автомат хэрэгсэлээр дамжуулан бүх шатны эрх бүхий удирдах бүрэлдэхүүн хүлээн авах боломжтой. Заставын хариуцсан хэсэгт нислэг үйлдэх замналыг нь шаардлагатай чиглэл бүрт мэдрэгч нэг бүрээр гар жолоодлогоор нисгэн тогтоож, газар орны зураг дээр тоон өгөгдөл байдлаар гаргана.

Аль ч тохиолдолд Аэробот нь GPS болон сансрын холбооны мэдээллийн нэгдсэн сүлжээ ГЛОСНАСС системийг ашиглана. Шаардлагатай гэж үзвэл жижүүрийн оператор нь бүхээгийн болон удирдлагын дэлгэц дээрхи дүрсийн камер ашиглан бичлэг хийнэ.


Аэробот нь 15 минут тутамд ээлжлэн солигдож байдаг зай тэжээлээр тэжээгдэх бөгөөд тасралтгүй ажиллагааг бүрэн хангана.

Хилийн заставын хариуцсан хэсэгт нийтдээ 50 хүртэл аппаратыг ашиглаж болох хэдий ч амьдрал дээр 4-5 нэгж ННА-г ашиглахад л улсын хилийн хамгаалалтын найдвартай байдлыг хангах бүрэн боломжтой гэдгийг туршилтаар тогтоосон байна.

Аэробот нь харьцангуй хүчтэй салхинд тооцогддог 10 м/сек хурдтай салхитай үед ашиглах бүрэн боломжтой бөгөөд үүний тулд хил дээр байгаа мэдрэгчүүдийг салхины болон цаг уурын хэмжилтийн багаж төхөөрөмжөөр хангах шаардлагатай.

Энэхүү бяцхан ННА-ийн тактик техникийн үзүүлэлтийг харуулбал:

- ННА "Аэробот" -ын геометрийн хэмжээ 90х90х20 см.
- ННА- "Аэробот" – ийн жин 1 кг.
- Цогцолборын нийт жин – 5 кг.
- Нислэгийн дээд өндөр – 1 км.
- Хамгийн ашигтай ажиллагааны нислэгийн өндөр – 100 – 250 м.
- ННА-ийн нислэгийн хурд – 0 –оос 50 км/ цаг хүртэл
- Цаг агаарын хэвийн нөхцөлд нислэг хийх радиус – 12 км.
- Нислэгийн хэвийн байдлыг хангах боломжтой салхины байж болох хурд 10м/сек
- Газраас дээш 200 м өндөрт хөөрсөн үед нүдээр харагдахгүй
- ННА-ийн хөдөлгүүрийн дуу нь 70 м-ээс цааш сонсогдохгүй
- Нэг иж бүрдэл аккумляторoор тасралтгүй нисэх хугацаа 30 минут
- Нөөцөд дагалдаж ирэх аккумлятoрын тоо - 1
- Нислэгт бэлтгэхэд нэг хүн 3 минут шаардна.
- Нислэг хийхэд тусгай мэргэжил шаардахгүй, цогцолборыг ашиглахад шаардлагатай сургалтыг явуулахад нислэгийг удирдах ажиллагаа ороод 30 минутын багтаамжтай сургалт явуулахад хангалттай.
- Тоон өгөгдөл бүхий Wi-Fi. радиосувгаар нууцласан удирдлага хийнэ
- GPS болон сансрын холбооны мэдээллийн нэгдсэн сүлжээ ГЛОСНАСС системийг ашиглан байршлаа тодорхойлно.
- Дүрсийн дэлгэц нь өнгөтэй, 480 Твл, 3 дахин өсгөлт бүхий дүрсийн тогтворжуулагч бүхий дурангийн системтэй
- Дүрсийг 4 цагийн туршид тасралтгүй бичих боломжтой
- Хааш хаашаа 1х1 м талбайд буух болон хөөрөх чадвартайгаас гадна агаарт зогсолт хийх боломжтой.
- Хилийн заставын хариуцсан хэсэг дээр "Дүрсийн локатор"-ын хамтаар хослуулан ашиглаж болох бөгөөд энэ тохиолдолд жижүүрийн оператор ажлын



байрнаасаа холбооны хэрэгсэл ашиглан гүйцэтгэнэ. Гар ажиллагаа болон автомат горимоор түгшүүрийн дохио өгөгдсөн

нөхцөлд нислэг үйлдэх бололцоотой байдгаараа давуутай.

Аэробот нь хилийн заставын бүрэлдэхүүний хоногийн ачааллыг багасгах ,түгшүүрийн дохиогоор ажиллах үед илүү үр дүнтэй ажиллагаа явуулах боломж олгож байгаагаараа онцлог юм.

ННА аэробот нь маш өвөрмөц хийц бүхийнисдэгтэрэгнийзагварбөгөөдорчин үеийн электрон дурангийн цогцолбороор бүрэн тоноглогдсон байхын хамтаар эрэл- тагнуулын болон эрэл-хайгуулын ажиллагаанд зориулагдсан. Агаарын эргүүлийг богино хугацаанд тодорхой хэсэгт хийх боломжтой учраас манай орны ихэнх хэсэгт үр дүнтэй ашиглагдах орчин үеийн хил хамгаалалтын техник хэрэгслийн нэг төлөөлөл юм.

ННА "Аэробот " нь ОХУ-ын ХАБА-ны Хилийн албаны бүрэлдэхүүнд шинэ төрлийн хяналт-хамгаалалтын техник хэрэгслийн системийн хувьд цоо шинээр нэвтэрч эхлэж байгаа болно.

ДҮРСИЙН ЛОКАТОР-"ДОЗОР"

Дүрсийн локаторын энэхүү систем нь ил задгай өргөн уудам орон зай, улсын хилийн зааг дээр хиймэл ой ухааныг ашиглан ажиглах болон хяналт хийх, хамгаалалтыг зохион байгуулахад зориулагдсан бүтээл юм.

Гүйцэтгэх үүрэг нь:

- Задгай томоохон орон зайд хиймэл оюун ухааныг ашиглан бодит цагийн байдлын дагуу дүрсийн хяналт хийх
- Радиолокацийн горим дээр дүрсийн болон дулаанаар мэдрэх эргэлтийн дурангууд ашиглан целийг бие даан илрүүлэх, дагах ажиллагааг гүйцэтгэх
- Хамгаалж байгаа хэсэг болон улсын хил дээр байрлуулсан ямар ч төрлийн мэдрэгч, мэдээлэл дамжуулах хэрэгсэлүүдээс мэдээлэл хүлээн авч оюунлаг боловсруулалт хийх
- Цогцолборын өөрийн аюулгүй байдлыг хангах
- Хяналтын цэгээс алс зайд холбооны сувгаар мэдээлэл дамжуулах

Дүрсийн локатор нь хийцийн хувьд суурин болон шугамын хэсгээс бүрднэ.


Сууринхэсэгтнь"дүрсийнлокаторын сервер болон 48 бит/с хурдтайгаар дамжуулах радиорелейны холбооны STS-505 хяналтын төхөөрөмж орно.

Операторын буюу заставын даргын ажлын байранд мультисистем бүхий хоёр дэлгэц байрлана.

Харин шугамын хэсэгт нь төхөөрмж бүхий цамхаг, бие даасан тэжээлийн үүсгэвэр бүхий STL-703 –аас бүрдэнэ.

Цамхаг дээр байрлах төхөөрөмжүүд нь:

- Алсын зайд ажиглалт хийх зориулалт бүхий эргэлтийн дүрсийн камер SDR-808
- Дулаанаар мэдрэгч SDR-8415м
- Орчны хяналт хийх зориулалт бүхий хяналтын дүрсийн камер SDR-810 -2 ш
- Цогцолборын аюулгүй байдлыг хангах олон зориулалтын хяналтын



төхөөрөмж

- Радиорелейны холбооны хяналтын төхөөрөмж STS-505 антейн болон холболтын төхөөрөмжийн хамт
- Бие даасан тэжээлийн эх үүсгэврийг хангах болон өөрийн аюулгүй байдлыг хангах төхөөрөмж
- Эргэлтийн хурдтай камер SDR-806
- Өөрийн аюулгүй байдлыг хангах ххяналтын төхөөрөмж STS-502R
- Хэт улаан туяаны прожектор STS-10220-2ш
- Өөрийн аюулгүй байдлыг хангах

мэдрэгч ORTEX-402 2ш

- Чанга яригч төхөөрөмж

Бие даасан тэжээлийн үүсгэвэрт түүнээс гадна салхин сэнс болон нарны зай хураагуур багтана.

Техникийн үндсэн өгөгдөхүүн:

- Дүрсийн камераа хүнийг илрүүлэх алсын зай 2000-2500 м
- Хүнийг дулаанаар мэдрэх алсын зай 2700 м
- Автомашиныг илрүүлэх алсын зай 3500-4000 м
- Автомашиныг дулаанаар мэдрэх алсын зай 6900м
- 704*576 пиксель нарийвчлалтайгаар секундэд 25 хуудас зураг авна.
- Нэг ээлжинд нэгэн зэрэг 50 цел /бай/-г ажиглана
- Дүрсийн камер SDR-808 нь өнгөтэй, 540 Твл үзүүлэлттэй, өдөр шөнө ажиллах горимтой, обьектив нь 30-750 мм трансфокатортай, секундэд 45 градус хурдтай
- Дулаанаар мэдрэгч нь өндөр мэдрэмж бүхий микроболометр бүхий хөргөлтгүй элементээс бүрдэх ба гэрлийн спекторын 8-14 мкм, 384*288 пиксельтэй, мэдрэмж нь 50 мк
- Хэвтээ тэнхлэгт 360 гарус, босоо тэнхлэгт 90 градуст ажиллана
- Радиорелейны холбоог 80 км зайд 48 бит/сек хурдтайгаар дамжуулна. Сувгийг автоматаар хайх ба алдаагаа өөрөө тодорхойлно.
- Үндсэн цамхагийн өндөр нь 9 м, цамхагийн дээд хэсэгт гаднын хүн хүрэхээс хамгаалсан хавхлагтай.
- Хэт улаан туяаны прожектор нь 200 м хүртэл зайд гэрэлтүүлнэ.
- Салхин сэнсний хүч нь 1,2 Квт, нарны зай хураагуурынх нь 600 вт
- Тэжээлийн аккумлятор нь 1600 Ач багтаамжтай
- Нар, салхины зай хураагуурын ажиллагаа тасалдсан үед 6 хоногийн туршид бие даан ажиллах боломжтой.
- Их засварт орох хүртэлх ажиллах боломж нь 5 жил
- Үе шатны техникийн үйлчилгээ нь хагас жилд 2 удаа
- Хүрээлэн байгаа орчинд ажиллах боломж нь +50-аас -50 хэм

Ажиллагааны ерөнхий байдал:

Оператор / жижүүрийн ажиглагч/ нь онцгой анхаарал татаж байгаа хэсэг буюу бүсийг тодорхойлно.

Энэ чиглэлд алсын зайн ажиллагаатай дүрсийн болон дулаанаар мэдрэх төхөөрөмжийг чиглүүлэн програмчлана.

Эдгээр камерууд нь заасан хугацааны дотор бие дааж газар орны байдлыг дүрсээр харуулана. Ямар нэгэн хөдөлгөөнт цель /дүрс/* илэрсэн үед түнийг автоматаар барьж таних, дагах ажиллагааг автоматаар гүйцэтгэх ба сэжигтэй зүйл илэрмэгц пиктограмм дээр улаан өнгийн гэрэл асаж түгшүүрийн дуут дохиог дагалдуулна.

Мульти дэлгэцүүдийн аль нэг дээр газар орны зураглалыг харуулж пиктограммын дэлгэц дээр аюултай целийн байрлалыг харуулна. Нөгөө дэлгэц дээр бодит цагийн байдлын үеийн дүрсийн байдлыг харуулна.

Энэ үеэс систем нь гүйцэтгэх болон хамгаалалтын төхөөрөмжүүдэд гар ажиллагаагаар ажиллах боломжийг удирдах боломжийг олгох ба сонирхож байгаа обьект руугаа хулганын тусламжаар шилжих боломжтой байна.

Дэд системүүд нь төхөөрөмжийн дотоод байдлын талаар ялангуяа тэжээлийн байдлын талаар өндөр нарийвчлалтайгаар автомат горимоор хяналт тавих ба тусгай дэлгэцээр харуулна.

Цогцолборт төрөл бүрийн мэдрэгчүүдийг холбосон бол хяналтын эргэх системүүдийг автоматаар тухайн сэжигтэй чиглэлд чиглүүлэх, автоматаар бүртгэх, дагах ажиллагааг хангах боломжтой болно.

Дүрсийн локатор нь болж байгаа цагийн байдал, түүний дагуу операторааас хэрхэн ажилласан, багаж хэрэгслийн ажиллагааны байдлын талаар автоматаар бүртгэх ба тусгайлан кодолсон байдлаар хадгална.

Хадгалсан материалыг дүрсээр давтан харах боломжтой. Түүнчлэн нөхцөл байдлыг дээд шатны удирдлагын зүгээс шаардлагатай хэсгүүдийг дүрсийн ролик хэлбэрээрхарах боломжийг олгоно.

Энэхүү төхөөрөмж нь ОХУ-ын

хилийн шугамын хэдэн зуун км хэсэг дээр амжилттай ашиглагдаж маш өндөр үзүүлэлттэй болохоо харуулсан орчин үеийн ухаалаг систем юм.

Шигтгээ: "...Өнөө үед олон улсын террорист ажиллагаа, хил дамнасан гэмт хэргийн шинж чанартай янз бүрийн хэлбэрүүд ОХУ-ын хил дээр олонтаа гарах болсноор ХХБ-ыг зарчмын цоо техник, зэвсэглэлээр хангах шаардлага бий боллоо.

Одоо ОХУ-ын хилийн орон зайд учирч болох аливаа аюулаас урьдчлан сэргийлэх маш үр дүнтэй хариу арга хэмжээг авахуйц хамгаалалтын нэгдмэл цогцолбор системийг бүрдүүлээд байна.

ОХУ-ын ХАБА-ны ХХА-ны зүгээс ийм нөхцөл байдалд Хил хамгаалах байгуулгыг зайлшгүй шаардлагатай техник хэрэгслээр бүрэн хангах, улсын хилийн хэсгийг орчин үеийн техник хэрэгсэлээр иж бүрэн төхөөрөмжлөхөд онцгой анхаарч маш нягт нямбай хандаж байна.

Өнөөгийн байдлаар Хойд Кавказын хилийн хэсэгт улсын хилийг орчин үеийн техник хэрэгслээр хангах эхний шатны ажил дууссан бөгөөд энэ хэсэг дээр 100 гаруй шинэ техник хэрэгсэлийг нэвтрүүллээ.

Орчин үеийн инженер техникийн хэрэгсэл болон шинэ маягийн зэвсэглэлийн хүчээр хилийн манааг удирдах, цагийн байдлын мэдээлэл цуглуулах, солилцох,хүлээн авах , боловсруулалт хийх, иж бүрэн автоматжуулснаар хилийн анги, салбаруудын алба- байлдааны ажиллагааг хангах нөхцөл үндсэндээ бүрдлээ.

Удирдлагын автоматжуулсан ийм системийг зөвхөн хуурай газрын хилийн хэсэгт нэвтрүүлээд зогсохгүй тэнгис, далайн усан хилийн хэсэгт ч нэгэн адил нэвтрүүлэх болно.

Энэ систем нь төрөл бүрийн мэдээлэл дамжуулах хэрэгсэл болох цахилгаан дуран, дохиололын, радиолокацийн, чичирхийллийн, дулаан мэдрэгч төхөөрөмж, бусад олон төрлийн төхөөрөмжүүдээс бүрдэж байгаа бөгөөд мэдээлэл хүлээн авах эх булаг нь ОХУ-ын БХЯ, ХААЯ,ЗТЯ, ОБЯ зэрэг бүхийл байгууллагын хяналтын системүүдээс шаардлагатай мэдээллийг хүлээн авах болон тэдгээрт холбогдох бүрэн боломжтой болно.

Зохион бүтээх болон туршилтын төслийн хүрээнд хяналт ажиглалтын автомат систем /ХААС/, Радиолокаци дурангийн хяналтын хөдөлгөөнт цогцолбор /РДХХХ/, усны мандал хилийн хэсгийг хянах дулаанаар мэдрэх цогцолбор /РДМХЦ/ -уудыг цоо шинээр бүтээлээ.

Түүнчлэн өндөр бүтээмжтэй, ашиглалтын зардал, өөрийн өртөг хямдтай тоон өгөгдөл бүхий РЛС, туулах чадварыг нэмэгдүүлсэн тээврийн хэрэгслүүд, цас, намгийг туулах газар сайгүй явагчууд, дулаанаар мэдрэх техникүүд, хяналт ажиглалтын хэрэгсэл бүхий тусгай машин, нисэгчгүй нисэх аппарат, төрөл бүрийн радио системүүд нэвтэрч хил хамгаалалтанд ашиглагдаж эхэллээ.

Эндээс дүгнэлт хийхэд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь ОХУ-ын хилийн орон зайд гаднаас болон дотоодоос учирч болох аюулын эсрэг найдвартай системийг бүрдүүлэх, техникийн болон технологийн ололтыг хил хамгаалалтанд бүрэн нэвтрүүлэх, хүний хүчин зүйлийн оролцоог эрс бууруулах боломж бүрдэх болно.." гэж ОХУын ХХА-ны захирал 2010 2-р сард ОХУ-ын олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр мэдээлжээ.

Судлаачийн дүгнэлт:

Энэхүү нэн ухаалаг гэж болох цогцолбор төхөөрөмжүүд нь манай орны өргөн уудам нутгийн ихэнх хэсэгт маш үр бүтээлтэй ашиглагдах бүрэн боломжтой хамгийн орчин үеийн хамгаалалтын цогцолбор болох бөгөөд эрдэмтэн, мэргэжилтнүүд цаашид гүнзгийрүүлэн судлахын хамтаар дотооддоо хийж бүтээх аргыг эрэлхийлбэл туйлын ашигтай байх нь мэдээж.

Энэхүү материалыг хэвлэлд шилжих мөчид МУ-ын ХХБ-аас ОХУ-ын талтай хамтран хойд хилд нисэгчгүй нисэх аппаратыг хэдийнээ туршсанд маш баяртай байгаагаа дашрамд илэрхийлье.

Оюутолгой, Таван толгойн талаарх

Ц.Ганболд. ХЦДС-ийн СЭШЭ тэргүүн дэд захирал, доктор профессор, хурандаа

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ДҮРВЭГСДИЙН АСУУДАЛ

Сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр НҮБ-ын Дүрвэгсдийн дээд комиссарын газрын төлөөлөгчид, албаны хүмүүс Монгол улсад ирсэн, холбогдох албаны хүмүүстэй санал солилцож байгаа гээд л "дүрвэгсэд"-ийн талаар цөөнгүй мэдээлэл цацагдах боллоо.

дуулиантай мэдээллүүдийн шуугианд дарагдан хүн болгон анзааран уншиж ач холбогдол өгөхгүй байгаа мэт боловч "дүрвэгсдийн" талаарх асуудлын мөн чанарыг ойлгодог хүмүүсийн хувьд төдийгүй Монгол улсын үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс бол анхаарахгүй өнгөрөөж болохгүй асуудал юм.

Өнөө үед дүрвэгсдийн асуудал дэлхий дахинд тэр тусмаа Азийн бүс нутагт улам хурцдаж байна. Одоогоор дэлхий дээр 43 сая орчим дүрвэгсэд байгаагаас хил залгаа ОХУ-д гэхэд 800000 хүн эх орноосоо дүрвээд байгаа аж. Хөрш хоёр их гүрний дотоод улс төрийн байдал хурцадснаас эдгээр орнуудаас угсаа гарал, хэл, соёл нэг монгол угсааны үндэстнүүд, мөн тэрчлэн гуравдагч орноос ялангуяа Хятадаар дамжин Хойд Солонгосоос дүрвэгсэд орж ирэх магадлал өндөртэй. Дэлхийн II дайны дараа дүрвэгсдийн асуудал онцгой хүндэрч, 1950 онд Дүрвэгсдийн дээд комиссарын газрыг байгуулсан.

Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенцийг НҮБ 1951 онд баталсан бөгөөд энэ конвенцид дэлхийн 121 улс нэгдээд байна. Манай улс энэ конвенцид одоогоор нэгдээгүй бөгөөд ер нь Азийн орнуудаас нэгдэж орсон улс орон цөөхөн байдаг. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3-р зүйлийн:

3.1.2.3 Гадны дүрвэгсэд олноор хил даван орж ирэх, гэнэтийн хяналтгүй нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх бэлэн байдлын тогтолцоог бүрдүүлж, эрх зүй, улс төр, дипломатын цогц арга хэмжээ авна.

3.1.3.5. Гадаадын иргэн, харъяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшинг хадгалж, бүртгэл, мэдээллийн тогтолцоо, эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.

3.2.1.9. Дотооддоо хөдөлмөрийн зах зээлээ хамгаалж, иргэдээ ажлын байраар найдвартай хангах замаар ядуурлыг арилгах тууштай бодлого хэрэгжүүлнэ гэж заасан. Гаднаас Монгол улсад орж ирсэн дүрвэгсдийн асуудлыг ямар аргаар яаж шийдвэрлэх вэ?, хүлээж авах юм уу? Эсвэл улсын хилээр хэрхэн буцааж гаргах вэ ? гэсэн асуудлууд гарч ирнэ

1998 онд Бээжин хотод хуралдсан Дүрвэгсэдийн асуудлаархи олон улсын бага хурлаас гаргасан зөвлөмжид "Хилээр орж ирсэн дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэхдээ юуны өмнө тэдэнтэй уулзан ярилцаж, тэдний зорилго, санал бодлыг сонсох хэрэгтэй. Ялангуяа тэдний удирдагч нартай ярилцаж зөвшилцөх нь илүү үр дүнтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд ач холбогдолтой болно" гэж заасан байдаг. Олон улсын практикаас харахад улсын хилээр цөмрөн орж ирсэн дүрвэгсдийг улсын хилд ойрхон удаан хугацаагаар байлгах нь тэдний аюулгүй байдал ба тухайн улсын тусгаар тогтнолд тодорхой хэмжээний аюул занал учруулдаг. Учир нь дүрвэгсдийн араас тэднийг буцааж авчрах зорилгоор зэвсэглэсэн бүлэг тухайн улсын зэвсэгт хүчний анги, салбарууд орж ирж улмаар зэвсэгт мөргөлдөөн ч гарч болдог магадлалтайг үгүйсгэж болохгүй. Дүрвэгсэд,цагаачдыг хүлээж авах, суурьшуулах нь ихээхэн эмзэг асуудал бөгөөд хэд хэдэн үндсэн аюулыг бий болгодог.Тухайлбал:

1. Нийгмийн давхарга,үндсэн хүн ам, үндэстэн, яастнуудын бүтцэд

өөрчлөлт оруулж, улмаар тэдний зүгээс үндсэрхэх, гадуурхах, үзэн ядах, хэт даврах үзлийг дэвэргэх хөрс суурь болдог. Тэд үндэс угсаа, хэл соёл, арьс өнгө, шашин шүтлэгээрээ үндсэн хүн амаас ялгаран нэгдэж тусгаарлан олон жилийн турш төлөвшүүлж бий болгосон ардчилсан нийгмийн үнэт зүйлсийг үгүй болгох.

2. Үндсэн хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, хангалтын тогтолцоонд өөрчлөлт оруулдаг. Тодорхой мэргэжилгүй, хямд ажиллах хүчний урсгал, хөрөнгө чинээ, амьжиргааны түвшин, баян хоосны ялгааг улам бүр тодруулж улмаар нийгмийн давхаргын ялгарал үүсгэж улс орны улс төрийн тогтворгүй байдлыг бий болгоход нөлөөлдөг.

3. Гэмт хэргийн гаралт, эрүүгийн нөхцөл байдлыг хүндрүүлэхэд ихээхэн нөлөөтэй Тухайлбал: аллага хядлага явуулах, төр засгийн удирдлагыг булаан авахыг оролдох, босого, үймээн дэгдээх гэх мэт.

4. Тухайн улсын дотоодын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал улсын хилийн халдашгүй дархан байдлыг алдагдуулах, " гарал үүсэл, удам угсаа нь тодорхойгүй хүмүүс " учраас санаатай ба санамсаргүйгээр улсын хилийн ач холбогдлыг бууруулах, улс орны нэр хүндийг унагах, хууль ба хууль бус аргуудаар эрх ашгаа хамгаалах оролдлогуудыг хийх. Үндэс угсаа, шашин шүтлэгээрээ нэгдэж үүндээ хэт үнэнч бүлэглэлүүдийн эсрэг тухайн орны хууль үйлчлэх боломжгүй, хүчгүйдэх болдог. Үүний жишээг өнгөрсөн жил Франц, Герман болон Европын бусад орнуудад болсон дүрвэгсдийн үймээн самуун сургамж боллоо. Ялангуяа мусульман шашинт дүрвэгсэд, цагаачдын бөөгнөрөл тухайн хүлээн авсан улс орондоо олон сөрөг үр дагаврыг авчирч, тэдний өмнө хүчин мөхөсдөх болов. Одоо АНУ-д 10 сая гаруй, Францад 6 сая, Германд 3,5 сая, Англид 1,5 сая, Японд 1 сая гаруй мусульман шашинт дүрвэгсэд амьдарч байгаа аж. Тэдний ихэнх нь шашин, омгийн зохион байгуулалттай нийгэмдээ дассан, боловсролгүй, хүн төрөлхтний нийтлэг соёл иргэншил, хууль ёсны ойлголтгүй хүмүүс юм. Ойрын 20 жилд Баруун Европын аль нэг орон задарч бутрах нь гарцаагүй бөгөөд үүнд Дундад Азийн орнуудаас бөөн бөөнөөрөө дүрвэн очиж буй мусульман шашинтнуудын нөлөө асар их байх юм гэж НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга Пан Ги Мун "Исра" сонинд өгсөн ярилцлагандаа цохон дурьдсан.

Монгол улсын хувьд гадны дүрвэгсэд, цагаачдыг хүлээн авч сууршуулж байсан туршлагагүй бөгөөд энэ асуудал, аюулаас хол хөндий байсан улс бөгөөд хязгаар нутгаасаа төв рүүгээ шилжин сууршиж буй дотоодын шилжилт хөдөлгөөнөө ч зохицуулан шийдвэрлэж чадахгүй байгаа улс шүү дээ.

Өнгөрсөн жилүүдэд Хятадын зүүн хойд мужууд дахь Хойд Солонгосын дүрвэгсдийн лагериас Хятадуудад мөнгө өгөн зуучлуулж Монгол улсын хилийг зөрчсөн хэсэг бүлэг Солонгосын иргэд хил зөрчигчдийн багаахан хэсэгт яаж дарамтлуулав, ямар хохирол хүлээв, ямар хүндрэл амсаж байлаа, энэ бол зөвхөн зах зух нь л байлаа. Албан ёсоор улсын хилээрээ нэвтрүүлсэн, Монголд зөвшөөрөлгүй сууршиж үлдсэн Хятадын хар ажилчдаа ч бүртгэж, хянаж, хариуцлага тооцож, хөдөлмөрийн зах зээл, ажлын байраа тэдний хууль бус үйлдлээс өөрсдийн иргэдээ ч хамгаалж чадахгүй байна.

1951 оны Конвенци ёсоор хэрэв дүрвэгсдэд зориулан илүү тааламжтай нөхцөл олгохгүй бол тэдэнд гадаадын иргэдийг нэгэн адил эрх эдлүүлнэ. Түүгээр барахгүй анхан шатны боловсрол эзэмших, хөдөлмөрийн хөлс авах зэрэг зарим эрхийн хувьд өөрсдийн иргэдтэй адилтгаж үзнэ. Улсын хил нэвтрэн гарахад зориулан тэдэнд зорчин явах үнэмлэх бичиг баримт олгодог байна. Конвенцид оролцогч гүрнүүд дүрвэгсдийг эх оронд нь буцааж болохгүй, харин тэд нарыг шингэн ижилсэх, харъяа болох явдлыг бололцоогоороо хөнгөвчлөх үүрэг хүлээдэг билээ.

Ийм олон нөхцөл байдлуудыг тооцвоос Монгол улс нь НҮБ-ын 1951 оны Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенцид нэгдэн орох асуудалд нухацтай хандах нь чухал юм.

Ийм далд эдийн засагт хар тамхи

П.Даш МОУА-ийн академич, доктор, профессор

ОЛОН УЛСЫН ТЕРРОРИЗМ, ТҮҮНТЭЙ ХИЙХ ТЭМЦЛИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

Даяарших үйл явцтай холбоотойгоор олон улсын терроризмын тогтолцоо бүрэлдэн бий болсоор байна. Зөвшилцөх, нэгдэх үйл явцын үр дүнд бүрэлдэн тогтсон Дэлхий даяар үйл ажиллагаагаа явуулах зорилготой төрөл бүрийн бүтэц байдгийн нэг нь олон улсын террорист бүлэглэл юм. Энэхүү террорист бүлэглэл нь тодорхой хөрсөн дээр буюу улс төр, эдийн засгийн тодорхой бааз суурь, дэмжлэгтэйгээр байгуулагддаг байна. Террорист үйл ажиллагаа нь маш нууцаар зохион байгуулагдаж явагддаг тул түүний гол бааз суурь нь далд эдийн засаг дээр тулгуурласан байдаг.

болон зэвсгийн наймаа, захиалгат аллага, мөнгө угаах үйл ажиллагаа зэрэг зохион байгуулалттай гэмт хэрэг гол байр суурийг эзэлж байна.

Дээрх зохион байгуулалттай гэмт хэрэг дэлхий нийтийг хамарч гэмт хэргийн бүлэглэл нь аливаа улсын төрийн байгууллагын тогтолцоонд гүнзгий шургалах болжээ.

Зохион байгуулалттай гэмт хэргийн бүтэц төрийн тогтолцоонд авилга, хээл, хахуулиар дамжин нэвтрэн орж байна.

Өөрөөр хэлбэл авилга хээл хахууль нь төрийн өндөр албан тушаалтныг гэмт бүлэглэлтэй холбож өгөх гүүр болж байна.

Ийнхүү төрд нэвчин орсон гэмт бүлэглэлийн дархлааг улс төрийн сонгууль бий болгодог.

Улс төрийн сонгууль нь төрийн албан хаагчдийг мэдлэг, чадвар, дадлага, туршлагаар нь бус улс төрийн сонгуульд оролцсон байдлаар нь эсвэл улс төрийн болон хувийн ашиг сонирхолын шалгууруар томилох боломжийг олгодог тул гэмт бүлэглэлийн идэвхтэй гишүүдийг төрийн албанд шургалуулж тодорхой албан тушаалд дархлаажуулдаг.

Нэгэнт төрд нэвтрэн орж, дархлаажсан гэмт бүлэглэл, түүний гишүүд төрийн механизмыг ашиглан террорист бүлэглэлтэй хамтран үндэстэн дотроо болон үндэстэн дамнасан ажиллагаа явуулах, үйл ажиллагааг нь дэмжих, санхүүжүүлэх бодлого явуулах замаар олон улсын терроризмыг бий болгодог байна.

20 дугаар зууны 2 дахь хагасаас террорист байгууллагууд олноор байгуулагдаж, идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд судлаачдын хийсэн дүгнэлтүүдээс үзэхэд тэд ойролцоогоор 3 жил оршин тогтноод нэг бол шоронд орж, нэг бол устгагдаж байжээ.

Гэтэл хангалттай санхүүгийн боломжтой, ивээн тэтгэгч байгууллага эсвэл ивээн тэтгэх улс оронтой бол удаан хугацаагаар оршин тогтнодог нь "Аль-Каида" зэрэг зартай террорист бүлэглэлийн үйл ажиллагаанаас тодорхой харагдаж байна.

Терроризм гэж нэрлэгдэх террористуудын бодлого, үйл ажиллагаа, түүний дотор олон улсын терроризмыг танин мэдэж, түүнтэй тэмцэхийн тулд терроризм гэж чухам юу болох, түүний үүсэж бий болох шалтгаан, нөхцөл, зорилго, үйл ажиллагааны талаар нарийн судлаж мэдсэний үндсэн дээр түүнтэй тэмцэх аргаа тодорхойлох нь арга зүйн хувьд зөв гэдэгтэй хүн бүхэн санал нийлнэ гэдэгт эргэлзэхгүй байна.

Эртний түүхээс үзвэл манай тооллын 1-р зуунд эртний Ромын "Иудеягийн бүлэглэл" гэх террорист бүлэглэл бий болж еврейн язгууртнуудын

төлөөллийг алж устгах ажиллагаа явуулж байжээ. Тэдний зэвсэглэл нь хутга байсан бөгөөд хутгаар хүний амь насыг бүрэлгэх дадлага сургуулийг хийж байсан тухай мэдээлэл байдаг.

Тэгвэл дундад зууны үед алан хядах ажиллагааны арга хэрэгсэл улам боловсронгуй болж өргөн уудам нутаг дэвсгэрийг хамарч, удаан хугацаагаар үргэлжлэх болов. Тухайлбал, 1090-ээд оны үед "Хашашаинуудын бүлэглэл" гэж нэрлэгдсэн террорист бүлэглэл Газар дундын тэнгэсээс Персийн булан хүртэл өргөн уудам нутагт алан хядах ажиллагаа явуулж олон зуун хаад, ноёд /султан/, цэргийн дарга нар, шашины зүтгэлтнүүдийг устгаж тухайн бүс нутгийн улс төрийн нөхцөл байдал, геополитикийг өөрчлөхөд хүргэж байжээ. Тэрээр 12-р зууны дунд үед Монголчуудад бут цохигдон устсан юм.

Тэд хар тамхи, мансууруулах бодис тухайлбал хар тамхины нэгэн төрөл болох "гашиш" татаж мансууран алан хядах ажиллагаагаа явуулдаг байснаас "хашашаин", европ дуудлагаар "ассассинов", Англиар "hashishin", Франц дуудлагааг "Assassin" тэр нь орчин үед Англиар "улс төрийн аллага", хөлсний алуурчин гэсэн утгатай "Assassin", "Assassination" гэдэг үгнүүд болж хувирчээ. Энэ нь тухайн үеийн улс төрийн нөхцөл байдалд нөлөөлөөд зогсоогүй улс гүрний хэл соёлд хүртэл нөлөөлснийг харуулж байна.

Шинэ үеийн террорист ажиллагааг 18-р зуунаас эхлэн үечлэж үзвэл 18-р зуунд францад, 19-р зуунд Орос, европ, улмаар Америкт өрнөсөн хувьсгалт үйл явцтай холбоотойгоор, 20-р зууны эхэн ба дунд үед үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн болон колоний эсрэг хөдөлгөөнтэй холбоотойгоор, 1970-аад онд "шинэ зүүний үзэлтнүүд"-ийн үйл ажиллагаатай холбоотойгоор, 1970-аад оноос хойш даяршилтайгаар холбоотойгоор явагдаж байна гэж судлаачид үздэг байна.

1960-аад оноос хойш 40 жилийн хугацаанд гарсан террорист үйл ажиллагааг задлан шинжилж, нэгтгэн дүгнэж үзвэл аливаа тэмцэлд хүчин мөхөсдсөн бүлэглэл, хөдөлгөөн, үндэстэн өөрийн зорилгодоо хүрэхийн тулд гол төлөв хүчирхэг гүрнүүдэд өөрсдийн үзэл суртал, бодлогоо тулган хүлээлгэж, хүлээн зөвшөөрүүлэх, тэдний оролцоогүйгээр дотоодын асуудлаа шийдвэрлэх болон өөрийн үйл ажиллагаагаа санхүүжүүлэх эх үүсвэрээ олох зорилгоор дараахь ажиллагаануудыг явуулж байжээ. Үүнд:

1) Гадаад оронд суугаа дипломат ажилтнуудынх нь эрх ямбанд халдах, тэднийг устгах

2) Гадаад оронд амьдарч байгаа иргэдийг нь бөөнөөр нь устгах

3) Иргэдийн биеэ хамгаалах, аюултай нөхцөл байдлаас зугатаж гарах боломжгүй нөхцөл байдлыг ашиглан тэднийг олноор нь барьцаалах, амь насанд нь занал хийлэх, устгах

4) Аль болох бага хүч хэрэгслээр их хэмжээний хохирол учруулах /эдийн засаг, түүх, соёл, техник, технологи, иргэдийн амь нас эрүүл мэнд зэрэгт/

5) Тухайн нийгэм, улс, үндэстний үнэт зүйлийг устгах гэх мэт үйл ажиллагаа явуулдаг байна.

Энэ нь тухайн улс, үндэстний төр болон иргэдэд нийгмийн сэтгэл зүйд хүчтэй нөлөөлөхүйц айдас хүйдэс төрүүлэх, дарамт шахалтанд оруулах, замаар террорристуудаас болгоомжлон тэдний санаа бодол, эрх ашигт нийцсэн бодлого, шийдвэрийг Олон улсын байгууллага, тухайн улсын төр, засгаар гаргуулах гэсэн оролдлого юм.

Уг үйл ажиллагаагаа явуулахад тохиромжтой объект гэж:

a) Гадаадад суугаа дипломат ажилтнууд, элчин сайдын яам, дипломат төлөөлөлгдийн газар,

b) Олон улсын байгууллага, тэдний ажилтнууд

c) Ганц хүний үйлдлээс бүхэлдээ сүйрч болох олон хүн зорчдог тээврийн хэрэгсэл /нисэх онгоц, галт тэрэг, автобус, метро гэх мэт/

d) Олон хүн нэг доор цуглардаг худалдааны болон олон нийтийн арга хэмжээ зохион байгуулагддаг газар,

нисэх буудал, галт тэрэгний зогсоол, метроны станц, орон сууц зэрэг газрууд

е) Улс, үндэстний түүх, соёлын үнэт зүйл болсон барилга, байгууламж,

f) Хүн амын амин чухал хэрэглээ болсон ус, цахилгаан, хийгээр хангах байгууламж

g) Төр ба иргэний байнгын халамж болон анхаарлын төвд байдаг эмнэлэг, сургууль, гэр бүлийн гишүүдийн сэтгэл зүйд амь нас, эрүүл мэнд нь хамгийн эмзэг тусдаг, тэнд олноороо нэг дор байрлаж байгаа хүүхэд, эмэгтэйчүүд, өвчтөнүүд зэргийг үздэг байна.

Сүүлийн 40 жилд халдлагад өртсөн объектуудын нэр төрлөөр нь авч үзвэл, нийт халдлагад өртсөн объектуудын:

- Дипломатууд, дипломат төлөөлөгчдийн газар - 16%
- Эмнэлгийн ажилтан, өвчтөн сургуулийн хүүхдийг барьцаалж, амь насыг нь хохироох – 10%
- Нисэх буудал дэлбэлэх, нисэх онгоц барьцаалах замаар олон хүний амь нас бүрэлгэх – 24%
- Галт тэрэг, метро, автобус, метро станц, галт тэрэгний буудал дэлбэлж, иргэдийг олноор нь устгах – 28%
- Худалдааны төв, бусад олон нийтийн газрыг дэлбэлэх байдлаар иргэдийг олноор нь устгах – 22% -ийг тус тус эзлэж байна.

Энэ бүхнээс үзэхэд Олон улсын терроризм гэдэг нь хүчирхэг улс гүрнээс шашны болон эрх ашгийн нэгдэлтэй бүлэг, хөдөлгөөн, үндэстний талаар явуулж байгаа улс төрийн бодлогыг тэд эсэргүүцэн, хүчирхэг гүрнүүдэд өөрсдийн үзэл суртал, бодлогоо тулган хүлээлгэж, хүлээн зөвшөөрүүлэх, тэдний оролцоогүйгээр дотоодын асуудлаа шийдвэрлэх болон өөрийн үйл ажиллагаагаа санхүүжүүлэх эх үүсвэрээ олох зорилгоор явуулж байгаа үндэстэн дамнасан алан хядах, хорлон сүйтгэх бодлого, үйл ажиллагааны нийлбэр юм.

Олон улсын терроризм нь дараахь онцлогтой байдаг:

- Бодлого үйл ажиллагаагаа чөлөөтэй хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх зорилготой байдаг.
- Үйл ажиллагаагаа урьдчилан нарийн төлөвлөсөн байдаг
- Ямагт хүч хэрэглэдэг
- Эсрэг талдаа учрах хор уршгийг урьдчилан тодорхойлсон байдаг
- Гүйцэтгэгч ба гишүүд нь нарийн зохион байгуулалтанд орсон, тодорхой удирдлагын доор үйл ажиллагаа явуулдаг.

Дээрх онцлогийг мэдсэн байх нь түүнтэй тэмцэх аргыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм. Түүнээс гадна Олон улсын терроризм улам нарийн төвөгтэй, харгис шинжтэй болж байгаа нь дэлхий нийтийн сэтгэлийг түгшээх боллоо. Тухайлбал,

- 1990-ээд оны дунд үеэс амиа золиослох байдлаар террорист ажиллагаа явуулах болсон нь үзэн ядалт дээд цэгтээ хүрч терроризм улам харгис шинжтэй болж байгааг харуулаад зогсохгүй, түүнээс хамгаалахад улам төвөгтэй болж байна.
- 21-р зуун гарсаар нэг удаагийн террорист халдлагаар хэд хэдэн объектод халдах болсон байна.
- Өшөө хорсол, үзэн ядалт нь терроризмын зорилгод ч нөлөөлж байна. Тодорхой бүлэглэл, хөдөлгөөн, үндэстнүүд өөрийн эрх, эрх чөлөө, ашиг сонирхолоо хамгаалахын тулд террорист үйл ажиллагаа явуулдаг байсан бол сүүлийн үед өөрсдийнхөө амийг золиослон гэм зэмгүй иргэдийг бөөнөөр нь хоморголон устгах болсон нь цаашид улс үндэстнийг бүхэлд нь хүйс тэмтрэхэд бэлэн байгааг харуулж байна. Иймд цөмийн терроризмын аюул гарахыг үгүйсгэх аргагүй боллоо.
- Террорист ажиллагааг захиалдаг болсон байна. Энэ тухай мэдээллийн "викилеакс" сайтад баримт нотолгоотой бичсэн байдаг.

Лондонгийн стратеги судлалын хүрээлэнгийн Ойрхи дорнодын тэнхимийн эрхлэгч Стифен Уиллиамс "...шууд хэлэхэд тэрхүү алан хядах ажиллагааг улстөрчид дэмждэг. Ингэж гэмээнэ тэдний ажлаа хийж байгаа нь

иргэдэд харагдана" гэсэн нь террорист ажиллагааг захиалдаг гэсэн дээрхийг дүгнэлтийг бататгаж байгаа юм.

Тэрч байтугай зарим эх сурвалжийн мэдээлж байгаагаар Европын холбоо болон АНУ-д халдлага үйлдэхээр бэлтгэж байсан бүлэглэлийг Францийн тусгай албаныхан илрүүлж 12 хүнийг баривчлан шалгахад тэдгээр нь муслим шашинтай, Ливи гаралтай Франц иргэншилтэй иргэд байсан аж. Уг халдлагыг Европын холбоо Аль-Каида бүлэглэлд захиалсан гэжээ.

Энэ мэдээлэл хэдийгээр эргэлзээтэй ч гэсэн аливаа халдлагын дараа халдлагад өртсөн улс орны иргэд нэгдэж чаддагийг олон баримтаар нотолж байгаа нь зарим террорист ажиллагаа захиалгаар хийгддэг байхыг үгүйсгэх аргагүйд хүргэж байна.

2001 оны 9 сарын 11-ний халдлагын дараа АНУ-ын тухайн үеийн ерөнхийлөгч Жорж Буш ард түмэндээ хандан мэдэгдэл хийж эв нэгдэлтэй байж, олон улсын терроризмтай тууштай тэмцэхийг уриалсан. Ингэснээр америкийн ард түмэн Афганистан руу цэрэг илгээх Бушийн төлөвлөгөөг дэмжсэн бөгөөд Жорж Буш терроризмыг өөрийн улсдаа ашиггайгаар эргүүлж чадсан байна.

Мадрид хотын метронд 2004 оны 3 сарын 11 нд болсон халдлагад өртөж 100 гаруй хүн алагдсан. Энэ халдлагыг хойт Африкт байдаг Аль-Каида бүлэглэл үйлдсэн байдаг. Үүний дараагаар Испаний "баск", "каталон" гэх салан тусгаарлах үзэлтэй үндэстнүүд үйл ажиллагаагаа бараг л зогсоосон байжээ.

Дээрх жишээнүүдээс үзэхэд террорист ажиллагаа захиалгаар хийж болохыг харуулж байгаа билээ.

Энэ бүхнээс дүгнэж үзвэл олон улсын терроризм улам боловсронгуй болж, үйл ажиллагаа нь шинэ шинэ арга хэрэгслээр баяжсаар, улам бүр аюултай болсоор байгаа нь түүнтэй тэмцэх арга механизмаа боловсронгуй болгохыг шаардаж байна.

- Мэдээллийн эрин болсон 21-р зуунд мэдээллийн технологийн хөгжил олон улсын хэмжээнд улам хурдацтай тархаж, цаашдаач одоонийхоос ч илүүтэйгээр хөгжлийг тодорхойлогч хүч байх болно гэж судлаачид үзэж байна.

Терроризм болон үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэхэд мэдээллийн технологи онцгой ач холбогдолтой болохын дээр террорист халдлагад өртөх нэг чухал объект болж байна. Сүүлийн үед ихээр гарах болсон кибер гэмт хэрэг үүний нэг эхлэл гэж мэргэжилтнүүд үзэх боллоо.

Олон улсын терроризм улам нарийн зохион байгуулалтанд орж, үйл ажиллагаа нь өргөжин тэлж хамгийн харгис шинжтэй болж байгаатай уялдуулан түүнтэй хийх тэмцлийг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Үүнтэй холбогдуулан дараахь саналын дэвшүүлж байна.

Нэг. Терроризмтай хүчирхийллийн аргаар тэмцэхээс татгалзах

"Коммерсант" сонины 2004 оны 9 сарын 13-ны өдрийн 169/П (3008) дугаарт гарсан 1994-2004 онд болсон террорист халдлагад амь үрэгдэгсэдийн судалгаанаас үзэхэд АНУ-д 3228 хүн, ОХУ-д 2111 хүн, Изральд 1274 хүн тус тус амь үрэгдсэн байна.

Террорист халдлага үйлдсэн бүлэглэл, түүний толгойлогчийн нэрсийг үзвэл АНУ-д "Аль-Каида" бүлэглэл, ОХУ-д Чиченчүүд болон "Кавказын эмират" бүлэглэл, Изральд Палестинчууд ихэвчлэх террорист ажиллагаа явуулсан байна.

Энэ АНУ-аас Персийн буланд явуулсан ажиллагаатай, ОХУ-аас Чичений талаар явуулсан бодлоготой, Израилийн талаас Палестинтай хийсэн тэмцэлтэй шууд холбоотой болохыг харуулж байна.

Түүнчлэн АНУ-д олон улсын худалдааны төв болон Пентагоныг онгоц барьцаалан дайрсан 2001 оны 9 сарын 11-ны үйл явдлын дараагаар дэлхийн улс гүрнүүд Олон улсын терроризмтай хамтран тэмцэх хөдөлгөөн идэвхтэй өрнөж, АНУ – аас Ирак, Афганистанд цэргийн ажиллагаа явуулсан нь террорист

ажиллагааг бууруулж чадсангүй.

Үүнээс аливаа хүчирхийлэл хүчирхийллийг төрүүлдэг шигээ хүчирхийлэлийг хүчирхийллээр зогсоож болдоггүй гэсэн зүй тогтол харагдаж байна.

Террорист халдлагад байнга өртдөг том гүрний бодлого тодорхойлогчид үүнийг олж харж бодлого үйл ажиллагаагаа өөрчилж байгаа нь сайшаалтай хэрэг.

Тухайлбал, ОХУ-ын ерөнхийлөгч Д.Медведев саяхан Данийн радио нэвтрүүлгийн корпорацийн сурвалжлагчид өгсөн ярилцлагадаа: "Терроризм бол тэсрэх бөмбөг зүүсэн бүлэг хүмүүс биш юм. Энэ бол тодорхой байр суурийн багц. Тиймээс терроризмыг нийгэм, эдийн засгийн шинэчлэл эсвэл хүчээр арилгах аргагүй юм.

Дор хаяж дөрвөн чиглэлээр ажиллах ёстой. Үүнд:

1-рт. Боломжтой бүхий л хэрэгслээр террорист бүлгийн зартай төлөөлөгчтэй үргэлжлүүлэн тэмцэх хэрэгтэй. Хэд хэдэн тохиолдолд энэ цорын ганц боломж байна.

2-рт. Бид хууль ёс гэдэг үгийг хамгийн өргөн утгаар сэргээх ёстой. Зөвхөн хуулиар дэг журам тогтоож, Кавказд хэдэн зуунаар тогтсон отог, омгийхнийгоо өөд нь татах байдлаас ангижрахыг хүмүүст итгүүлэх шаардлагатай.

3-рт. Шашин – ёс суртахуунд түшиглэхгүйгээр энэ тэмцлийг явуулах аргагүй. Кавказын хүн амын шүтдэг лал, христосын шашинд өгүүлдэг ёс суртахууны талаарх төсөөлөл, мөн ёс суртахууны ерөнхий төсөөлөл үүнд багтана. Шашны үнэт зүйлийг ишлэх нь нэн чухал.

4-рт. Эдийн засгийг сэргээж, ажлын байрыг нэмэгдүүлж, Кавказын хүн амд амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх ёстой." гэжээ.

Өөрөөр хэлбэл террорист ажиллагаа явуулж байгаа бүлэглэл, хөдөлгөөн, үндэстний хөндөгдөж байгаа эрх, ашиг сонирхолыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг тууштай, шуурхай авч хэрэгжүүлэх замаар терроризм түүний дотор олон улсын терроризмыг хазаарлан барих ёстой гэсэн санааг дэвшүүлсэн байна.

Хоёр. Аливаа шашин, соёлд хүндэтгэлтэй хандах

Шашин нь түүнийг шүтэж байгаа үндэстэн, ястны итгэл үнэмшил, соёл, үзэл суртал нь байдаг. Иймд аливаа шашныг гадуурхах явдал нь тэр шашныг шүтдэг улс, үндэстний соёл, ёс заншил, итгэл үнэмшил, үзэл суртлыг үгүйсгэсэн хэрэг болох билээ.

9 сарын 11-ний үйл явдалтай холбогдуулан АНУ-д зарим хүмүүс Коран судрыг шатаах талаар дэлхий нийтийг цочирдуулсан мэдэгдэл хийж дуулиан тарьсан. Энэ талаар янз бүрийн шашинтны болон улс төрийн зүтгэлтнүүдийн хийсэн мэдэгдэл бүгд л "Терри Жонсийн мэдэгдэл нь Аль-Каида бүлгийн гишүүдийн гарт зэвсэг бариулж, эгнээндээ шинэ хүмүүс элсүүлж, шинэ алан хядах ажиллагаа үйлдэхэд өдөөсөн хэрэг боллоо" гэсэн санааг илэрхийлсэн байна.

Өөрөөр хэлбэл, шашны асуудалд хүндэтгэлтэй хандах ёстой гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн хэрэг юм.

Гурав. Терроризм, түүний дотор олон улсын терроризмын талаар дэлхий нийтээр нэгдмэл нэг ойлголтод хүрэх

Терроризмын талаар дэлхий нэгдсэн ойлголтонд хүрээгүй байна. Энэ нь олон улсын терроризмтай тэмцэхэд ихээхэн саад бэрхшээл учруулж байна.

Тухайлбал, нэг хэсэг нь эрх чөлөөний төлөө тэмцэгч гэж үзэж байхад нөгөө хэсэг нь түүнийг террористууд гэж үзэж байна. Үүнээс болоод өөрийн орондоо террорист ажиллагаа явуулсан этгээд өөр оронд улс төрийн орогнол авч байна.

Жишээ нь ОХУ-д террорист халдлага үйлдсэн Чечений зэвсэгт бүлгийн төлөөлөгчид Их Британид улс төрийн орогнол авч байна гэсэн мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж

байна.

Үүнээс үзэхэд хэнийг эрх чөлөөний төлөө тэмцэгч гэхэв, хэнийг алан хядагч гэхэв гэдэг талаар дэлхий нэгдсэн ойлголтонд хүрч асуудлыг шударгаар шийддэг болохгүй бол дэлхийн улс орнууд терроризмтай хамтран тэмцэх боломжгүй юм.

Дөрөв. Терроризмыг өөрийн орны улс төр, эдийн засгийн зорилгодоо ашиглахгүй байх

Түүнчлэн аливаа улс орон терроризмыг өөрийн орны улс төр, эдийн засгийн зорилгодоо ашиглахгүй байх механизмыг олон улсын түвшинд бүрдүүлэх шаардлагатай байна.

Өөрөөр хэлбэл террорист ажиллагааг захиалах боломжийг бүрэн хаах нь хүн төрөлхтний сайн сайханы төлөө хийж байгаа ариун үйлс болно.

Дээр дурдсан баримтуудаас үзэхэд террорист ажиллагааг өөрийн орны улс төр, эдийн засгийн зорилгодоо ашиглахын тулд захиалсан гэх баримт байхгүй боловч тийм боломж байгаа гэдгийг хариулж байгаа билээ.

Тухайлбал, Ирак АНУ тэргүүтэй 10 гаруй орны цэргийн хүч 7 жилийн хугацаанд үүрэг гүйцэтгэсэн. Тэдгээр нөлөө бүхий улсууд Иракийн дайнд зарцуулсан мөнгөө 5,5 дахин нугалж олсон тухай мэдээллийн "Викилеакс" сайтад тэмдэглэснийг анзаарахгүй өнгөрч болохгүй билээ. Судлаачдын дүгнэлтээр "томоохон улс гүрнүүд түүхий эдийн хомсдолд орох тусам тэдгээр улсад террорист халдлага олон гарна. Тиймээс тэд баялаг ихтэй ядуу буурай орнуудыг шалтгааны золиос болгох нь ихсэнэ. Үүгээрээ тэд терроризмын аюулаас улсаа аварч байна гэж ард иргэддээ ойлгуулдаг юм" гэж бичиж, мэдээлж байгаа нь дээрх санааг бататгаж байна.

Тав. Терроризмтай тэмцэх шинэ арга, механизмын эрэл хайгуул тасралтгүй явагдах ёстой.

Терроризмын бодлого, үйл ажиллагаа нь сүүлийн жилүүдэд улам боловсронгуй болж, өргөжин тэлж байгаатай уялдуулан түүнтэй тэмцэх арга хэлбэрийг өдөр тутам боловсронгуй болгох эрэл хайгуул хийж, шинэ шинэ арга механизмыг илрүүлэн гаргаж байхын дэлхийн улс төрийн нөхцөл байдал шаардаж байна.

Г.Дагважамц. МОУА-ийн академич тэргүүлэх профессор, доктор

МОНГОЛ УЛСЫН ЭРДЭС БАЯЛГИЙН ГЕОПОЛИТИК, ХӨРШ ГҮРНҮҮДИЙН ХҮЧИН ЗҮЙЛ

Хүн төрөлхтөн шинжлэх ухаан технологийн хувьсгалд тулгуурлан аж үйлдвэрийн нийгмээс мэдээлэлжиж, даяаршиж байгаа нийгэмд шилжиж буй, XXI зуунд Монгол улс дэлхий дээр хамгийн том газар нутагтай ОХУ, хамгийн олон хүн амтай БНХАУ хоёр их гүрний дунд оршиж, экспортыг дэмжих эдийн засгийг эрчимтэй хөгжүүлж, мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих стратегийг сонгосон.Монгол улсын асар уудам нутаг дэвсгэрийг геополитикийн болон геоэдийн засгийн өнцгөөс авч үзвэл тэр нь тус улсын тусгаар тогтнол, бие даасан оршнолын амин чухал баталгаа, тус улсын хөгжлийн үндсэн суурь болж байна. Монгол Улс XXI зууны эхэнд хосгүй их эрдэс баялгаараа хол ойрын улс гүрнүүдийн стратегийн анхаарал сонирхлыгтатах болов.

Эдүгээ дэлхийн уул уурхайн салбарт хамгийн их хөрөнгө оруулалт татсан арван улсын тоонд Монгол Улс багтсан юм. Дэлхийн уул уурхайн тэргүүлэх компаниуд Anglogold, BHP, Biliton, Camego, Rio Tinto, Mitsui Монголд үйл ажиллагаагаа явуулж байна.

Олон улсын хөрөнгийн корпорацийн мэдээлснээр Монгол Улсад ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 18 компани Торонто-ийн биржид хувьцаагаа гаргаж байна. Эдгээр компаниудын Монголтой хамааралтай хөрөнгийн хэмжээг 2,5 тэрбум доллар гэж тооцоолж байна.

Монгол Улсын уул уурхайн нөөц баялгийг нээн, ашиглах нь хэдийнээ Монгол Орос, Монгол Хятадын харилцааны тэргүүлэх чиглэл болоод байна.

Эдүгээ Монгол улсын уул уурхайн нөөц баялаг юуны учир гадаадынхны сонирхлыг татах болсон вэ?

Нэгдүгээрт; Монгол Улс геологийн газрын хэвлийн тогтцоороо эрдэс баялгийн нөөц ихтэй орон зай болох нь сүүлийн жилүүдийн геологи хайгуулын судалгаагаар нотлогдлоо.Монгол улсын газар нутгийн зөвхөн 30 орчим хувьд эдүгээ геологийн судалгаа хийсэн байгаа. Судалгаа хийгдсэн энэ хэсэгт л гэхэд "Оюу толгой", Таван толгой Эрдэнэт, Төмөртэй, Дорнод уран орд газрууд илэрч, олон улсын анхаарал татах боллоо.

Хоёрдугаарт; Монгол орны умарт, төв, өмнөт хэсгүүд өнгөт металийн хүдэржилтийн хувьд ихээхэн ирээдүйтэйд тооцогдож байна. Тухайлбал тус орны өмнөт болон умарт нутгуудаар зэс молибдений чиглэлийн хүдрийн томоохон ордууд илрэх магадлал өндөр, ОХУ Монгол Улсын хилийн зааг орчмын нутгаар өнгөт металын болон төмрийн хүдрийн галт уулын гаралтай хүдэржилтийн илрэлүүд тогтоогдсон байгаа. Мөн түүнчлэн нүүрс, газрын тос, жонш, фосфорит, алт, мөнгө, газрын ховор элементийн илэрц ордууд хил орчмын нутагт тулхүү олдож байна. Энэ нь зах зээлд ойр, тээврийн зардал хэмнэх зэрэг олон давуу талтайн дээр хөрш орнууд болох Орос, Хятадын харилцаанд эерэг болон сөрөг нөлөө үзүүлэх боломжтой юм.

Гуравдугаарт; дэлхийн зах зээл дээр өнгөт металл, эрчим хүчний түүхий эдийн үнэ асар огцом өсөн нэмэгдэж байна. Монгол Улсын экспортын гол бүтээгдэхүүн болох зэс, алт, цайрын үнэ 2006 оноос хойш огцом нэмэгдэж Лондонгийн металлын бирж дээр 1 тн зэс 1998 оноос хойш 6780 ам.долларт хүрч, 1 унци алт 649 ам.доллар болсон нь сүүлийн 25 жилийн рекорд өндөр үнэ байв. 1 тн цайр 3310 ам.долларт хүрэв. Өнгөт металлын эрэлтийн огцом өсөлтөд Хятад улсын эдийн засгийн өсөлтийн өндөр хурд (2005 онд 9,9%, 2006 онд 10,2%), аж үйлдвэр эдгээр жилүүдэд 18-20% өссөн/ ихээхэн нөлөө үзүүлж байна. Ийм болохоор ойрын ирээдүйд Монголын уул уурхайн салбрын олборлолт, экспорт, ялангуяа цайр, газрын тос, нүүрс зэрэг ашигт малтмалын үнэ тасралтгүй өсч экспорт нь нэмэгдэх магадлал өндөртэй байгаа.

Дөрөвдүгээрт; Монгол улсын улс төр, эдийн засаг, нийгмийн тогтвортой байдал, хууль эрхийн таатай орчин гадныхны анхаарлыг татаж байна. Монгол улс ардчилал, зах зээлийн тогтолцоонд амжилттай шилжиж буйн зэрэгцээ

дотооддоо шашин, омог, үндэстний зөрчил, терроризмын халдлагаас ангид харьцангуй тогтвортой, дөлгөөн тайван орон юм.

Түүнчлэн урд, хойт хоёр хөрш БНХАУ, ОХУ-тай найрсаг харилцаатай, түүхээс улбаалсан шашин үндэстний болоод газар нутгийн шинжтэй маргаан зөрчилгүй, гадаад орчим нь таатай улсуудын нэг болой.

Сүүлийн жилүүдийн байдлаас харахад дээрх хүчин зүйлүүдтэй уялдан Монгол орны эрдэс баялгийн ашиглалтыг тойрсон геополитикийн том өрсөлдөөн буй болчихоод байна. Монгол улсын энэхүү эрдэсбаялгийнгеополитикийн"тоглоомонд" үндсэн гурван "тоглогч" оролцох нь тодорхой болов. Эдгээр нь Монгол Улсын уул уурхайн салбарт урьд өмнө нь нэгэнт тогтоосон хяналт, ашиг сонирхолоо хэвээр хадгалан бэхжүүлэх, шинэ өрсөлдөгч орж ирэхээс ихээхэн болгоомжилж байгаа ОХУ, жил байтугай сар, өдрөөр эрдэс баялгийн эрэлт хэрэгцээ улам бүр өсч, эрчим хүч болоод аж үйлдвэрийн гол гол чухал түүхий эдийн хувьд гадаад зах зээлээс хараат болж буйн улмаас "үүцээ" задалж байгаа Монгол Улсыг улам бүр чухалчлан үзэх болсон БНХАУ, хэрвээ нөхцөл бололцоо, хууль эрхийн болоод үнийн таатай нөхцөл бүрдсэн тохиолдолд ашигт малтмалын баялаг нөөц, шинэ ордуудад хөренгө оруулахад бэлэн байгаа гуравдахь орны болон үндэстэн дамнасан уул уурхайн аврага том компаниуд болон ашигтай том ордны "эрэлд мордсон" уул уурхайн жижиг, дунд компаниуд болой.

Монгол Улсын эрдэс баялгийн геополитикт голлон үүрэг гүйцэтгэх хоёр хөрш БНХАУ, ОХУ-ын бодлого, үйл ажиллагаа, ашиг сонирхол чухам юунд чиглэж байна вэ?

Манай өмнөт их хөрш Хятад улсын эрчим хүчний болон аж үйлдвэрийн түүхий эдийн импорт жилээс жилд өссөөр байна. Хятад Улсын статистикийн мэдээгээр тус улс жилд 2,19 тэрбум тн нүүрс, 181 сая тн төмрийн хүдэр, 352 сая тн ган, 16,3 сая тн 10 төрлийн өнгөт төмөрлөг олборлодог, харин 126,8 сая.тн газрын тос, 275,2 сая. тн төмрийн хүдэр, 4,58 сая тн марганцын хүдэр, 3,02 сая.тн хром, 4,06 тн зэсийн хүдэр импортоор авсан байна. Ийм болохоор эрчим хүч болон аж үйлдвэрт нэн шаардлагатай эрдэс түүхий эдийн найдвартай эх үүсвэр олох: улс орноо тогтвортой хангах асуудал Хятад улсын төрийн бодлогын томоохон зорилтуудын нэг, улс орны нь эдийн засгийн ашуулгүй байдалтай холбоотой амин чухал эрх ашиг болоод байна. БНХАУ дотоодынхоо нөөц бололцоог нэмэгдүүлэхийн зэрэгцээ эрдэс түүхий эдийн гадаад эх үүсвэрээ бэхжүүлэх талаар' идэвхитэй ажиллаж байна. Юуны өмнө ' зрчим хүч, түүхий эдийн нөөц баялаг ихтэй орнууд, тухайлбал Монгол Улсаас гадна ОХУ, Казахстан, Чили, Австрали, Саудын Араб, Иран, Нигери, Венесуэл зэрэг орнуудтай харилцаагаа идэвхижүүлж байна. Ийнхүү дипломат бодлогын үр дүнд Хятадын уул уурхайн компаниудыг дэлхийн түвшинд хүргэх, юуны өмнө томоохон орд газруудад хөрөнгө оруулах, хувьцааны багцыг худалдаж авах, хамтарсан компаниуд байгуулах зэрэг чиглэлд хөрөнгө санхүү, хүч анхаарлаа төвлөрүүлж байна.

Сүүлийн жилүүдэд Хятадад газрын тосны CNPC, CNOOC томоохон компаниуд засгийн газрынхаа хүчтэй дэмжлэг, улсын зээлээр Индонез, Австрали, Венесуэл, Ангол зэрэг олон орны газрын тос, ибайгалийн хийн хувьцааг худалдан авах олон тэрбум долларын гэрээ байгуулсан байна.

CNPC 4.2 тэрбум доллараар Казакстаны газрын тосны ордыг Petrokazakstan компаниас худалдан авсан тухай хэвлэлээр мэдээлсэн. CNOC Нигерийн газрын тосны хувьцааны 45%-ийг 2.7 тэрбум доллараар авах гэрээ хийсэн. Харин АНУ-ын UNOCAL компанийг 18.6 сая доллараар худалдан авах санал тавьсан боловч үндэсний аюулгүй байдал болон Ази дахь нөлөөнд нь хохиролтой гэж үзээд Хятадад компаниа зарахыг АНУ зөвшөөрөөгүй тухай мөн хэвлэлд бичсэн.

БНХАУ хилийн чанад дахь эдийн засгийн үйл ажиллагаагаа идэвхжүүлэх, гадагшаа хөрөнгө оруулах, гадаадын томоохон компани болон уул уурхай, газрын тос, хийн том ордуудыг худалдан авах болсны үндэс нь тус улсын валютын нөөц зузаарч байгаатай холбоотой. Хятадын ардын банкны мэдээлснээр Хятад улсын валютын нөөц эдүгээ 1 трилион ам.доллараас давжээ.

Хятад улс бол Монголын хамгийн том хөрөнгө оруулагч бөгөөд сүүлийн жилүүдэд Хятадын хөрөнгө оруулалт уул уурхайн чиглэлээр эрс нэмэгдэж байна. БНХАУ-ын "Доншен газрын тос Монгол" Австралийн "Рок ойл" компанийг 2003 оны 3 дугаар сард, АНУ-ын "Соко Тамсаг Монголиа Л.ЛС", компаний гэрээлэгчийн эрхийг БНХАУ-ын "Петро Чайна Ласин Тамсаг Монгол"-д 2005 оноос 100% шилжүүлэн өгсөн.

Ингэснээр Монголын газрын тосны идэвхтэй хайгуул, олборлолт хийж буй орд газрууд бүгд Хятадын компаниудын мэдэлд байгаа. Сүүлийн жилүүдэд ОХУ-ын эдийн засгийн хөгжил нэлээд тогтворжиж хөгжлийн хурд нь хөгжингүй орнуудаас дээгүүр, хятад, Энэтхэгээс арай доогуур түвшинд байна.

ИТАР-ТАСС агентлагийн мэдээлж буйгаар ОХУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүн жилээс жилд өссөөр байгаа аж. Өнгөрсөн жилүүдийн өсөлтийн гол хүчин зүйл нь газрын тос, хийн эрчимтэй хөгжил, рублийн ханшийн гүйцэтгэх үүрэг нөөц бололцоо байсан.

Гэтэл тэдгээрийн нөөц шавхагдаж байна. Иймд хөгжлийг түргэтгэх гол гарц нь хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, эдийн засгаа төрөлжүүлэх явдал болсон. Ойрын жилүүдэд газрын тосны үнэ огцом өсч, эрчим хүчний эх сурвалжийн төлөөх дэлхийн хэмжээний өрсөлдөөн улам ихсэх хандлагатай болов. ОХУ нь дэлхийн байгалийн хийн нөөц 26.7%, олборлолтын 22.1%, экспортын 29%, газрын тосны нөөцийн 6%, олборлолтын 11,4% экспортын 9,3%-ийг эзэлдэг томоохон нийлүүлэгч бөгөөд эдүгээ эрчим хүчний дипломат бодлого явуулж байна. Стратегийн өрсөлдөгчийн зарим нь ОХУ-ын нөлөө ихсэхээс ихэд болгоомжилж, зарим нь Оростой харилцаагаа улам нягтруулахыг эрмэлзэж байна.

ОХУ-ын 1990 оноос хойш Монголд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харьцангуй бага байсан боловч Монгол Улсын уул уурхайн гол үйлдвэрүүд болох "Эрдэнэт", "Монросцветмет" компаниудад гол хөрөнгө оруулагч хэвээр байж, манай улсын түлш шатахууны импортыг бараг 100% нийлүүлдгийн хувьд цаашдаа ОХУ-ын хөрөнгө оруулалт уул уурхайн салбарт нэмэгдэж байгаа зэргээс харахад ОХУ-ын Монгол дахь ашиг сонирхол, нөлөө жинтэй хэвээрээ байна гэж үзэх үндэстэй.

Монгол Улсын эрдэс баялаг тойрсон геоэдийн засаг, геополитикийн өрсөлдөөн нь Монгол орон, түүний ард түмний сайн сайхан байдал, хөгжил цэцэглэлт, аюулгүй байдалд ямар нөлөө үзүүлэх вэ?, Монголын ард түмэн тэрхүү өрсөлдөөнд хэрхэн оролцох вэ? Ашиг хонжоо бий юу? Аюулгүй байдлаа алдах уу? гэх мэт асуултууд анхаарал сонирхол татах нь мэдээж.Монголчууд газрынхаа хэвлийд байгаа ашигт малтмалаа олборлож авах нь дотоод гадаадын цөөн хэдэн уул уурхайн компаний эрхэлдэг, эдийн засаг, экологийн асуудал тэдий биш харин Монголын гадаад харилцаа, аюулгүй байдлын хамгийн чухал. хамгийн эмзэг асуудал болох нь улам бүр тодорч байна.

Гадаад ертөнцөөс тавих болсон энэхүү анхаарал, сонирхол, өрсөлдөөний эерэг сайн тал нь Монгол орны уул уурхайн салбарын нэр хүнд өсч, гадаадын хөрөнгө оруулалт тал бүрээс орж нэмэгдэн улс орны эдийн засгийн чадавхи дээшилж ард түмний аж байдал сайжрах явдал байх болно.

Гэвч байгалийн нөөц ялангуяа эрдэс баялаг улс орон ард түмнийг шууд баян чинээлэг болгож хөгжил цэцэглэлт авчирдаггүй болохыг Монгол улсаас өмнө энэ замыг туулж өнгөрүүлсэн улс орнуудын гашуун туршлага, сургамж харуулж байна. Энэ асуудлыг олон орны нэртэй эрдэмтэд, судлаачид нягтлан судалж бүтээл туурвилдаа бичиж үлдээжээ Нобелийн шагналт Америкийн нэрт эдийн засагч Жозеф Стиглиц улс орны баялаг сөрөг үр дагаварт хүрэх хэд хэдэн хүчин зүйл байдагтухай онцлон тэмдэглэсэн байна. Түүнийг томъёолвол:

1. Улс орнууд баялаг гэж нэрлэдэг зүйл дээрээ мэхлүүлдэг.

2. Баялгаас цөөн хүмүүс ашиг хонжоо олж, түүнийгээ өөрийн болгохоор элдэв арга, хэрэгслэлийг янз бүрийн хэлбэрээр ашигладаг. Үүний үр дүнд нийгэм бүхэлдээ хохирол амсдаг.

3. Байгалийн баялаг ихтэй улсууд түүнээсээ хэт хамааралтай болж, үнийн тогтворгүй байдал үүсдэг, энэ нь эдийн засгийн ихээхэн хор уршигтай.

4. Олон улсын банк санхүүгийн байгууллагууд байдлыг улам бүр дордуулдаг.

5. Голланд өвчинд нэрвэгддэг. Энэ нь баялгийг засгийн газрууд зөвхөн ойр зуурын нэр хүнд, ашиг хонжоо олохоод ашигладаг, үүний үр дүнд баялаг урт хугацааны стратегийн тогтвортой хөгжилд хүргэдэггүй гэсэн дүгнэлт хийсэн байна.

Байгалийн эрдэс баялгийн ашиг орлогын хуваарилалтыг ил тод, шударга, хуулийн дагуу шийдвэрлэхгүй бол ялангуяа стратегийн чухал туухий эд, хосгүй баялаг ордууд дотоодод улс төрийн зөрчил тэмцэл, зэвсэгт мөргөлдөөн гарч, тэр ч байтугай төрийн эргэлтэнд хүргэж байсан гашуун туршлага сургамж түүхэнд цөөнгүй. Холын жишээг дурьдваас манай улсын нэгэн адил зэсээр баян орон болох Чили улсад 1973 онд гарсан төрийн эргэлт гадаадын хөрөнгө оруулалттай зэсийн 4 том уурхайг улс нийгэмчилсэнтэй холбоотойгоор гарч байсныг түүх мартаагүй. Ойрын жишээ гэвэл ОХУ-д "ЮКОС" компанитай холбогдон гарсан хэрэг явдал тус орны улс төрийн амьдрал, эдийн засгийн хэвийн ажиллагаанд яаж нөлөөлснийг бид мэдэж байна.

Монгол Улсын эрдэс баялгийг ашиглахыг тойрсон геополитикийн ил далд өрсөлдөөнд Монголчууд оролцохын тулд хөрш БНХАУ, ОХУ-н зүгээс ирж болох сөрөг нөлөөлөл, учирч болзошгүй дарамт шахалт тулгарч болзошгүй сорилт бэрхшээлийг зайлуулах, түүнээс зайлсхийх, эе эвээр

шудрага зохицуулахын тулд бид юунд гол анхаарлаа чиглүүлвэл зохих вэ?

Нэгдүгээрт: Монгол улсын уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалт түүний дотор олборлолтын болоод ашиглалтын лиценз олгох асуудалд анхаарал болгоомжтой, шудрага, хариуцлагатай хандах нь чухлаас чухал. Өнөөгийн байдлаар манай хоёр хөрш орон БНХАУ 232, ОХУ 248 лиценз эзэмшиж Монголд оруулсан хөрөнгө оруулалтаараа тэргүүлж явна.Эдгээр улсуудад ашиг сонирхлоо хамгаалах шаардлага гарвал манай улсад улс төр, дипломатын хүчтэй шахалт үзүүлэх магадлал ендөр байна. Цаашдаа ч энз хоёр гүрний эдийн засаг, цэргийн хүч чадал, дэлхийн бодлогод эзлэх б.айр суурь, нөлөө өсөхийн хэрээр энэ аюул, сорилт, улам бүр нэмэгдэхгүй гэх баталгаа байхгүй.

Хоёрдугаарт: уул уурхайн бүтээгдэхүүн олборлолт, ялангуяа хөрөнгө хамтарсан, дангаараа хөрөнгө оруулсан компаниудтай хийх гэрээ, хэлэлцээрийн биелэлт, түүний дотор хилийн ойролцоо, хязгаар нутагт олборлолт хийж буй уурхайнуудаас улсын хилээр орж гарч буй бүтээгдэхүүний тоо хэмжээ, хүн, машин тээврийн хэрэгслэлийн хөдөлгөөнд тавих хяналтыг хүчтэй, болгож, хяналтыг боловсронгуй болгохыг олон талаас үр өгөөжтэй болгох шаардлагатай.

Гуравдугаарт: уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох үнэ, ялангуяа нүүрс, цайр, төмрийн хүдэр гэх мэт нийтэд тэр бүр таньж мэдэгдээгүй ашигт малтмалын үнийг, цаашид нийт экспортын үнийг хянаж зохицуулдаг механизм бий болгох, эсвэл Монгол Улсын эрдэс баялгийн зөвлөлийн эрх хэмжээг өргөтгөн өнөөгийн жаягаар зөвхөн нөөц баталдаг бус ашигт малтмалын үнэ хан ı, найрлага, тоо хэмжээнд хяналт тавьдаг болгон өөрчлөх шаардлагатай.


Дөрөвдүгээрт: эрдэс баялгийн олборлолтын үр ашгийг нэмэгдүүлэх, хяналтыг сайжруулах үүднээс аль болох эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх. Үүний тулд алт болоод зэсийн үнийн өсөлтөөс орж ирэх нэмэлт орлого, ноогдол ашиг бусад орлогуудын нэлээд хувийг тогтворжилтын сангаар дамжуулан зэс хайлуулах үйлдвэрийг оновчтой газарт гадаадын хамтарсан үйлдвэрийн хэлбэрээр байгуулж, зэсийн баяжмалыг хяналтандаа авах, баяжмалыг шууд экспортлох тохиолдолд тодорхой хэмжээний татвар ноогдуулах. Цаашдаа бусад улсуудын жишгээр ашигт малтмалын бүх төрөлд нөөцийн рентийн татвар буюу хэт өндөр ашгийн татвар тогтоох хэрэгтэй. Түүнчлэн хөрш орнуудаас гарч буй төслүүд тухайлбал ОХУ, 1,5 сая.тонн газрын тос боловсруулах үйлдвэр, өнгөрсөн оны эцсээр тохиролцсон "Дорнод ураны хамтарсан үйлдвэр, БНХАУ-ын Шэнхуа компаний нүүрс гүн боловсруулах санал зэргийг хэрэгжүүлэх шаардлагатай.

Тавдугаарт: "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага"-д Монгол Улс нэн даруй тууштай нэгдэн орох хэрэгтэй. Уг санаачлагын дагуу компаниуд түүний дотор өнөөдөр хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр ихээхэн шуугиан дэгдэж байгаа хөрш орнууд бусад гадаад улсуудын компаниудтай засгийн газар, манай компаниудын байгуулсан бүх гэрээ, хийгдсэн бүх төлбөрийг нээлтэй болгож, ард иргэд баялгаас орсон орлогыг мэдэж тэрхүү орлогыг хэрхэн зарцуулж байгааг мэдэх боломжтой болж улмаар нийгмийн дунд хүчтэй болж буй хардлага, сэрдлэг, болгоомжлол буурах боломжтой болно. Ингэснээр иргэний болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа сайжирч, иргэний нийгмийн хяналт дээшилж тэр хэмжээгээр нэгэнт буй болсон нийгмийн бухимдлыг бууруулах учиртай.

Зургадугаарт: гадаад бодлого, аюулгүй байдлын асуудлаа уул уурхайн салбарын хөгжилтэй уялдуулан холбож үүний тулд зэс, жонш, нүүрс, эрчим хүчний гэх мэт хөтөлбөр боловсруулж, тэр чиглэлийн дипломат бодлогыг хэрэгжүүлэх.

Хөрөнгө оруулалт, ялангуяа хил орчмын томоохон уул уурхайн төслүүдэд дэлхийн нөлөө бүхий гүрнүүд уул уурхайн томоохон компаниудыг түлхүү оруулах асуудлыг онцлон авч үзэх. Энэ нь Монгол Улсын тусгаар тогтнол, улсын хил, хязгаар нутгийн аюулгүй байдалд стратегийн чухал ач холбогдолтой юм.

Монгол төрийн зөв бодлого, хуулийн ухаалаг, зарчимч зохицуулалт, сайн менежмент, оновчтой хуваарилт байхгүй бол улс орны улс төр, эдийн засаг, нийгэм, экологийн аюулгүй байдалд ноцтой аюул учрах, ялангуяа их гүрнүүд үндэстэн дамнасан корпорацуудын геополитикийн өрсөлдөөнд татагдан орж нөхөж баршгүй хохирол амсаж болох магадлал өндөр байгааг ухаарч ойлговоос зохилтой.



Г.Уламбаяр 1986 оны 08 сарын 10-ны өдөр Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд төрсөн. 2004 онд Арвайхээр сумын нэгдүгээр 10 жилийн сургуулийг 2008 онд "Их засаг" сургуулийн Чингис Соосэ олон улсын харилцааны сургуулийг "Гадаад харилцааны ажилтан" мэргэжлээр дүүргэсэн. 2008 оноос Чингэс хааны нэрэмжит "Их засаг" их сургуулийн олон улсын харилцааны тэнхимд багшилж байна.

МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ УЛС ТӨР, ДИПЛОМАТЫН АРГААР ХАМГААЛАХ НЬ

ЗХУ-ын цэрэг Монголоос гарсны дараа Монгол Улс цаашид үндэсний аюулгүй байдлаа ямар арга замаар, хэрхэн хангах вэ? гэсэн асуудал гарч ирсэн. Ер нь аливаа улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, эрх чөлөө бол хамгийн чухал асуудал юм. Үүнийг шийдэж болох арга замыг бид эрэлхийлсэн юм.

ОХУ, БНХАУ-ын нэгнийх нь дайсан, нөгөөгийнх нь холбоотон байсан улс яаж хоёулантай нь найрсаг, сайн хөршийн харилцаа тогтоож, харилцан ашигтай хамтран ажиллах вэ? гэдэг асуулдалтай тулгарсан. Хөршүүдээсээ болон олон улсаас улс орныхоо аюулгүй байдлыг хангах баталгааг олж авах нь чухал байлаа.

Монгол Улсын шинэ Үндсэн хууль /1992 он/, Гадаад бодлогын үзэл баримтлал /1994 он/, Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал /1994 он/ зэрэг төрийн тулгуур баримт бичгүүд Улсын их хурлаар батлагдаад эдүгээ амьдралд биеллээ олж байна. Эдгээр тулгуур баримт бичгүүд нь орчин үеийн Монгол Улсын төрийн гадаад бодлогын эрх зүйн үндэс болж байна. Мөн үе үеийн засгийн газрууд үйл ажиллагааныхаа мөрийн хөтөлбөрт гадаад бодлогын зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга, шийдвэрлэх алхмуудыг тодорхойлж Улсын их хурлаар батлуулж ирэв.

Эдүгээ хөгжиж байгаа улс тусгаар тогтнол , аюулгүй байдлаа цэргийн хүчээр хамгаалах боломжгүй, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Гадаад бодлогын үзэл баримтлалд зааснаар "Монгол Улсын аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хамгаална. Монгол Улс Монгол Улсын аюулгүй байдал , үндэсний язгуур эрх ашиг сонирхлыг улс төр - дипломатын аргаар хангах , эдийн засаг , шинжлэх ухаан – технологийг хөгжүүлэх гадаад таатай нөхцөлийг бүрдүүлэх явдал" гадаад бодлогын тэргүүлэх чиглэл гэж заасан.

1994 онд баталсан Гадаад бодлогын үзэл баримтлалд:"Монгол улс нээлттэй , эвсэлд үл нэгдэх бодлого явуулна" гэзд , аюулгүй байдал , үндэсний язгуур ашиг сонирхолыг улс төр дипломатын аргаар хангах эдийн засаг , шинжлэх ухаан технологийг хөгжүүлэх гадаад таатай нөхцлийг бүрдүүлэх явдал гадаад бодлогын тэргүүлэх чиглэл байхаар заасан юм. Хоёр том гүрний дунд орших газар зүйн хувьд эмзэг байрлалтай , аюулгүй байдлаа дан ганц цэргийн хүчээр сахин хамгаалах боломжгүй , эдийн

засгийн чадавхи сул , далайд гарцгүй зэрэг өвөрмөц бэрхшээлүүдийг даван туулж , үндэсний аюулгүй байдлаа бататган бэхжүүлэх , эдийн засгийн тогтвортой хөгжлийн үндсийг тавихад гадаад хүчин зүйлүүдийг хэрхэн үр ашигтай , зүй зохистой ашиглах вэ гэдэгт гадаад бодлогын бас нэг зорилт чиглэгдэж байна. Монгол улс гадаад бодлогынхоо зарчмыг "олон тулгууртай байна" хэмээн тодорхойлсон.

Монгол Улс цэргийн аливаа эвсэл, бүлэглэлд үл нэгдэх ,нутаг дэвсгэр ,агаар мандлаа аль нэг улсын эсрэг ашиглуулахгүй , гадаадын цэрэг , зэвсэг , түүний дотор цөмийн болон үй олноор хөнөөх бусад зэвсгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй байх чиг шугам баримтлана.

Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг зарласан нь гадаад бодлогын үзэл баримтлал болон аюулгүй байдлын үзэл баримтлалуудад заасан заалтын хэрэгжилтийг харж болох төдийгүй Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх хорогдуулахыг эрмэлзэж буй Их гүрнүүдийн ашиг сонирхолд нийцэж Монгол Улсын байр суурь, нэр хүндийг өсгөж тусгаар тогтнол, аюулгүй байдлаа улс төр, дипломатын аргыг чадварлаг ашиглаж, хөгжиж буй бусад улс орнуудад нөлөөлсөн явдал юм. Австри улс цөмийн зэвсэггүй статусыг зарласан , энэ үйл явдлаас харж болох юм. 1992 оны есдүгээр сарын 25-нд болсон НҮБ-ын Ерөнхий ассамблейн 45 дугаар чуулган дээр Ерөнхийлөгч үг хэлж, Монгол Улс цөмийн зэвсэггүй бүс болсныг зарласан.

Гэхдээ энэ статусыг НҮБ-аар хүлээн зөвшөөрүүлэх нь эн тэргүүний шаардлага байв. Зургаан жилийн хугацаанд Ерөнхийлөгч цөмийн зэвсэгтэй дэлхийн таван гүрэнд бие төлөөлөгчөө хоёроос доошгүй удаа явуулж, бодлогоо тайлбарлан дэмжлэг авахыг хүссэн. Мөн НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, түүний албанд энэ асуудлаа танилцуулж дэмжлэг авахыг хичээсэн.

Улс орон тус бүртэй бас хамтад нь уулзсан.

Ингээд 1998 онд л НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас ·Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг дэмжих тухай тогтоол гаргасан юм. Уг тогтоолд "Монгол Улс газарзүйн хувьд өвөрмөц байрлалтай, далайд гарцгүй орон. Тиймээс нутаг дэвсгэрийнх нь бүрэн бүтэн, хил хязгаарын халдашгүй дархан, эдийн засаг, экологийн аюулгүй байдлыг хамгаалах асуудал их чухал тул цөмийн зэвсэггүй статусыг нь дэмжиж байна" гэжээ.

Мөн НҮБ-аас манай улсын энэ статусыг дэмжиж, хамтарч ажиллахыг цөмийн зэвсэгтэй таван гүрэн, нийт улс оронд уриалсан юм.

Үүнээс хойш гурван жил гаруй ажиллаж байж 2001 онд цөмийн зэвсэгтэй ОХУ, АНУ, БНХАУ, Франц, Англи гэсэн таван гүрэн уг статусыг дэмжиж, аюулгүй байдлыг хангах хамтын баталгааг гаргах тогтоолд гарын үсэг зурсан. Энэ бол дипломат ажиллагааны маш том амжилт байлаа.

Өнөөгийн Зүүн хойд азийн нөхцөл байдал нь олон улсын нөхцөл байдлаас ихээхэн шалтгаалж байгаа бөгөөд дэлхийн эдийн засгийн хямрал , Хойд Солонгосын цөмийн асуудал тус бүс нутагт ноцтой нөлөөлж байна . Солонгосын хойг дахь хурцадмал асуудал БНСАУ тэртээ 1953 онд байгуулсан "Эвлэрлийн гэрээ"-с гарч 2009 оны 4 сарын 4-нд дэлхий дахинд " тив алгасагч пуужин " гэдэг нэрээр ойлгогддог "газрын хиймэл дагуул" -ыг хөөргөж , НҮБ- ын Аюулгүйн зөвлөлөөс хиймэл дагуул хөөргөхийг буруушаасан мэдэгдлийн хариуд зургаан талт хэлэлцээрээс гарч 5 сарын 25 – нд цөмийн туршилт хийсэн зэргээс байдал улам даамжирсан . Үүний үр дүнд АНУ Пхеньянтай хоёр талын харилцаагаа сайжруулж , яриа хэлэлцээрийн шинэ түвшинд хүрэх оролдлого бүтэлгүйтэж , Ардчилсан нам засгийн эрх авсан даруйдаа л уг асуудлаар уламжлалаа давтаж , чухал яриа хэлэлцээрийн механизм,

хүрсэн тохиролцоонуудаа алдсан юм.

Үүнээс хойш гурван жил гаруй хугацаа өнгөрсний дараа 2001 онд цөмийн зэвсэгтэй ОХУ, АНУ, БНХАУ, Франц, Англи таван гүрэн уг статусыг дэмжиж, аюулгүй байдлыг хангах хамтын баталгаа гаргах тогтоолд гарын үсэг зурсан. Энэ бол улс төр дипломатын маш том амжилт байлаа. Одоо бидэнд нэг чухал алхам үлдсэн. Энэ нь дээрх таван гүрэнтэй цөмийн зэвсэггүй статусыг баталгаажуулсан гэрээ байгуулах, гэрээний талаар дээрх орнуудтай ярилцан тохиролцоонд хүрэх явдал юм. Англи, АНУ, Франц гурав "Та нар хоёр хөрштэйгээ гурван талын гэрээ байгуулчих юм бол бид шууд нэгдэнэ" гэсэн байдаг. Монголын тал гэрээнийхээ төслийг ОХУ, БНХАУ руу явуулаад хариу авсан. Одоо хэлэлцээрээ сайн хийж, хөрш орнуудтайгаа гэрээнд гарын үсэг зурах л үлдээд байгаа билээ.

Энэ гэрээг байгуулчихвал Монгол Улс улс төр, эрх зүйн бүрэн баталгаатай болно. Ямар нэг асуудал гарч нэг нь гэрээгээ зөрчвөл бусад нь бие биеийнхээ өмнө хариуцлага хүлээх учиртай. Өөрөөр хэлбэл, Монгол Улс үндэсний аюулгүй байдлаа олон улсын түвшинд, дипломат аргаар баталгаажуулж байгаа нь энэ болой.

Цаашид БНХАУ болон ОХУ цөмийн зэвсэггүй статусыг баталгаажуулж Англи, Франц, АНУ зэрэг таван улсаар гэрээг баталгаажуулах ажлыг богино хугацаанд яриа хэлэлцээгээр шийдвэрлэх ингэснээр аюулгүй байдлыг улс төр –дипломатын аргаар улам баталгаажуулах нь чухал болно.

Хөрш хоёр оронтойгоо тэнцвэртэй харилцааг хөгжүүлэх,бүс нутгийн болон олон улсын аюулгүй байдал,энх тайван байдлыг тогтооход НҮБ-ын ивээл дор энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох , Монгол Улсын нэр хүндийг өргөх , гадаад таатай орчинг бий болгох улс төр-дипломатын аргыг идэвхтэй хэрэгжүүлэх явдал Монгол Улсын шинэ гадаад бодлогын эрхэм чухал зорилтуудын нэг болж байна.


ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ СУДАЛГААНЫ АЖИЛ

Т.Сүхбаатар. БХУА-ийн магистрант, дэд хурандаа

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАНД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АНГИ, САЛБАРУУД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ,

"Зэвсэгт хүчний тухай" Монгол Улсын хуулинд Зэвсэгт хүчний гүйцэтгэх үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна.Үүнд :

Зэвсэгт хүчний үндсэн чиг үүрэг нь эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах явдал мөн.



Зэвсэгт Хүчний анги, салбар нь тайван цагт Монгол улсын хилийн тухай хуулийн дагуу зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх сургалтыг бие бүрэлдэхүүндээ эзэмшүүлсэн байна.

Харилцан ажиллагааны төлөвлөгөөны дагуу Зэвсэгт Хүчний анги, салбарыг улсын хил халхлалтад оролцуулж болох бөгөөд энэ талаархи журам, харилцан ажиллагааг ЗХЖШ, Хил хамгаалах ерөнхий газартай хамтран тогтоож Монгол Улсын Батлан хамгаалахын сайдаар батлуулна.

ЗХЖШ нь тайван цагт улсын хил халхлах төлөвлөгөөг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангана. /БХС-143. 2.8/

Улсын хил дээр цагийн байдал хурцадсан үед нэн яаралтай хийх удирдлага зохион байгуулалтын гол арга хэмжээний нэг нь хилийн отряд, зэвсэгт хүчний анги салбаруудыг байлдааны бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх арга хэмжээ болно.

"Байлдааны бэлэн байдал" гэдэг нь цэргийн анги салбар өөрийн хүч хэрэгслээр ямар ч нөхцөлд тавигдсан байлдааны үүргийг биелүүлэх чадавхийг хангасан байдлыг хэлнэ.

Улсын хил дээрх цэрэг-улс төрийн хурцатмал байдал улам даамжирсаар дайн бүхий байдал, улмаар дайны байдалд хүрч болзошгүй юм.

"Дайн бүхий байдал" гэж Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд аюул занал учруулж, зэвсэглэн халдсан улс, түүний холбоотонтой дайн бүхий байдал зарласан мөчөөс түүнийг цуцлах хүртэлх улс хоорондын харилцааны онцгой хэлбэр болно.

"Дайны байдал" гэж Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь эмх замбараагүй байдал үүсч, зэвсэгт мөргөлдөөнд хүрсэн, тийм мөргөлдөөн гарах бодит аюул буй болсон бусад улсаас цэргийн хүчээр түрэмгийлэн халдсан эсхүл тийнхүү халдах нь бодитой болсон үед төрийн эрх барих дээд байгууллагаас нийт нутаг дэвсгэр буюу зарим хэсэгт тогтоох улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн онцгой дэглэмийг хэлнэ.

Улсын хил халхлалт нь бүх нийтийн дайчилгаа эсхүл хэсэгчилсэн дайчилгаа явуулах, томилгоот анги, салбаруудыг байлдааны үүрэг гүйцэтгэх заагуудад хүч задлах боломжийг бүрдүүлэх зорилгоор хил халхлалтыг зэвсэгт хүчний нэгтгэл, анги, хилийн тусгай ангиуд хамтран явуулах байлдааны ажиллагаанууд болно.

Улсын хил халхлалтанд ерөнхий зориулалтын цэргээс хил орчим байрлаж байгаа анги салбарууд, агаарын довтолгооноос хамгаалах болон радио техникийн анги салбарууд, хил хамгаалах байгууллагаас тухайн зурваст улсын хилийг хориглон хамгаалж буй хилийн отряд, эсхүл түүний салбарууд оролцоно.

Дайсан тодорхой чиглэлээр багахан бүлэглэлээр довтлох, нутгийн гүнд тагнуул хорлон сүйтгэх бүлэг десантын хүчээр байлдааны ажиллагаа явуулах тохиодолд хилийн цэргийн болон Зэвсэгт хүчний анги салбарууд хил халхлах ажиллагаанд харилцан ажиллаж улсын хил дээр үүссэн өдөөн хатгалга, хорлон сүйтгэх ажиллагааг таслан зогсоох, зэвсэгт халдлагыг няцаах, устгах үүргийг .....зэвсэгт хүчний анги салбарын хүчээр, тухайн чиглэлд байгаа Хилийн цэргийн анги салбарын хүчээр гүйцэтгэж болно.

"Монгол улсын төрийн цэргийн бодлогын үндэст": Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн халдашгүй дархан байдалд цэргийн хүчээр заналхийлсэн, зэвсэгт түрэмгийлэл үйлдсэн улс орон, тэдний энэхүү зэвсэгт түрэмгийлэлд холбоотон нь болж буй эдгээдийг дайснаа гэж үзнэ.

Монгол улс гадны зэвсэгт түрэмгийллийн эсрэг өөрийгөө хамгаалах зэвсэгт тэмцэл явуулна. Үүнд :

- Аливаа улс орон манай улсын нутаг дэвсгэрт цэргийн хүчээр цөмрөн орох, халдан довтлох,

-Хилийн гаднаас манай улсын болон цэргийн обьектод зэвсгийн хүчээр цохилт хийх,

- Гадаад улсын Зэвсэгт Хүчин тус улсын нутаг дэвсгэрт байрлах, дамжин өнгөрөхдөө энэ тухай Монгол улсын хуулийг зөрчих,

- Аливаа улс орон, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу түр буюу удаан хугацаагаар эзэмшүүлж буй газар нутгийг бусад улс орны эсрэг зэвсэгт түрэмгийллийн зорилгоор ашиглах,

- Аливаа улс орон тусгайлан бэлтгэсэн зэвсэглэсэн хүмүүсийг зохион байгуулалтайгаар Монгол Улсад нэвтрүүлэх улмаар Монгол улсын нутаг дэвсгэрт алан хядах, хорлон сүйтгэх

болон бусад хууль бус үйл ажиллагаа явуулах,

- Аль нэг улс орны дотоодын зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд Монгол Улсын хилийг зөрчих, цөмрөн орох гэж заасан байна.

"Монгол улсын төрийн цэргийн бодлогын үндсийн 15-д": Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалан орчин үеийн зэвсэг, байлдааны техникээр зэвсэглэсэн давуу хүчтэй дайсантай зэвсэгт тэмцэл явуулахад зэвсэгт хүчин бусад цэрэг, төр, нийт иргэд, аж ахуйн нэгж, байгууллага бэлэн байх ёстой" эдгээр хуулинд заасныг удирдлага болгон Зэвсэгт хүчний анги салбарууд хилийн отрядтай харилцан ажиллагаатайгаар байлдааны ажиллаагаа явуулж болох юм.

Орчин үеийн дайны үзэл бодлоор дайсан эхлээд улсын хил дээр зэвсэггүйгээр өдөөн хатгалга үйлдэж дараа нь зэвсэгт өдөөн хатгалгад шилждэг байна.

Дайсан өөрийн цэргийн цохилт хийх гол чиглэлийг төөрөгдүүлэх, хүч хэрэгслийн маневрыг нууцлах, тэрчлэн байлдаан явуулж тагнах зорилготойгоор өдөөн хатгалга явуулдаг ажээ.

Тавигдсан үүрэг зорилгоос шалтгаалж зэргэлдээ улсын талаас явуулах өдөөн хатгалга нь зэвсэгт ба зэвсэгт бус шинжтэй, улсын хилийг зөрчих буюу зөрчихгүйгээр үйлдэгдэж болзошгүй юм.

"Монгол улсын төрийн цэргийн бодлогын үндсийн 12-д" бусад орны зүгээс зэвсэгт түрэмгийлэл үйлдэх нь тодорхой болсон тохиодолд Монгол Улс дараахь үйл ажиллагаа явуулна. Үүнд:

1.Түрэмгийлэл үйлдэхээр зэхэж буй улс оронтой дипломатын аргаар яриа хэлэлцээр хийх.

2.НҮБ, олон улсын цэрэг, улс төрийн байгууллага, Монгол Улсыг дэмжигч нөлөө бүхий улс орнуудтай батлан хамгаалах талаар цаг алдалгүй гэрээ хэлэлцээр байгуулах, зэвсэг техникийн туслалцаа авах...

3. Улс орныг дайны байдалд шилжүүлэх, түрэмгийллийг няцаах бэлтгэлийг хангах, Зэвсэгт хүчин бусад цэргийн бэлэн байдлыг өндөржүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнүүдийг дэс дараатай хэрэгжүүлэх" гэж заажээ.

Цэрэг, улс төрийн байдал хурцадсан үед улсын хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх ажиллагаанд Зэвсэгт хүчний анги салбарууд чухал байр суурийг эзэлнэ.

Зэвсэгт хүчний анги салбарууд хилийн цэрэгтэй харилцан ажиллагааны төлөвлөгөөний дагуу хилийн заставуудыг рот буюу салаагаар хүч нэмэгдүүлэх, мөн эрэл зохион байгуулж явуулахад Зэвсэгт хүчний анги салбаруудаас хилийн отрядын даргын мэдэлд хүч нэмэгдүүлсэн МБББ-ыг томилж болно.

Зэвсэгт хүчний анги салбаруудын хилийн албаны бэлтгэлийг ЗХЖШ хариуцан явуулж, ХХЕГ мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.

Б.Аманбек. БХУА-ийн магистрант, хошууч

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ НЬ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ БОЛОХ НЬ

Сүүлийн хориод жилд дэлхийн олон орон, ард түмний амьдрал хийгээд орчин үеийн геополитикийн зураг дээрх лугаа томоохон өөрчлөлт орсон явдал үндэсний болон бүх нийтийн аюулгүй байдлыг хангах арга зам, хүч хэрэгслийн сонголтод ухаалгаар хандахыг шаардах боллоо. Шинэ нөхцөл байдал нь "Аюулгүй байдал", "Үндэсний аюулгүй байдал" гэдэг ойлголтуудыг улам өргөн хүрээтэй, гүнзгий агуулгатай болголоо.

Ерөөс "Үндэсний аюулгүй байдал" гэдэг нэр томъёо XX зууны 90-ээд оны эхээс эргэлтэд орсон байдаг ч үндэсний аюулгүй байдлыг хангах асуудал төр үүссэн цагаас л эхлэлтэй байж таарна. Үндэсний аюулгүй байдлыг хангахын тулд эн тэргүүнд уг ойлголтын мөн чанар, агуулгыг, гүнзгий танин мэдэж, зорилго болон түүнийг хэрэгжүүлэх механизм, хамгийн оновчтой, үр дүнтэй арга хэрэгслийг тодорхойлох шаардлага үүсдэг[1.т.65]. Иймээс үндэсний аюулгүй байдлыг хангах асуудалд онолын гүн гүнзгий, бүрэн дүүрэн боловсруулалт хийх явдал үндэстэн улс бүрийн хувьд чухал байдаг юм.

Үндэсний аюулгүй байдал нь тухайн улсын оршин байгаа байдал, түүний оршин байх таатай нөхцөлийг хангах үйл ажиллагааны нэгдэл юм. Энэ нь аливаа улс буюу үндэстний амин чухал ашиг сонирхол болдог билээ.

"Үндэсний аюулгүй байдал" гэдэг нэр томьёо ОХУ-ын хувьд 1995 онд "Мэдээллийг хамгаалах ба мэдээлэлжүүлэлт, мэдээллийн тухай" холбооны хуулинд анхлан орж, эрх зүйн актад тусгагдсан. Энэ баримт бичигт "Үндэсний аюулгүй байдал гэж төр, нийгэм, хувь хүмүүсийн дэвшил, хөгжлийг хангаж, үндэсний эрх ашиг дотоод, гадаад аюулаас хамгаалагдсан байхыг хэлнэ"[2.т.3], Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд "ОХУ дахь засаглалын нэгэн эх булаг, тусгаар тогтнолын эзэн болох олон үндэстний ард түмний аюулгүй байдал"[3] гэж тус тус тодорхойлжээ.

Үндэсний аюулгүй байдлын талаарх ойлголтыг манай улсын эрдэмтэн Ч.Улаанхүү "Үндэсний аюулгүй байдал гэдэг нь үндэсний нөөц баялаг, үнэт зүйлс тэрчлэн улс, нийгэм, хувь хүний ашиг сонирхол дотоод, гадаадын аюул заналаас тухайн түвшин, шинж чанарын хувьд хангалттай хамгаалагдсан байдал юм[4.т.113] үзсэн байна.

Мөн түүнчлэн үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлыг судалдаг Оросын эрдэмтэн А.В.Возженников "Үндэсний аюулгүй байдал" гэдэгт улс орны нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, дотоодын тогтвортой, тусгаар тогтносон, дэвшилттэй хөгжлийг хангаж, бүрэн эрхтэй, бие даасан байдлаар олон улсын харилцаанд оролцох боломжийг бүрдүүлэн, амьдрал, үйл ажиллагааны бүх салбарт гадаад, дотоодын аюул заналаас төр, нийгэм, хувь хүмүүсийн амин чухал эрх ашиг хамгаалагдсан байдаг гэж ойлгож байна"[5.т.48]гэсэн нь нилээн бүрэн дүүрэн, бодитой тодорхойлсон гэж үзэж байна.

Би үндэсний аюулгүй байдлын талаарх бүх тодорхойлолтуудыг судалж дүн шинжилгээ хийх зорилго тавиагүй болохоор цаашдаа үндэсний аюулгүй байдлыг, улс орны тогтвортой урагшлах хөгжлийг хангаж, төр, нийгэм, хувь хүмүүсийн амин чухал эрх ашиг, гадаад, дотоодын аюулаас хамгаалагдсан байдал гэсэн нийтлэг томъёоллоор

үндэсний аюулгүй байдлыг тодорхойлж байгаа юм.

Манай улсын хувьд Үндэсний аюулгүй байдлаа "Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ"гэж[6.т.1482] тодорхойлсон байдаг бөгөөд Үндэсний язгуур ашиг сонирхолд: "монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил" багтана.

Үндэсний ашиг сонирхлын хамгийн гол тодорхойлогч, тулгуур ойлголт нь улсын оршин тогтнох, хөгжин хүчирхэгжих асуудал, өөрөөр хэлбэл, бие хүн, нийгэм, улсын аюулгүй байдлыг хангах явдал юм. Өөрөөр хэлбэл геополитикийн өөрмөц байрлалтай Монгол Улсын тусгаар болон бүрэн эрхт байдал нь монголын ард түмэн, түүний соёл иргэншил оршин байхын үндсэн баталгаа болно. Иймд Монголын ард түмэн хийгээд түүний төр улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал нь яахын аргагүй тэргүүн зэргийн үнэт зүйлс, язгуур ашиг сонирхол байх ёстой болов уу гэж үзэж байна.

Энэхүү үзэл баримтлалаар хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй байдлыг язгуур ашиг сонирхол гэж үзсэн нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалалтын анхаарал төвлөрөх объект буюу хилийн орон зайг тодорхой болгоход ихээхэн дөхөм үзүүлсэн. Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд улсын хилээс гадуур учрах аюул гэж бараг байхгүй[7.т.191] учир хилийн орон зайг тодорхойлох нь чухал ач холбогдолтой юм. Үүний учир хилийн орон зайд улс нийгэм, ард түмний амин чухал эрх ашиг хамгаалагдсан байдлаар Үндэсний аюулгүй байдал хангагдаж баталгаажих нэг үндэс болно гэж үзэж байна.

Монголын газар нутгийг зарим судлаачид тоймлон төв хэсэг, хязгаарын хэсэг гэж гол төлөв хоёр хуваан ангилдаг бөгөөд улсын хилийн аюулгүй байдлыг хангах эрх ашигтай холбон үзвэл улсынхаа нутгийг хязгаар, төв гэж ангилах нь бодит байдалд хараахан нийцэхгүй байна. Үүнийг, цэргийн шинжлэх ухааны доктор, профессор, дэслэгч генерал Ш.Арвай: хилийн орон зай, хязгаарын орон зай, төвийн хэсгийн орон зай[8.т.127] гэж гурван ангилалд авч үзсэнтэй санал нэг байна. Хязгаар гэдэг агуулгад асар өргөн уудам нутаг газар орон багтаж байгаа ба тийм хэмжээний зайнд аюулыг лавшрах бололцоо олгодог. Харин хилийн орон зай нь үндэсний ашиг сонирхол, олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу эрх зүйн тусгай журам тогтоогдсон, төрийн тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор эрх бүхий байгууллагууд хяналт шалгалтын болон хамгаалалтын журам сахиулж байгаа хил орчмын нутаг дэвсгэрийн тодорхой хэсэг юм.

Үндэсний аюулгүй байдал нь олон элементүүдийг агуулдаг бөгөөд[10.т.37] хилийн аюулгүй байдал бол үндэсний аюулгүй байдлын уламжлалт нэг чухал элемент юм.

Олон улсын хэмжээнд хилийн орон зайд улс, нийгэм, иргэдийн амин чухал эрх ашиг хамгаалагдсан байх нөхцөлийг хилийн аюулгүй байдал гэж хэлдэг байна[9.т.12]. Тухайлбал ОХУ-ын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал /II бүлэг.Оросын үндэсний ашиг сонирхлууд/-д төрийн ашиг сонирхолд эдийн засгийн, дотоод улс төрийн, нийгмийн, оюун санааны, олон улсын мэдээллийн, цэргийн, хилийн, байгаль орчны ашиг сонирхолууд байна гэж тодорхойлоод, хилийн аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын нэг төрөл ангилалд багтаадаг байна.

Харин Монгол Улсад Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3 дугаар зүйлд: Монгол Улсад Үндэсний аюулгүй байдал нь оршин тогтнохын аюулгүй байдал; эдийн засгийн аюулгүй

байдал; дотоодын аюулгүй байдал; хүний аюулгүй байдал; хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал; мэдээллийн аюулгүй байдал[11.т.1483] гэсэн үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байна гэж тодорхойлсон. Үүнийг задлан шинжилж үзэхэд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын бүрэлдэхүүн хэсэгт "хилийн аюулгүй байдал" гэсэн үг өгүүлбэр байхгүй ч түүний агуулга нь Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдлын хүрээнд хил хязгаарын халдашгүй байдал гэсэн агуулгаар багтаж байгаа юм. Тиймэс энэхүү үзэл баримтлалын агуулгад шууд биш ч гэсэн шууд бусаар хилийн аюулгүй байдлыг тусгасан хэмээн үзүүштэй.

Мөн Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын салшгүй хэсэг нь Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого мөн[13.т.5] бөгөөд уг "...бодлого нь байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдэнэ" гэж Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого баримт бичигт заасан. Өөрөөр хэлбэл энэхүү баримт бичиг бол хилийн аюулгүй байдлыг хилийн орон зайд хангах чухал хэрэгсэл болдог.

Дээрхи албан ёсны баримт бичгүүдэд тодорхойлсон "МУ-ын хил, хязгаар нутгийн халдашгүй байдал", эсвэл "хилийн халдашгүй байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал" гэсэн үзэл санаануудыг нэгтгэн дүгнэж үзэхэд эцсийн үр дүнд хилийн аюулгүй байдлын хүрээний асуудлууд юм. Өөрөөр хэлбэл хууль тогтоогчид "хилийн аюулгүй байдал" гэдэг ухагдахууныг тодорхойлоогүйгээс "хил хязгаарын халдашгүй байдал", "хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал" гэсэн томъёоллоор тус тус оруулжээ.

Зарим судлаачид хилийн аюулгүй байдал бол үндэсний аюулгүй байдлын "гол бүрэлдэхүүн хэсэг"[Шербаков. А.С Пограничная безопасности России и система ее обеспечения] буюу "бие даасан төрөл"[Сергеев.В.В Конституционно – правовые основы безопасности государственный границы Российской Федераци] гэж тайлбарлаж байгаа юм. Үндэсний аюулгүй байдлын бүтцэд хилийн аюулгүй байдлыг ялган зааглах үндэслэл нь үндэсний ашиг сонирхол, түүнд учрах аюул заналыг төвлөрүүлсэн, нийгмийн харилцаа / хилийн орон зай/-ны тодорхой орчин хамаарч байгаа болохоор, хилийн аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын "бие даасан төрөл" гэж онцлох нь учир дутагдалтай.

Нийгмийн харилцааны энэ хүрээ, үндэсний аюулгүй байдлыг хангах үйл явцад бүрэлдэх бүх харилцаанаас том, өөрөөр хэлбэл, хилийн аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, нэгэн төрөл гэж үзвэл зохино.

Бүтэн юмны хэсэг гэдэг харьцангуй бие даасан байдалтай байдаг учир, хилийн аюулгүй байдлыг "бие даасан төрөл" гэж ангилах нь буруу юм. Хилийн аюулгүй байдал бол үндэсний болон орон нутаг, дэлхий төвшний төрөл бүрийн субъектүүд, тэдний янз бүрийн нь дотоод чадавх, харилцан ажиллагааны үр дүн юм. Тэгээд бас энэ харилцан ажиллагаа орчин цагийн нөхцөлд үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн бүр нь улмаар нөгөөхөө нөхцөлдүүлж, бусад нь буй болох нөхцөл болж, улам бүр нэгдмэл тогтолцооны шинжтэй болж байна.

Хилийн аюулгүй байдал нь тодорхой орон зай /хилийн орон зай/ дахь үндэсний ашиг сонирхлын аюулгүй байдлаар голчлон тодорхойлогдож, аюулгүй байдлын бусад төрлүүдэд шууд нөлөөлж байдаг. Үүнтэй холбогдуулан миний бие хилийн аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдлын нэгэн төрөл гэдгийг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ, тэр нь үндэсний аюулгүй байдлын тогтолцоонд зөвхөн нэгэн төрөл тодийгүй, өөрийнхөө объектуудаар үндэсний аюулгүй байдлын төрлүүдийн агуулгыг бүрэн хамардаг, түүний нэгдмэл төрөл байх ёстой гэж үзэж байна.

Хилийн аюулгүй байдлын мөн

чанар нь хилийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг аюул гарч болзошгүй үед нь илрүүлэн арилгах, субъектив аюулыг илэрсэн тухайн үед нь засч, залруулж байх шаардлагатай бөгөөд олон улсын дэмжлэг, хамтын ажиллагаа шийдвэрлэх үүрэгтэй байж болно.

Эцсийн эцэст хилийн аюулгүй байдал, төр, нийгэм, иргэдийн язгуур эрх ашгийг хилийн орон зайд хангах замаар үндэсний хийгээд, улс хоорондын аюулгүй байдлыг хангах тогтвортой урьдчилсан нөхцлийг бүрдүүлэх явдал юм. Үүнээс үндэслэн улс орны нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангаж, тусгаар тогтнолыг бэхжүүлэн, улсын хил болон түүний орон зайд цагийн байдлыг тогтвортой байлгаж, төр, нийгэм, иргэдийн язгуур эрх ашгийг хилийн орон зайд хэрэгжүүлэх таатай нөхцлийг хангах, учирч болзошгүй аюул заналыг арилгах, хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо бүрдүүлэх нь хилийн аюулгүй байдлын үндсэн зорилго болж байна.

Аливаа улс үндэстэний хувьд хилийн аюулгүй байдлаа хангана гэдэг нь юуны өмнө төрийн тусгаар тогтнол, газар нутгийнхаа бүрэн бүтэн байдал, ард иргэдийнхээ оюун санааны нэгдмэл чанарыг хилийн орон зайд хамгаалан бэхжүүлэхээс эхлээд өөрийн ашиг сонирхол, хилийн халдашгүй дархан байдлыг бусдаар хүлээн зөвшөөрүүлэх төдийгүй, түүний баталгаатай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй олон талтай, баялаг агуулгатай улс төр-дипломат, цэрэг, тагнуул, эдийн засгийн цогц бодлого, арга хэрэгсэл, үйл ажиллагааны нэгдэл хэмээн ерөнхийд нь ойлгож болно.

Ашигласан, ишлэл авсан сурвалж, судалгааны бүтээлийн жагсаалт

1. Стратеги судлал сэтгүүл.УБ.2008.№43
2. Послание Президента РФ Федеральному Собранию "О национальной безопасности".М.1996
3. Президента РФ от 10 января 2000 г.№24 "О концепции национальной безопасности Российской Федерации
4. Уланхүү.Ч Аюулгүй байдал.УБ.2009.186х
5. Возженников.А.ВПарадигманациональнойбезопасностиреформирующейся России.М.2000
6. Төрийн мэдээлэл сэтгүүл.УБ.2010.№36
7. Арвай.Ш Улсын хилийн тухай дурсамж, үзэл бодол.УБ.2005.
8. Арвай.Ш Улсын хилийн тухай өвөг дээдсийн хайрласан сургамж. УБ.2002.159х
9. Хил судал сэтгүүл.№03-04.УБ.2009
10. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал.УБ.2010.№14(24).126х
11. Төрийн мэдээлэл сэтгүүл.УБ.2010.№36
12. МУ-ын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлал.УБ.2010
13. МУ-ын төрөөс хилийн талаар баримтлах бодлого.УБ.2002.77х

Х.Гантулга. БХУА-ний магистрант, хошууч

ОЛОН УЛСЫН ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ХУУЛИЙН ЗАРЧИМ.

Зэвсэгт мөргөлдөөний хууль гэхээр энэ бол бидэнд огт хэрэггүй зөвхөн Зэвсэгт хүчин буюу дайн байлдааныг бэлтгэж, явуулах нэгтгэл, ангиудад л /бидний хэлж заншсанаар арми/ хэрэгтэй, надад огт хэрэггүй зүйл байна хэмээн санагдаж болзошгүй юм. Гэвч Зэвсэгт мөргөлдөөний хууль нь Хил хамгаалах байгууллагад ажиллаж буй албан хаагчдад ч гэсэн амин чухал, түүнийг зайлшгүй мэдэж байх ёстой асуудлуудын нэг нь мөнөөс мөн юм.

Дэлхий дахин даяаршиж, олон улс гүрнүүд эвлэлдэн нэгдэж, энх тайвнаар зэрэгцэн орших бодлогыг баримтлахыг эрмэлзэж байгаа хэдий ч байгалийн баялгийн төлөөх тэмцэл, газар нутгийн маргаантай асуудал, үндэстэн хоорондын зөрчилдөөн, салан тусгаарлах оролдлого гэх мэтийн олон хүчин зүйлүүдээс шалтгаалан олон улс гүрнүүд зэвсэгт мөргөлдөөнд татагдан орж байна.

Манай улсын хувьд дэлхийн хөгжлийг тодорхойлогч хоёр их гүрний дунд оршин тогтнодог учир бидэнд ийм явдал тохиолдохгүй хэмээн нэг өнцгөөс харж санаа амирлангуй байж болохгүй юм. /тэнэгийн дотор харанхуй хэмээдэг бөгөөд хүнд мэдлэг мэдээлэл хэзээ ч илүүддэггүй./

Учир нь том гүрнүүдийн доторх олон үндэстнүүдийн тэмцэл, салан тусгаарлах бодлого, оролдлогын улмаас улсын хилээр дүрвэгсэд орж ирэх, тэднийг буцааж авчрах зорилгоор зэвсэглэсэн бүлэг, дээрэмчид, тухайн улсын зэвсэгт хүчний анги, салбарууд орж ирэн, энэ нь ЗМ-ний түвшинд ч хүрч болдог. Үүний тод жишээ нь Турк, Иракийн хил дээр болсон үйл явдал.

Үүнээс гадна Монгол Улс анх 2002 оноос НҮБ-аас хэрэгжүүлж буй Энхийг сахиулах ажиллагаанд /ЭСА/ оролцож, багаггүй мэдлэг, туршлага хуримтлуулсан.

ЭСА-нд Хил хамгаалах байгууллагаас цөөнгүй цэргийн албан хаагч үүргээ амжилттай биелүүлж ирсэн бөгөөд цаашид ч гэсэн олон улсын эрх ашиг, аюулгүй байдлыг хангахын тулд хилчин дайчид маань энхийг сахиулагчдын үүргийг гүйцэтгэх болно.

НҮБ-ын ЭСА нь цагийн байдал хүндэрсэн үед дайтагч талуудын маргааныг зогсоох зорилгоор Энхийг хүчээр сахиулах ажиллагаа болон хувирах магадлал ихтэй учир НҮБ-ын ажиллагаанд цэргийн хүчнийг хандивлан оруулж байгаа улс орнуудын ЗХ-ний цэргийн албан хаагчид нь Зэвсэгт мөргөлдөөний хуулийг сайтар ойлгосон байх ёстой байдаг.

Иймийн учир уншигч таны мэдлэгт өчүүхэнч гэсэн хөрөнгө оруулах зорилгоор энэхүү нийтлэлийг толилуулж байна.

Дэлхийн зарим бүс нутаг, улс орон дахь мөргөлдөөн, түүний доторх зэвсэгт мөргөлдөөнийг шийдвэрлэхэд хүч хэрэглэх хууль эрх зүйн хэм хэмжээний тухай асуудал нь олон улсын бодлогын хамгийн төвөгтэй асуудлуудын нэг байсаар байна.

Зэвсэгт мөргөлдөөний хуулийн талаар хүмүүс өөр өөр ойлголттой байдаг бөгөөд "дайн, байлдааны явцад түүнийг хэрэгжүүлэх боломжгүй" гэх хүн ч байдаг.

Гэвч сүүлийн жилүүдэд явуулсан орон нутгийн дайн, зэвсэгт мөргөлдөөнд явуулсан цэргийн үйл ажиллагааны бодит үр дүнгээс үзэхэд ирээдүйн зэвсэгт тэмцэл нь цэргийн болон технологийн

салбарт хамгийн тэргүүний амжилтанд хүрч, түүнийгээ амьдралд хэрэгжүүлэхэд дээд зэргээр бэлтгэгдсэн талуудын хууль ба дүрмийн дагуу явагдана гэсэн үзэл баримтлалыг баталж байна.

"Хуулиуд дээр үндэслэгдсэн зарчмуудыг хүн тодорхой үйл явдлаас шалтгаалан ухамсартайгаар хэрэглэдэг" нь сүүлийн үед явагдсан зэвсэгт мөргөлдөөний туршлага, сургамж, практикаас харагдаж байна.

Дэлхийдахиндболсондайн,зэвсэгт мөргөлдөөний явцад зэр зэвсэг улам боловсронгуй болж, операц, байлдааныг явуулах арга, хэлбэр өөрчлөгдөж зэвсэгт тэмцлийн хэрэгслийн хөнөөлийн хүчин чадал нэмэгдэхийн зэрэгцээ өөрийн улс, орны эрх ашигийг хамгаалах, дайн байлдаанд ялалтад хүрэх зорилгоо хангахын тулд хөнөөлийн янз бүрийн зэвсэг болон арга тактикийг хэрэглэх нь өсч, түүнд өртөгсөд, хэлмэгдэгсдийн тоо харьцангуй нэмэгдсэн нь Зэвсэгт мөргөлдөөний хуулийг гаргах үндэс суурь нь болж өгсөн.

Зэвсэгт мөргөлдөөний хууль байх ёстой гэсэн анхны санаа санаачлага 1859 онд Сольферногийн байлдааны талбарт төрсөн билээ.

Франц улс Австраас Италийн нэгээхэн хэсгийг эзлэн авахын тулд 1859.06.24-нд Италийн Сольферино тосгоны ойролцоо Австри, Франц-Сардины армийн хооронд болсон тулалдаанд дайны талбарт шархдагсад эмнэлгийн ямар ч тусламж авч чадахгүй байснаас амь үрэгдэгсдийн тоо маш олон болж байжээ.

Тулалдааны талбарт хүндээр шархдаж, үхэх мөчөө хүлээн тарчилж байгаа цэргүүдийг харсан Анри Дюнан Женевт буцаж ирснийхээ дараа сэтгэлээс салахгүй аймшигт үйл явдлын тухай "Сольферногийн дуртгал" гэдэг ном бичиж энэ номондоо: Европын хэмжээнд тусламжийн нийгэмлэг зохион байгуулах; дайн үүссэн нөхцөлд байлдагч талууд бүх шархтнуудад тусламж үзүүлэх, тэд ямарч үндэстэн байсан хоорондоо зөвшилцөх; улс гүрнүүд олон улсын эрүүгийн болон заавал биелүүлэх журамд гарын үсэг зурах, түүний дотор Европын орнууд шархтнуудад туслах хэрэгтэй гэсэн саналыг дэвшүүлж ЗМХ-ийг санаачилсан.

Дайн, зэвсэгт мөргөлдөөний туршлагаас урган гарсан Зэвсэгт мөргөлдөөний хууль нь бодит амьдралаас урган гарсан хүмүүнлэгийн шинж чанартай бөгөөд Тухайлбал:

* 1864 оны Женевийн конвенц - Өвчтөн, шархтанг хамгаалах тухай / Франц-Австрийн 1859 оны дайны гашуун туршлагаас төрөн гарсан/,

* Женевийн 1925 оны протокол Брюсселийн хэлэлцээр: - Байлдаанд хорт ба бусад төрлийн хий бактерлогийн арга хэрэглэхийг хориглосон. /Франц-Пруссын 1870 оны дайнаас урган гарсан/

* Женевийн 1929 оны конвенц: - Цэргийн олзлогдогсодын тухай. /Дэлхийн нэгдүгээр дайнаас урган гарсан /

* Женевийн 1949 оны конвенцүүд: - Энгийн иргэдийг хамгаалах тухай, Дайтагч талуудын шархадсан, өвчтэй цэргүүдийг асран хамгаалах, Олзлогдогсодтой харьцах тухай /Дэлхийн хоёрдугаар дайнаас урган гарсан /

* Нэмэлт протоколууд: - Зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсэдийг хамгаалах тухай. /1977 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, 60-70-аад оны Вьетнамын дайн, олон улсын болон олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөний гашуун сургамжаас урган гарсан/ гэх мэт.

Өөрөөр хэлбэл Зэвсэгт мөргөлдөөний хууль нь дайн явуулах үйл ажиллагааны зарчимтай холбоотой бөгөөд нэгдүгээрт хүний эрх ашгийг хамгаалах зорилготой Женевийн хууль /1949.08.12/, хоёрдугаарт дайн явуулах арга, хэрэгслийг хориглох, хязгаарлах зорилготой Гаагийн хууль /1899 он/ юм.

Хууль, дүрэм, журмыг батлан

гаргах нь нилээдгүй хэцүү ажил боловч түүнийг амьдралд хэрэгжүүлнэ гэдэг бүр хүнд хүчир ажлын нэг юм.

1907 оны Гаагийн конвенцийн 4 дүгээр зүйлд "хэлэлцэн тохирогч талууд нь одоогийн конвенцид хавсаргасан хуурай газарт дайн явуулах дүрмүүдтэй тухайн улсын зэвсэгт хүчний заавар, дүрмийг уялдуулан боловсруулна" гэж заасан байдаг.

Харин 1949.8.12-ны өдрийн Женевийн конвенцүүд дээрх заалтыг нилээд дэлгэрэнгүй байдлаар тодорхойлсон.

Женевийн 4 конвенцид нэгдэн орсон улсуудад "Энэхүү конвенцийг дайны болон тайван цагт улс орондоо аль болохоор өргөн дэлгэр сурталчилах, тухайлбал түүнийг цэргийн болон иргэний сургуулийн сургалтын хөтөлбөрт тусган, улмаар түүний зарчмыг нийт хүн ам, ялангуяа дайтаж байгаа зэвсэгт хүчин, эмнэлгийн албаны ажилтан, санваартан нарт танилцуулах" үүргийг хүлээлгэсэн байдаг. /Женевийн конвенцүүд 47,48, 127 болон 144 дүгээр зүйл/

Монгол Улсын Их Хурлын 1998 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ЦЭРГИЙН БОДЛОГЫН ҮНДЭСД:

"Монгол Улс үндэсний аюулгүй байдлаа хангах гадаад таатай нөхцөлийг бүрдүүлэх, аливаа дайн, зэвсэгт мөргөлдөөний аюулыг сэрэмжлэн зайлуулах, энх тайванч бодлогоо олон улсын эрх зүйн түгээмэл зарчмуудад нийцүүлэн, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн халдашгүй дархан байдалд цэргийн хүчээр заналхийлсэн, зэвсэгт түрэмгийлэл үйлдсэн улс орон, тэдний энэхүү зэвсэгт түрэмгийлэлд холбоотон нь болж буй этгээдийг дайснаа гэж үзэн, гаднын зэвсэгт түрэмгийллийн эсрэг өөрийгөө хамгаалах зэвсэгт тэмцэл явуулна" гэж заасан.

Энэ нь Монгол Улс аливаа дайн, зэвсэгт мөргөлдөөнд Монгол Улсын болон Олон улсын зэвсэгт мөргөлдөөний хууль, түүний түгээмэл зарчмуудыг баримтлан өөрийгөө хамгаална гэсэн утгыг илэрхийлж байгаа бөгөөд энэ нь олон улсын Зэвсэгт мөргөлдөөний хуулийг ягштал мөрдөх зарчмын чухлыг харуулж байна.

Гэвч үүнийг даган мөрдөхийг хуулиндаа чухалчилсан боловч бидний сайн мэдэх "Байлдааны түр дүрэм БД-1/100, 2/100, 3/100"-д энэ талаар нэг ч үг дурсаагүй, түүнийг тайлбарлан таниулж дэлгэрүүлэх үүргийг гүйцэтгээгүй нь түүнийг амьдралд хэрэгжүүлэх ажилд хайнга хандаж байсныг харуулж байна.

Монгол Улс НҮБ-ын ЭСА-нд үүрэг гүйцэтгэж эхэлснээр Зэвсэгт мөргөлдөөний хуулийн чухлыг ойлгож энэ талаарх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн хөтөлбөрт тусгаж өгсөн нь сайшаалтай томоохон ажлуудын нэг болсон.

Дайн зэвсэгт мөргөлдөөний хуулийг хэлбэрэлтгүй сахин мөрдөж, хэрэгжүүлэн, түүнийг бүс нутагтаа хэвшүүлэн баталгаажуулах явдал манай улсын аюулгүй байдал, батлан хамгаалалтыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой. / А.Сүхбаатар, Н.Энхбаялаг "Дайны хууль, эрх зүйн асуудал" 2010 он 7т/

Цэргийн операци, байлдаанд давшилт, хориглолт, бүслэлт гэх мэт олон төрөл байдгийн нэгэн адил зэвсэгт мөргөлдөөний хуульд тодорхой зарчим байдаг. Эдгээр зарчим нь энгийн бөгөөд мөргөлдөөний бодит байдалд нийцсэн байдаг.

Байлдааны үед цэргийн албан хаагчид биелүүлж, дагаж мөрдөж чадахгүй зарчим гэж байдаггүй. Эдгээр зарчим нь хүмүүнлэг ёс, цэргийн ажиллагааны шаардлага /хэрэгцээ/-ын дундах тэнцвэрийг хадгалж, ямар ч нөхцөл, газар орон, цагийн байдалд хүчин төгөлдөр үйлчилдэг. Өөрөөр хэлбэл байлдааны ажиллагаанд оролцож буй цэргийн албан хаагчид нь өөрийн юу хүссэнээ хийх эрх чөлөө байхгүй гэсэн үг

юм.

Захирагч, дарга, штабын офицеруудын хувьд эдгээр зарчмуудыг мэдэж, ойлгож, түүнийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, хэрэгжилтэнд нь хяналт тавих үүрэгтэй байдаг учир эдгээр зарчмуудыг цэргийн төлөвлөлт, сургалтанд тусгаж байж сая ажил хэрэг, үйлдэл болж Цэргийн албан хаагчид хууль зөрчихгүй байх үндэс суурь тавигдах нь гарцаагүй юм.

Дайны үед цэргийн албан хаагчдын баримтлах уг зарчмуудад:

Ялган таних зарчим:

Цэргийн албан хаагч нь дайтагч болон энгийн оршин суугчдыг ялгаж таних.

Цэргийн албан хаагчид нь дайн, зэвсэгт мөргөлдөөнд оролцож байхдаа цэргийн объектод хөнөөл учруулахаасаа өмнө түүнийг цэргийн объект мөн үү? Эсвэл иргэний объект уу? гэдгийг ялган таньж байх хэрэгцээ шаардлага байсаар байна.

Дайтагч, байлдагч болон цэргийн объектийг ялган таньснаар энгийн иргэд, тэдгээрийн объектийг хөнөөхөөс урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлдэг.

Ялган таних зарчимд үндэслэн ялгавартай хандах зарчимыг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага урган гарч ирдэг. ЗМХ-иар ялгавартай хандах зарчим гэж байхгүй боловч түүнийг хэрэгжүүлэх арга замыг тогтоосон байдаг.

Ялган таних зарчмыг ялгавартай хандах зарчим болгон хэрэглэснээр энгийн хүмүүс, иргэний объектыг хамгаалах, тэдгээрт аль болох бага хохирол учруулах нөхцөл бүрдэх болно.

Тэнцүүлэлтийн зарчим.

Тухайн объектод тохирсон арга, хэрэгсэл хэрэглэхийн оронд хэтэрхий их хэмжээний хүчин чадал бүхий зэвсэг, галт хэрэгсэл хэрэглэн объектийг хөнөөж, өөрт ашигтай цагийн байдал үүсгэж болох боломж бий. Гэвч сөргөлдөгч талдаа асар их хэмжээний хөнөөл учруулснаар түүнд энгийн иргэд олноор өртөж, амь үрэгдэж, шархдах магадлал өндөр байна гэдгийг байнга санаж байх хэрэгтэй. /Энэхүү зарчмыг АНУ-Иракийн дайнд хэрэглэсэн/

Энэ тохиолдолд сөргөлдөгч талын дайчдаас гадна орон нутгийн энгийн иргэд таны эсрэг мөн л эрс шийдэмгий алхам хийж эсэргүүцэн байлдаж байгаа хандлага орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөнд ихээхэн тохиолдож байна.

Сайн төлөвлөлт, хуульд нийцсэн тодорхой хэм хэмжээний хүч хэрэглэх дүрэмтэй байх нь цэргийн мэргэжсэн сургалт, мэргэжлийн ур чадварын үр дүн юм.

Цэргийн ажиллагааны хэрэгцээний зарчим.

Олон улсын хуулиар хориглоогүй арга хэмжээг дайснаа ялахын тулд авч хэрэгжүүлэхийг хүлээн зөвшөөрнө.

Хязгаарлалтын зарчим.

Ямар ч зэвсэгт мөргөлдөөнд талууд байлдаан явуулах арга хэрэгслийг сонгох хязгааргүй эрхийг эдэлдэггүй.

Эрт дээр үеэс хорыг дайснаа хөнөөхийн тулд өргөн хэрэглэж, түүний үр дүнд худаг, усны эх булаг хордож, энгийн иргэд, мал, ан амьтан түүнийг ууснаас олноор хордож үхэж байсан гашуун сургамж бий. Орчин үед ч гэсэн энэ арга нь улам боловсронгуй болж байлдааны ажиллагаанд янз бүрийн зэвсэг хүлээгдээгүй асар их хохиролыг араасаа дагуулах болжээ. /16 төрлийн зэвсгийг дайн, зэвсэгт мөргөлдөөнд хэрэглэхийг хориглосон/.

Хэрэгцээшаардлагагүй тохиолдолд хүмүүсийг тарчлаан зовоох эсвэл хүнд гэмтэл учруулах зэвсэг болон тактикийн арга хэрэглэхийг хориглодог.

Сайн санаа.

Ихэнх тохиолдолд хуулийг хэрэгжүүлэгч нь ЦАХ-ид /дайтагч/ байдаг. ЦАХ-ид ЗМХ-ийг тайлбарлан таниулах, хэрэглэх асуудалд сайн санаагаар хандах нь НҮБ-ын ЭСА-нд оролцох болон бүс нутгийн зэвсэгт мөргөлдөөнд ч энэ байдал өргөн тохиолдох боллоо.

Дайтагч сөргөлдөгч талтайгаа

болон хүмүүнлэгийн байгууллагатай хэлэлцээ хийх, харилцах үедээ сайн санаа, хүмүүнлэг үйлдэл хийснээр маш олон асуудлыг эерэг байдлаар шийдвэрлэдэг бөгөөд сайн санааны үр дагвар нь хэлэлцээр, зуучлал, хамгаалалтын үр дүнгээр илэрч байдагаараа онцлогтой.

Хүнлэг харьцаа, үл ялгаварлах.

Бүх хүмүүстэй хүйс, үндэс угсаа, арьс өнгө, шашин шүтлэг болон улс төрийн үзэл бодлын үндсэн дээр ялгаварлахгүйгээр хүнлэг харьцах ёстой. Бууж өгсөн дайтагч, шархадсан, өвчтэй буюу цэргийн олзлогдогч, бусад хоригдол зэрэг байлдааны ажиллагаанаас гарсан хүмүүсийн харъяаллыг тогтоож, тэдэнтэй хүнлэг харьцах нь байлдааны ажиллагаанд эергээр нөлөөлж улмаар нутгийн оршин суугчид болон байлдааны ажиллагаанд оролцож буй дайтагч нарыг өөрийн талд татах, тэдний сэтгэл зүйд хүчтэй нөлөөлөх зэрэг эерэг үр дагаврыг араасаа дагуулдаг.

Дайн, байлдаанд зэвсэгт мөргөлдөөний хуулийн дээрх зарчмуудыг сахин, дагаж мөрдсөнөөр:

• зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадварыг дэлхий дахинд харуулах:

• улмаар НҮБ болон олон улсын байгууллагаас цэрэг-улс төрийн дэмжлэг авах нөхцөлийг бүрдүүлнэ;

• бие бүрэлдэхүүний ёс зүй, сахилга батыг сайжруулах;

• байлдааны ажиллагааны талбарт болон тухайн улсад энгийн хүн амын дэмжлэг авах;

• харилцан ашигтай байдлаар харьцах, тухайлбал шархадсан, өвчтэй цэргийн алба хаагчид, цэргийн олзлогдсдыг харилцан солилцох;

• улс орнуудын хоорондын харилцааг зохицуулна,

• дайн зэвсэгт мөргөлдөөний үр дагвараар бий болох хохирол, сүйрэл болон, зовоон тарчлаах явдлыг аль болохоор багасгана.

• энхийг бэхжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх /харин зэрлэг балмад үйлдэл нь зөрчлийг улам гүнзгийрүүлж, энхийн үйл ажиллагааг удаашруулдаг/;

• цэргийн үйл ажиллагааны зорилгыг зөвхөн дайсныг хөнөөхөд чиглүүлэх биш харин шаардлагагүй хохирол учруулахаас зайлсхийх зэрэг болно.

Мэргэжлийн цэргийн алба хаагч бүхэнд хууль зайлшгүй хэрэгтэй. Үүнийг зөвхөн хуульчдад даатгаж болохгүй. Тэд бид бүхэнд зөвлөж, туслах боловч зэвсэгт мөргөлдөөний хуулийг дээдлэх, хэрэглэх, мөрдөх зэрэг цогц асуудлын гол үүргийг цэргийн алба хаагчид л байлдааны талбар, байлдааны ажиллагаанд хэрэгжүүлдэг. Орчин үеийн олон улсын болон дотоодын зэвсэгт мөргөлдөөнд уг хуулийн зарчмыг баримтлаагүй тохиолдол нилээдгүй байсан боловч Самоли, Кампучи, Зүүн Тимор, Сьерра-Леон, Югослави зэрэг улс орнуудад явагдсан дайн, байлдаан нь хүн хүнээ хомроглон алах, зовоон тарчлаах ажиллагаа нь жирийн үйлдэл биш түүнийг хуулиар зохицуулан зогсоож болдог жишээг харуулсан нь Зэвсэгт мөргөлдөөний хуулийг ямар ч үед хэрэгжүүлэх боломжтой гэдгийг илэрхийлж байна.

СУРГАЛТ АРГА ЗҮЙ

Н.Алтанзул. ХЦДС-ийн ИБФ-ын багш

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙН ЭНЭ ЗУУНЫ ЗОРИЛГО

ЮНЕСКО болон дэлхийн улс орнуудын дээд боловсролын талаар баримталж дэвшүүлж байгаа үзэл бариmтлал өөрийн орны дээд боловсролын нөхцөл байдал хүрсэн түвшиндээ дүгнэлт хийгээд энэ зуунд дээд боловсролын талаар бариmтлах төрийн бодлого сургууль бүр өөрсдийн зорилтыг тодорхойлж байна.

Шинэ элсэгчдийг дэмжсэн сургалтын тогтолцоог төлөвшүүлэх чадвар чансаандаа тааруулан богино урт хугацаанд суралцаж шалгалтаа өгөх тогтолцоог /кредит/ хэрэгжүүлэх нөхцөлд шинээр элсэгчид дунд сургуулиас тэс өөр нөхцөлд орж байна.

Их дээд сургуульд оюутан сайн сурах үндэс суурь анхны жилээс ихээхэн шалтгаалах учир тэдэнд зориулсан тодорхой зорилго чиглэлтэй арга ажиллагааг хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна. Тухайлбал: сурах арга барил эзэмшүүлэх, зөвлөгөө өгөх зөвлөх багш томилон ажиллуулж болох юм.

1. Мэргэжил хоорондын холбоог бэхжүүлэх

Мэргэжил хоорондын зааг, ханыг аль болохоор арилгаж, мэргэжлүүдийн уулзвар ухааныг хөгжүүлэхэд онцгой анхаарах хэрэгтэй байна. Инженерийн ухааныг эдийн засгийн менежмент, хүрээлэн байгаа орчинтой холбоотойгоор судлах байгалийн шинжлэлийг нийгмийн ухаантай хослох зэргээр олон мэргэжлүүдийн уулзвар эрдэм судлалыг хөгжүүлж мэргэжлийн нарийн зааг хязгаарыг арилган, уян хатан, хэрэгцээнд түшиглэсэн хөрвөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх бүтцийг бүрдүүлэх шаардлага энэ зуунд тавигдах болно.

2.Судалгаанд түшиглэсэн сургалтын дэг жаяг /стандарт/ болгох

100 жилийн өмнө АНУ-ын боловсролын нэрт эрдэмтэн Жон Дивэн хэлэхдээ: " Сургалт бол мэдээлэл дамжуулахаас илүү багшийн удирдлагын дор суралцагч нээлт хийх"- ийг чухалчлан заасан байдаг. Хэрэгцээнд тулгуурласан сургалт нь багш оюутны хамтын ажиллагаа бөгөөд багш ч оюутнаасаа сурах тохиолдол гарч болно. Нөгөө талаас ШУ-ны чухал санаа зөвхөн хүний бүтээл байхаасаа хамтын хөдөлмөрийн үр дүн байх нь өнөө үеийн онцлог болж байна.

АНУ-ын ШУ-ны академийн ерөнхийлөгч Брус Албертс "багш оюутны хамтран санаа бодлоо уралдуулах" нь дээд сургуулийн бүтээмжийг нэмэгдүүлэх, багш оюутны хоорондох оюуны саадыг даван туулах чухал ач холбогдолтой гэж хэлсэн байдаг. Их сургуулиуд багш сургалт явуулахын зэрэгцээ судалгаа хийхийг дэмждэг. Учир нь судалгаа хийдэг багш бол зөвхөн бусдын нээсэн мэдээллийг дамжуулахаас гадна гол төлөв мэдлэгийг нээх, хэрэглэх талаар ихээхэн туршлага хуримтлуулсан байдаг. Ийм учраас дээд сургуульд элсэн орсон цагаас оюутныг судалгааны ажилд оруулах замаар өөрийгөө нээх боломж өгөх нь энэ зууны дээд боловсролын нэг зангилаа асуудал болж байна.

3. Мэдээллийн технологийг үр бүтээлтэй хэрэглэх

Хөрөнгө хүч хомс манай орны хувьд мэдээллийн технологийг дээд боловсролд үр бүтээлтэй ашиглах нь

дээд боловсролын эцсийн үр дүнд онцгой ач холбогдолтой. Мэдээллийн технологийн дэвшил шинэчлэл боловсролын салбарт өргөн боломж нээж өгч байна. Мэдээллийн технологийн ачаар монголын төдийгүй дэлхийн нэрт эрдэмтдийг өөрийн анги танхимд авчран багш, оюутантайгаа уулзуулах, хичээл заахдаа мэдээллийг бүх төрлийн аргаар дамжуулан богино хугацаанд эзэмшүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой.

4. Багшийг урамшуулах тогтолцоо, аргыг өөрчлөх

Дээд сургууль нь сургалт, судалгааны талаар өндөр стандартад хүрэхийн тулд сургалтын эрх чөлөөт байдлыг бүрэн хүлээн зөвшөөрч багшийг урамшуулах өвөрмөц тогтолцоог бий болгох хэрэгтэй.

1895 онд Чикагогийн их сургуулийн анхны ерөнхийлөгч Уилъям Р.Хапер шинэ багштай гэрээ байгуулахдаа албан тушаал дэвших цалин хөлс нэмэхийг зөвхөн судалгааны ажлын үр дүнгээс хамааруулна гэж зөвшөөрүүлж байжээ.

Өнөөдөр Монголын дээд боловсролын хөгжлийн бодит шаардлагыг авч үзвэл их дээд сургуулийн судалгааны ажлын түвшин цар хүрээг өргөтгөх зайлшгүй нөхцөл байдал тулгарч байна. Ийм учраас багш нараас судалгааны ажил хийх нөхцөл боломжийг бүрдүүлэх, тэдний хөдөлмөрийн бүтээлийг үнэлэх, урамшуулах системийг цоо шинээр авч үзэж тодорхойлох шаардлага гарч ирж байна. Сургалтын эрх чөлөөт байдлыг хангах талаар багшийн тусгай эрхийн хүлээн зөвшөөрдөг дэлхийн олон оронд хэрэглэдэг арга механизмыг ч бид судалж хэрэглэж болох юм.

5. Их дээд сургууль өөрийн гэсэн дүр төрхийг бүрдүүлэх

Их дээд сургууль бүрийн хувьд түүх, уламжлалын талаар өөр өөрийн гэсэн үзэл баримтлал бий. Тухайлбал, их сургуулиудын хувьд судалгааны чадавхыг нэмэгдүүлж, улс үндэстний хөгжилд оруулах хувь нэмрээ дээшлүүлэх, байр сууриа бэхжүүлэх зорилт тулгарч байхад дээд сургуулиудын хувьд эх орондоо төдийгүй дэлхийн түвшинд хүрсэн мэргэжилтэн бэлтгэх зорилт анхаарлын төвд байна.

6. Дээд сургуулийг сурч боловсрох орчин болгох

Дээд сургууль нь зөвхөн оюутан нь сурч боловсрохоос гадна багш нь тэр ч байтугай тухайн орон нутгийн ард иргэд сурч боловсрох дэд бүтэц, орчин болж өргөжин өөрчлөгдөх ёстой болж байна.

7. Харилцааны соёл, баг болж ажиллах чадварыг хөгжүүлэх

Шинжлэх ухаан, технологийн өнөө үед нэг хүний үүрэг ролиос хамтын бүтээл, зүтгэл, амжилтын эх үндэс болж байна. Ийм учраас дээд сургууль нь баг болон хамтран ажиллах чадвартай, харилцааны боловсон соёлтой мэргэжилтэн бэлтгэхэд илүү анхаарах нь зах зээлийн өнөөгийн хэрэгцээ, нийгмийн шаардлага болж байна.

8.Их дээд сургуулийн багш бэлтгэх

Баклавраас дээш шатны зэргийг сургалт, судалгааны ажлыг хослуулан олгодог дэлхийн нийтлэг зарчмыг хэрэгжүүлж эхлэх гэж байгаа өнөө үед болгоомжлол, үл ойлгох байдал нилээд байна. Мастер, докторын сургалтыг бий болгосноор юуны өмнө дээд сургуулийн багшлах боловсон хүчний нөөц бэлтгэх, цаашилбал судлаач эрдэмтдийн халааг бэлтгэх шинэ мэдлэг, мэдээлэл бий болгох, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, улмаар үндэсний хөгжил дэвшилд түлхэц үзүүлэх өргөн боломж нээгдэнэ. Мэдээжээр ийм сургалтыг багшлах боловсон хүчин, лабораторийн бааз, эрдэмтэд судлаачтай их сургуулиудаа түшиглэн гадаадын их сургуулиуд, санхүүгийн байгууллагуудын оролцоотой хамтран хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна.

Бүх хараат байдал мэдлэгийн хомсдолоос үүсэлтэй хараат байдал байдаг учраас төрийн дээд түвшинд

мэдээлэл хүртээж тусалж байдаг эрдэмтэн судлаачдын багийг бүрдүүлж шинэчилж байх явдал чухал билээ. Иймээс сургалт чанаргүй байгаа гол шалтгаан нь: Сургалт цаг үеэсээ хоцорч байна. Учир нь хүүхэд хэвлийдээ ухаажаад гарч байхад боловсрол түүнээс хоцорч байна.

- Монгол хэлээ мэдэхгүй, эх орныхоо хөрс шорооноо хөндийрсөн хүмүүс сурах бичгэрхүү хадмал орчуулгаар ном хийж байна.
- Багш нар залуужиж туршлагагүйтэн залхаах аргаар хичээл явагдаж байгаагаас боловсролоос суралцагчид хөндийрч байна.
- Мэдлэгийг /боловсролыг/ биет байдал болгон өөрчлөхийг үйлдвэрлэл гэдэг болохоор бүтээж сургахад боловсролын өөрчлөлтийг чиглүүлэх
- Мэдлэгийг /боловсролыг/ хүнд ашигтайгаар хүртээхийг үйлчилгээ гэдэг учраас хүн рүү нуруугаа биш нүүрээ харуулж тусалж дэмжих сэтгэлгээг хүн бүрт төлөвшүүлэхэд боловсролыг залж удирдах хэрэгтэй байна.
- Боловсролыг бүтээгдэхүүн ажил үйлчилгээнд шингээх арга ажиллагааг технологи гэдэг утгаар нь аж үйлдвэрийг хөгжүүлэх явдал чухал юм.

ХИЛИЙН ТҮҮХ

И. Саруул. МУИС-ийн профессор, доктор

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТҮҮХИЙН ҮЕЧЛЭЛИЙН ТОЙМ

Эн тэргүүнд тус сэтгүүлд өгүүллийг минь нийтлүүлж байгаад ХЦДС-ийн захирал, хурандаа Д. Дашдаваа, тэргүүн захирал бөгөөд сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга, хурандаа Ц. Ганболд, хурандаа А. Муратхан, ахмад О.Нэмэхханд нарт талархсанаа илэрхийлье. "Хил судлал" сэтгүүл бол төрөлх эх орон, манай төр улсын хилийн судалгааны төв, эрдэмтэн судлаачдыг нэгтгэсэн индэр болсонд амжилт хүсье.

Төр улс оршин тогтнож бүхий цагт түүний төрөлх нутаг дэвсгэр, эргэн тойрны хүрээлсэн хилийн шугам бүрэлдэн тогтсон сэдэв ямагт амин чухал бөгөөд ард түмэн, төр засгийн анхааралд оршино. Манай гариг ертөнцийн улс бүхэн эх дэлхийнхээ хаа ч байрласан бай өөрийн суугуул газар нутагтай, тэр нь эргэн тойрондоо улсын хилийн шугамтай байна. Тухайн улсын тусгаар тогтнолын үзүүлэлт, оршин тогтнохын үндэс суурь, олон улсын эрх зүйн бүрэн эрх эдлэх эн тэргүүн зарчим юм. Иймд улсынхаа нутаг дэвсгэр, хилийн түүхийг судлах явдал улс орнуудын судлаачдын шинжлэх ухааны чухал чиглэл болно. Тэдний шинжилгээ судалгааны үр дүн болсон хилийн түүх ард түмэн хийгээд хилчдийг эх орон ч хүмүүжил, ухамсрыг нь төлөвшүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэнэ.

Манай хилийн түүхийн судалгааны үечлэл, шатлалын асуудал өнөөг хүртэл тодорхойгүй явжээ. Гардаж ажилласан, эсвээс санал дэвшүүлсэн судлаач хараахан үгүй. 2006 онд Монгол улсын хөдөлмөрийн баатар, гавъяат хилчин, дэслэгч генерал, хилийн түүхийн эцэг хэмээн алдаршсан Базарын Цэдэн-Иш гуайн 100 насны эрдэм шинжилгээний хурлын индрээс энэ санаагаа анх дэвшүүлэх бололцоо олдсон юм . Тэгэхэд орчин цагийн хил судалгааны үеийн дөрвөн шатлалын асуудлыг тэмдэглэж байсан билээ. Харин тус өгүүлэлд нийт хилийн түүхийн судалгааны үечлэлийг дэвшүүлж байна.

Монгол улсын хилийн судалгаанд дараах хоёр үе тодорно. Үүнд: 1. Монгол улсын эрт ба дундад үеийн хил судлал; 2. Орчин цагийн хил судлал хамаарна. Эхний үед: 1. Монголын эртний улс гүрнүүдийн хил хязгаар; 2. Монголын эзэнт улс ба бутралын үеийн хил хязгаарын судалгаа; 3. Манжийн дарангуйллын үеийн хил хязгаар гэсэн гурван шатыг агуулна. Хоёрдох үед: 1. Олноо өргөгдсөн Монгол улсын үеийн хил хязгаар; 2. Ардын засгийн үеийн хилийн судалгаа; 3. Социализмын байгуулалтын үеийн хилийн судалгаа; 4. Ардчилсан нийгмийн үеийн хилийн судалгаа гэсэн дөрвөн шатлал байна.

Монголын эртний улс гүрнүүдийн хил хязгаарын судалгааны шатанд эн тэргүүнд анхны Монголын Хүннү Улс байгуулагдсан явдал хамгийн чухал үйл явдал бөгөөд дэлхийн анхны төр улсын нэгэн болсон юм. Тэр цагт Хүннү, хятадын Хан хоёр улс харилцан эн тэнцүү хэмээн бие биенээ зөвшөөрөн хүлээсэн байдаг. Мөн хоёр улсын заагийг Түмэн газрын цагаан хэрмээр тогтоосон нь энэ хорвоогийн хамгийн анхны тов тодорхой хилийн шугам юм. Европ дахинаа 1659 онд Франц, Испаний хооронд байгуулагдсан Пиренейн уулсын хилийн шугамыг хүн төрөлхтний анхны хилийн шугам гэж үзэх хандлага бий. Гэтэл түүнээс өмнө манай тооллын өмнөх II зууны эхэнд Пелопоннес, Аттик

хоёр улсын хооронд хил тогтоосон түүх бас тодорхой юм . Энэ талаар хурандаа Б. Бат-Эрдэнэ, хурандаа А. Муратхан бид гурав хамтран "Хүннү улсын нутаг дэвсгэр, хил хязгаар, харуул хамгаалалт" товхимол нийтлүүлсэн билээ. Түүнд: - "Түмэн газрын цагаан хэрмийн хилийн шугам хорвоод юутай ч харьцуулшгүй, байгалийн байц буюу газарзүйн зааг, нүүдэлчин суурьшмал соёл иргэншил буюу угсаатан үндэстнийг салгасан зааг, Төв Азийн улс төр буюу хөрш улсын төр улсын зааг бүхий гурамсан шинжийг нэгэн зэрэг өөртөө агуулж буй ийм тодорхой хилийн шугам хүн төрөлхний түүхэнд дахин үл давтагдах болбуу" хэмээн тэмдэглэсэн билээ. Дашрамд хэлэхэд хилчдийн өдрийг 9-р сарын 17-нд тэмдэглэдэг нь орчин цагийн хилчний баяр мэт олонд ойлгогддог. Угтаа Монголын хилийн цэрэг Хүннү улсын цагт хилийн шугам тогтооход хамт байгуулагдсан түүхтэй. Монгол улсын түүхэнд ингэж л бичигдэж тэмдэглэгдсэн. Мөн дээр бичсэн бидний Хүннүгийн үеийн хилийн тухай бүтээлд бүр тодорхой өгүүлсэн бий. Саяхан тус "Хил судлал"-ын сүүлийн дугаарт нэгэн нөхөр бас энэ санааг гаргасан нь уг асуудал дэвшигдсэн хэвээр л байгаа бололтой байна. Иймд улсын хил, хилийн цэрэг тэртээ 2220 жилийн бүрэлдэж байгуулагдсан агуулгыг нь тод томруун гаргаж, зөвхөн хилчдийн бус, тусгаар тогтнолын баяр мөн, нийт ард түмнээрээ тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Зарим улс төрч, судлаачид Монгол улсын хилийн түүхийн судалгаа 1990 оноос хойш эхэлсэн гэж үзсэнтэй санал нийлэмгүй. Хэтэрхий хожуу хийгээд өдгөөчилсэн нь тохиромгүй, угтаа ч тийм бус. Манай тооллын өмнөх 198 онд Хүннүгийн төр улс байгуулагдаж, хамгийн анхны хилийн шугам Түмэн газрын цагаан хэрмээр татагдсанаас хойш өдгөө 2220 жилийн ойг энэ оны 7-р сард улс орон даяр ёслол төгөлдөр тэмдэглэнэ. Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор анхлан ёслож байгаагаараа онцлогтой. Энэ их ойд зориулж миний бие Монголын маркийн холбоотой хамтран Хүннү улс гэсэн марк зохиож, түүндээ Монгол улсын анхны хилийн шугам буюу Түмэн газрын цагаан хэрмээр тогтоож буйг тусгасан болно. Тэгэхлээр Монгол улсын хил судлал эртний хөгжил арвинтай бөгөөд өнөөдөр мэргэжлийн эрдэмтэдтэй, Монгол улсын түүхийн шинжлэх ухааны бүхэл бүтэн салбар ухаан болон төлөвшжээ.

Дараагийн хил тогтоосон ажиллагаа Монголын эзэнт улсын бутралын үед хамаарна. 1740 оны Зүүнгарын улс, манжийн Чин хоёр хөршийн хооронд байгуулсан хилийн гэрээ бол Монгол улсаас гадаад улстай байгуулсан хоёрдох хилийн шугам юм. Тус гэрээгээр Алтайн нурууны ус хагалбараар хил байгуулсан бөгөөд манжийн талыг төлөөлж биечлэн оролцсон Сайн ноён хан, хошой эфү Цэрэн нар "Алтай бол Тэнгэрийн хил" гэж өргөмжилсөн тухай зохиогч "Алтайн нурууны Тэнгэрийн хил" шинжилгээний өгүүлэлдээ тодорхой бичсэн болно.

Ер нь дундад зууны үед монголчууд хилийн шугамаа газар дээр нь байнга шалган тодотгож, холбогдох баримт бичиг үйлдэн сайтар хадгалж иржээ. Баримт бичгээ дээш өргөж давхар хадгалуулна. Манжийн дарангуйллын цагт Чин улсын засгийн газар мөн хилийн баримтуудыг тусгайлан хийлгэж авч байсан байна. Манай улсын архивын сан хөмрөгт эдгээр газрын зураг, хилийн овооны цэс, хилийн шугамын явалт зэргийг тусгасан сурвалж баримт цөөнгүй хадгалагдаж буй. Эдгээр газрын зургийн онцлог нь монгол газрын зураг зүйн дүрслэлийн уламжлалт арга буюу уул нуруу, ой модыг перспектив дүрслэлийн аргаар, суурин газруудыг тойргоор (геометрийн тэмдгийн арга), гол мөрөнг зураасаар (шулуун шугамын арга), далай тэнгисийг долгиолсон зураасаар (ареалын арга – тэмдгэн дүрслэлээр), хэрмийг зурган шулуун таних тэмдгээр тус тус үзүүлжээ. Аймаг хошуудын зураг дээр уул нуруу хажуу бэлээс нь, оройг нь харж зурсан, ой мод, хад чулуу шууд дүрсэлж Монгол зургийн маягаар өнгө ялгаж тэмдэглэж байсан бол усыг дан хөх өнгөөр, сүм хийд, суурин газрыг нэг сүмээр, хошуу тамгын газрыг нэг гэрээр төлөөлүүлж зурж

байжээ . Эдгээр баримтуудыг үндэслэн доктор Б. Цэдэн-Иш "Монгол улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс" бүтээлээрээ Шинжлэх академийн Түүхийн хүрээлэнгийн эрдмийн зөвлөлд докторын зэрэг хамгаалсан билээ. Уг бүтээл цаг үедээ хаалттайд тооцогдсонч өнөөг хүртэл түүний баримтлалыг хилийн түүхэнд баримтласан хэвээр бөгөөд төрсөн хүү хурандаа Ц. Энхжаргал ардчиллын цагт дахин хэвлүүлж олны хүртээл болгосон билээ. Миний бие уг бүтээлийг бүтээлцэхэд нь баримт сэлт сурвалжлах зэрэг ажилд нь оролцсондоо бахархаж явдгаа анх удаа хэлсэндээ баярлаж сууна.

Хилийн судалгааны хоёрдох үе буюу Орчин цагийн хилийн түүх үндсэндээ XX зууны эхэн, тодруулбал 1911 оноос өнөөг хүртэлх хугацааг хамаарч буй. Дээр хэлсэн ангиллыг зохиогч дотор нь дөрвөн шатлалд авч үзсэн юм. Анхаарууштай нь шат болгон өөр өөрийн хөгжлийн зорилгын ялгаатай тул Олноо өргөдсөн Монгол улс, Ардын засгийн, Социализмын, Ардчилсан нийгмийн гэх мэтээр томъёолсон болно. Тухайн цаг үеийн Төв Азийн улс төрийн харилцааны байдал, мөн Монгол улсын дотоод төр улсын тогтолцооны онцлог байдалтай шууд холбоотойн дээр тухайн нийгмийн тогтолцоо хүчтэй нөлөөлөлж ирсэнтэй уялдаатай.

Олноо өргөдсөн Монгол улсын хилийн холбогдолтой архивын баримт сурвалж Түүхийн төв архивт арвин хадгалагдаж байна. Үндсэн хэрэглэгдэхүүн нь 1912 оны Монгол, Хаант Орос улсын хэлэлцээ, 1913 оны Хаант Орос, Дундад иргэн улсын хэлэлцээ, мөн 1915 оны Хаант Орос, Дундад иргэн улс, Монгол улс гурван этгээдийн Хиагтын гэрээ баримтууд чухал юм. Эдгээр нь бүрэн эхээрээ олны хүртээл болсон бөгөөд Хиагтын гурван улсын хэлэлцээрийн өдөр тутмын тэмдэглэлийг доктор О.Батсайхан бүрэн эхээр нь кирилл үсэгт хөрвүүлэн хэвлүүлжээ . Уг тэмдэглэлийг тэр болгон хүмүүст үзүүлдэггүй байсныг 1989 оны 1-р сарын 1-нээс нээлттэй болгоход нь үзсэн анх үзэж, диссертацийнхаа ажилд өргөнөөр ашигласан, дараагаар нь "XX зууны эхэн үеийн Монголын нутаг дэвсгэр" номоо 2005 онд олны хүртээл болгосон билээ. Тухайн үед зэргэлдээх хөршүүд Монголын эртний суугуул Или, Тарвагатайгаас Ляодун (Солонгосын хойг), Байгаль их далайгаас Түмэн газрын цагаан хэрэмд тулсан асар өргөн уудам нутгийг одоогийн Монгол улсын нутаг дэвсгэрээр хязгаарлажээ.

Ардын засгийн ба социализмын байгуулалтын үеийн хилийн судалгаа нь төрийн нууц сэдэвт тооцогдож, гагцхүү төр улсын захиалгаар судлагдаж байсны улмаас олон түмнээс хаалттай, тэр болгон судлаачид түүнд хүрч чадахгүй байв. Энэ байдал Монголд хилийн түүхийн судалгаа 1990 он болтол байгаагүй юм шиг дүгнэлтэнд зарим нөхдийг хүргэсэн биз ээ. Тэхдээ Монголын түүхийн судалгааны хүрээнд үндсэндээ судлагдаж, олон сайн бүтээл хэвлэгджээ. 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын дараахан Монгол улсад Судар бичгийн хүрээлэн, Газар зүйн судалгааны кабинет байгуулагдаж түүх, газар зүй, хэл шинжлэл түлхүү хөгжих болсонтой холбоотойгоор хилийн түүхийн судалгааны суурь тавигджээ. Тухайн үед хилийн түүхэнд холбогдох бүтээлүүдийг дурдваас: - Б. Бат-Очирын "Монголын эртнээс уламжлагдан ирснийг товчлон тэмдэглэсэн бичиг" , Н. Магсаржавын "Монгол улсын шинэ гарсан түүх" , Б. Буянчуулганы "Монголын бүх газар нутаг" зэрэг бүтээлүүд хэвлэгдэж, тэдгээрт хилийн түүх, газар зүйн асуудлууд хөндөгдөж, хил хязгаарын цэс, газар усны нэрс тэмдэглэгдсэн байна.

Судар бичгийн хүрээлэнгийн Газар зүйн кабинетэд ажиллаж байсан, монголчуудын дунд Шар Дамдинсүрэн хэмээн алдаршсан А.Д. Симуков Монголын бүх аймаг орноор экспедици удирдан очиж, судалгааны ажлыг газар дээр нь биечлэн тандсаны үндсэн дээр 1934 онд "БНМАУ – ын газар зүйн атлас" , 1936 онд "БНМАУ-ын эдийн засгийн атлас"-ыг тус тус зохиожээ. Эл зургууд нь олны дунд "Симуковын ногоон" хэмээн алдаршиж, зөвхөн танин мэдэхүйгээр хязгаарлагдахгүй улс төр, хилийн шугам, хилийн түүхийн асар их ач холбогдолтой юм. Өнөөгийн Монгол

улсын нутаг дэвсгэрийн хэмжээ, хил хязгаар, газар усны нэр, байршил зэрэг чухал мэдээлэл агуулсан шинжилгээний чухал хэрэглэгдэхүүн болсоор байна. Мөн хилийн үйл хэрэгт биечлэн оролцсон хүмүүс үзсэн харснаа бичиж тэмдэглэсэн, түүхэн сурвалж баримт сэлтийг цуглуулан эмхлэн цэгцлэх, судалгааныхаа үр дүнгийн дээжийг тоймлон гаргаж, бүхэлдээ хилийн судалгааны эхлэл буюу үндэс суурийг тавьжээ.

Социализмын хилийн судалгаа 1949 оноос хойш манай оронд үндэсний түүхч мэргэжилтэй боловсон хүчний эрин эхэлсэнтэй зэрэгцэнэ. Тэрээр Монголын түүх судлал, түүх бичлэг улам далайцтай хөгжиж өнөөгийн түвшинд хүрч ирэхэд шийдвэрлэх ач холбогдолтой байв. Чухамхүү 1950-иад оноос хойш монгол түүхчид ерөнхий (дэлхийн) түүх, Монгол улсын түүх, түүхийн салбар ухаан, тэр дундаа хилийн түүхээр ажиллаж эхэлсэн билээ. Энэ үед хилийн судалгаанд тодорхой ач холбогдол бүхий олон дорвитой бүтээл гарснаас дурдвал:- 1954 онд монгол, зөвлөлтийн эрдэмтдийн хамтарсан "БНМАУ-ын түүх" нэгэн боть бүтээл хамгийн анх гарчээ. Тус ном нь судалгаа шинжилгээний ололтуудын үр дүнг харгалзан 1966, 1984 онд дахин хэвлэгдсэн билээ.

Түүхчдийн нөр их судалгааны ажлын үр дүнд монгол түүхчдийн бие даан гаргасан "БНМАУ-ын түүх" гурван боть зохиол 1966-1969 онд хэвлэгджээ. Энэ зохиолыг дэлхийн монголч эрдэмтэд талархан хүлээн авч зарим ботиудыг өөрийн хэлнээ орчуулж байсан нь Монголын түүх бичлэгийн төвшнийг дэлхий дахинаа зөвшөөрөн хүлээсэн байна. Энэ үед манай ахмад түүхчид Монголын эрт, дундад үеийн түүхийн зангилаа асуудлаар томоохон суурь бүтээлүүд туурвисныг тэмдэглэх хэрэгтэй. Д. Гонгорын "Халх товчоон" , Н. Ишжамцын "Монголын феодализмын нэгдсэн улс байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь" , Х. Пэрлээгийн "Хятан нар тэдний Монголчуудтай холбогдсон нь" (11), Н. Сэр-Оджавын "Монголын эртний түүх" зэрэг бүтээлүүдийг дурьдууштай. Тэд Монголын эрт, дундад зууны Монголын нутаг дэвсгэр, хил хязгаар, харуул хамгаалалтын зохион байгуулалт зэрэг олон асуудлыг шинээр гаргаж тавьжээ. Академич Н. Ишжамцын "Хилийн түүхийн найруулал" зохиол нь 1962 онд бичигдэж, тухайн цагтаа хаалттайн улмаас хэвлэгдсэнгүй хадгалагджээ. 1962 оны монгол, хятадын хилийг тогтоох бэлтгэл ажилтай холбоотой хийгдэхдээ одоогийн Монгол улсын өмнөд хилийн түүхэн үндэслэлийг мэрэгжлийн түвшинд гаргасан анхны бүтээл юм. Зохиогч чадваас энэ онд багтаан олны хүртээл болгох бодолтой сууна. Эдгээр зэрэг бүтээл нь шинжлэх ухааны хамгийн сүүлийн ололт амжилтанд тулгуурласан, тухайн үеийнхээ монголын түүх бичлэгийн оргил бүтээлүүд байлаа. Учир нь урьд өмнө тавигдаж байгаагүй шинэ сэдвүүдийг судалсан баримтууд энд орсон, мөн Монгол улсын хилийн түүхийн асуудлууд ч судалгаа нотолгоотой, түүхэн үе шатаараа тэмдэглэгдсэн явдал чухал болжээ.

Хилийн түүхийн судалгааны ажлын гол үндэс нь тусгайлсан байгууллага буюу зориулалтын институт байх шаардлагатай байдаг. Тэгвэл 1982 онд Хилийн ба дотоодын цэргийн удирдах ерөнхий газар дээр байгуулагдсан Хилийн судалгааны групп чухал ач холбогдолтой байв. Хилийн судалгааны төвийг Б. Цэдэн-Иш гуай байгуулж, бүхий л ажлыг нь удирдан чиглүүлж байлаа. Тус төвд Монгол улсын хилийн түүх, газар зүйд холбогдох 200-300-гаад жилийн тэртээгээс эхлүүлэн өнөөг хүртлэх хилийн түүхийн сурвалж хэрэглэгдэхүүн, газрын зураг, хилийн овооны цэс, данс, хэлэлцээ зэрэг тэргүүтнийг Улсын Нийтийн Номын Сан, Улсын Түүхийн Төв Архив, Геодези зураг зүйн газар, Гадаад явдлын яамны архиваас сурвалжлан цуглуулж, тусгайлсан бэсрэг хилийн архивыг бүрдүүлсэн явдал үндсэндээ хилийн түүхийн төв байгууллага болж байсан билээ. Үүний хамт хилийн түүх, гэрээ хэлэлцээрүүдийг шинэ үсэгт хөрвүүлэх, түүхэн хилийн шугамын явалт, овоонуудын байршил, эртний хил тогтоох журам, харуул хамгаалалттай холбоотой анхны бүтээлүүдээ хэвлэлтэнд бэлэн

болгосон боловч тухайн цагт хаалттай сэдэвт тооцогдож байсны улмаас дарагдсан гэлтэй. Хилийн түүхийн группийн ажилтнууд хилийн отряд, застав, анги салбаруудаар явж уулзалт ярилцлага, лекц унших зэрэг ажлуудыг тогтмол явуулж, эх орон ч хүмүүжил, хилчний үзэл баримтлалыг төлөвшүүлэх замаар хилчний ухамсрыг бүрдүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэсэн нь зохих үр дүнгээ өгсөн билээ.

Хилийн түүхийн группт хурандаа Н. Санжаа, дэд хурандаа Дамчаабадгар, дэд хурандаа Б. Ламжав, ахлагч Б. Саранчимэг нар зүтгэсэн гавъяатай билээ. Эдний хийсэн нэг томоохон ажил бол хилийн түүхэнд холбогдох сурвалж бичгүүдийг кирилл үсэгт хөрвүүлэн эмхэтгэл болгон бэлтгэсэн. Түүнийг Б. Цэдэн-Иш гуай редакторлан 1990 онд "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хил хязгаар бүрэлдэн тогтож ирсэн түүхэн сурвалж баримт бичгүүдийн эмхэтгэл" хэвлэгджээ. Тэдний ажилд монголын нэрт эрдэмтэд болох ШУА-ийн академич Н. Ишжамц, доктор Б. Гунгаадаш, Д. Бадамжав, Хилийн ба ДЦУЕГ-ын штабын дарга хошууч генерал Дашдаваа, Геодези зураг зүйн газрын дарга асан Рагчаа, Гадаад явдлын яамны туршлагатай дипломатч Г. Нямдоо, Ж. Ганибал, япон хятад хэлний нарийн мэдлэгтэй Алмас нар уг төвийн ажилд мэргэжлийн зөвлөлгөө өгч хамтран ажиллаж байв. Тэд цөм 1960 оноос Б. Цэдэн-Иш гуайн удирдлаган доор 1962, 1976, 1979, 1983 оны ЗХУ, БНХАУ-тай хил тогтоох, дахин шалгах комисст удаа дараалан оролцсон туршлагатай хилийн мэргэжилтнүүд юм. Өөрөөр хэлбэл, хилийн судалгааны төв мэргэжлийн чадварлаг боловсон хүчинтэй, шинжилгээ судалгааны төв байгууллага болсон байв. Хилийн түүхийн группыг мэдэхгүй байгууллага, хүмүүс гэж үгүй, хилийн судалгааны талаар байнга харилцаж, хамтарч байсан нь нэр хүндтэй байгууллага болж чадсаны илрэл юм.

Яг энэ үед 1983 онд Б. Цэдэн-Иш гуай "БНМАУ-ын хил хязгаар бүрэлдэн тогтсон нь" бүтээлээ дуусгаж, түүний зөвхөн өмнө зүгийн хилийн түүхийн хэсгээр 1984 онд дэд эрдэмтний зэрэг хамгаалсан билээ. Диссертациа ном болгон гаргахад цаг үеийн байдлаар зөвхөн албан хэрэгцээнд тараагдсан юм. Тус ном хилийн түүхийг нарийвчлан нягталсан хоёр дахь шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл юм.

Ардчилсан нийгмийн нээлттэй тогтолцоонд шилжихийн хамт хилийн судалгаа шинжлэх ухааны бие даасан салбар болон хөгжсөнөөрөө онцлог юм. Социализмын цагт хилийн асуудал хаалттай байсан нь ардчиллын цагт нээлттэй сэдэв болж, уг сэдвийг судлахад марксист-ленинист формацийн ангич, намч онол, арга зүйн суртал халагдан, оронд нь эх оронч баримтлал тогтсоноор тэр болгон судлаачид хүрч чадахгүй нөхцөл нэгэнт өнгөрчээ. Монголын нийгэм нээлттэй болохын хамт үндэсний эрдэмтэн судлаачид хилийн түүхийн сэдвийг чөлөөтэй хөндөж, шинжилгээнийхээ гол объектоо болгон судлах болов. Тэгэхдээ судалгааны тодорхой чиглэлээр задлан нягтлах юм уу? Монголын түүхийн хөгжлийн үе бүрийн улс төрийн нөхцөл байдлаар нь лавшруулж эхэлснийг тэмдэглэх нь зүйтэй. Тэд төрөөс хэрэгжүүлсэн хил хязгаарын талаар баримтлах бодлого, хилийн хэлэлцээ, гэрээ, хамгаалалт, хил шалган баталгаажуулах зэрэг сэдвүүдийг түлхүү авч үзэх болжээ. Монголын хилийн түүх судлаачдын дийлэнх нь Б. Цэдэн-Иш гуайн шавь залгамжлагчид, эрдэм шинжилгээний байгууллага болон хилийн цэрэгт зүтгэж яваа эрдэмтэн судлаач нар болно.

Ардчилсан нийгмийн буюу 1990 оноос хойших 15 жилийн хугацаанд хилийн түүхийн чиглэлээр хамгийн олон бүтээл гарсан. Тэдгээрээс дурдвал: Юуны өмнө 2003 онд Б. Цэдэн-Иш гуайн "Монгол улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүх" бүрэн эхээрээ хэвлэгдэн гарчээ. Миний мэдэхээр хүмүүс ийм зохиол байдаг гэж ярьдаг боловч шинжлэх ухааны чухам ямар бүтээл вэ? гэдэг талаар ярьдаггүй. Тиймээс хэдэн зүйл хэлэх байна. Үүнд, уг бүтээл нь: - Түүхийн шинжлэх ухааны онол, арга зүйн ёсоор бичигдсэн, тэхдээ тоочин бичих аргыг түлхүү баримталсан нь хилийн түүхийг тодорхой болгожээ; - Одоогийн

Монголын хилийн түүхийг дундад зууны үеэс нь улируулан авч үзсэн; - Хилийн үйл явдлын он цагийг тодорхой тогтоож, дэс дарааллаар жагсааж, тэдгээрт судлаачийн байр сууринаас нарийн дүгнэлт гаргалга хийсэн; - Хилийн түүхийн янз бүрийн үзэгдлийн шалтаг шалтгааны холбоос, тайлбарыг тун оновчтой, үнэн бодитой, нотолгоо баталгаатай болгожээ; - Судалгааны эх сурвалж нь дотоод, гадаадын архивын үнэт баримт бичгүүд юм. Тэдгээрийг эрэн сурвалжлах, цэгцлэх он удаан жилийн нарийн нягт ажиллагаа, байнгын эрэгцүүлэл зэрэг судлаач хүний нөр их хөдөлмөр шингэсэн бүтээл; - Монголын хилийн түүхийг шинжлэн нягталсан хоёрдох бөгөөд шилдэг бүтээл; - Бүтээлийн бүхий л агуулга нь эх ороонч үзэл баримтлалаар дүүрэн юм; - Монголын хил хязгаар бүрэлдэн тогтсон онцлогийг сайн гаргасан; - Газар ус, овооны нэрс, хилийн газар орны байгалийн онцлог, түүхэн засаг захиргааны харъяалал, хилийн харуул манааны зохион байгуулалт, үйл ажиллагааг нь түүхчлэн тавьжээ. Б. Цэдэн-Иш гуайн энэхүү бүтээл Монгол улсын хилийн судалгаа шинжилгээ, сургалтын ажилд хэн бүхний ширээний ном болсон дорвитой бүтээл, хичнээн үнэ цэнэтэй нь харагдана.

2003 онд Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл доор гарсан "Монгол улсын түүх" таван боть бүтээл олны хүртээл болсон билээ. Энэхүү төрийн түүхийн III ботийн 320-344-р талд "Монгол улсын хил хязгаарын үндэс бүрэлдсэн нь" гарчигтай хилийн тухай тусгай бүлэг оржээ. Дотроо хоёр зүйлтэй. 1-р зүйл нь "Монгол улсын өмнөд хил хязгаарын үндэс бүрэлдсэн нь", 2-р зүйл нь "Монгол улсын умард хил хязгаарын үндэс бүрэлдсэн нь" гэж ангилан авч үзсэн нь тэр чигээрээ Б. Цэдэн-Иш гуайн бичсэн Монгол улсын хилийн түүх, үзэл баримтлал шингэж, гагцхүү зарим нэгэн нэмэлтүүдтэй байна.

Цаашилбал, 2002 онд доктор Ш. Арвайн "Монгол улсын хил хамгаалалтыг боловсронгуй болгох нь" сэдэвт бүтээл гарчээ. Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, хилийн баталгаажилт зэргийг дэлгэрүүлсэн томоохон бүтээл юм.

Миний бие 1990-ээд онд "Түүхийн судлал" хэмээх эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд нийтлүүлж байсан өгүүллүүдээ эмхэтгэн хурандаа Б. Бат-Эрдэнэ, хурандаа А. Муратхан нартай хамтран "Хүннү улсын нутаг дэвсгэр, хил хязгаар, харуул хамгаалалт" товхимолыг 2002 онд хэвлүүлсэн болно. Одоо түүний хоёрдугаар дэвтэр болох "Зүүнгар улсын хил, харуул хамгаалалт" гэсэн ном хэвлэлтэнд бэлэн болгоод байгаа, энэ ондоо олонд хүрнэ гэж найдна.

1998 онд диссертаци хамгаалсан бүтээлдээ үндэслэн 2005 онд "XX зууны эхэн үеийн Монголын нутаг дэвсгэр" сэдэвтэй нэгэн сэдэвт зохиолоо хэвлүүлсэн. Түүнд Монгол улс 1911-1912 онд тусгаар тогтнолоо сэргээсний дараа дэлхийн тавцан дээр тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хилийн шугамаа зөвшөөрөн хүлээлгэхийн төлөө эх орончид халуун амь биеэ хайрлалгүй тэмцэж ирсэн түүхийг сурвалж баримтаар баталгаажуулсан болно. Империализмын үед бага буурай орнууд нутаг дэвсгэр, хилээ батлан сахихад хичнээн хүнд бэрхшээлүүдтэй тулгарч байсныг Монгол улсын жишээн дээр өгүүлсэн. Империализмын ноёрхлын цагт мянган тохиолдолд ганц л буурай орон тусгаар тогтнох бололцоотой. Тэгвэл XX зууны эхэнд Монгол улс энэ зовлонг эдэлсэн. Нутаг дэвсгэр, хилээ зөвшөөрүүлэх явдал нь түүний баталгаа нь байлаа. Харамсалтай нь одоогийн Монгол улсын хил хязгаараар хязгаарласан түүх байна.

2003 онд хурандаа Б. Бат-Эрдэнэ докторын зэрэг хамгаалсан бүтээлээрээ "Төрөөс улсын хил, түүний хамгаалалтын талаар баримталсан бодлого" номоо гаргажээ. Түүндээ 1911-1990 он хүртэлх Монгол улсын хилийн бодлого, үйл ажиллагаа, гэрээ хэлэлцээрүүдийн талаарх мэдээ сэлт нь шинэлэг, хилийн түүхийг баяжуулсан болно.

2002 онд Ж. Гэрэлбадрахын "Монголын нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх (мэө III-XIX)" ном нийтэд очжээ. Тус бүтээл нь мэө Ш зуунаас XIX зуун хүртлэх хилийн түүх, харуулын асуудлыг хөндсөн тойм бүтээл юм. Шинэлэг тал нь

Монголын эртний улсууд болох Хүннү, Сүмбэ, Нирун, Хятан зэрэг улсуудын хилийн түүхийг оруулсанд оршино. Дээр дурдсан эрдэмтдийн бүтээл нь цөм диссертаци хамгаалсан эрдмийн ажил бөгөөд хилийн түүхийн судалгааны суурь бүтээл, шинжилгээний өндөр төвшинд дэвшсэнийг илтгэнэ.

Монгол улсын түүхийн судалгааны ажилтай уялдаж: 1. Монгол улсын хилийн түүх цаашид улсын түүхийн замналаар хөгжих нь дамжиггүй; 2. Хилийн түүхийн судалгаа нь өдгөө иж бүрэн судалгаатай, онол, үзэл баримтлалын тогтолцоонд орсон байна; 3. Хилийн судалгаа нь ямар ч нийгмийн тогтолцооноос үл хамааралтай, үнэн бодитой байх сэдэв; 4. Хилийн түүхийн талаарх бүтээлүүд нь өдгөө эрдэм шинжилгээ, сургалт, сурталчилгаанд өргөн ашиглагдаж байгаа нь тун чухал, эрдэмтдийн хүчин зүтгэл байна.

АШИГЛАСАН НОМ ЗОХИОЛ

1. Б. Бат-Очир. Монголын эртнээс уламжлагдан ирснийг товчлон тэмдэглэсэн бичиг.
2. Н. Магсаржав. Монгол улсын шинэ гарсан түүх. – УБ.,
3. Б. Буянчуулган. Монголын бүх газар нутаг. - УБ.,1936.
4. А.Д. Симуков. БНМАУ-ын газар зүйн атлас. 1934.
5. А.Д. Симуков. БНМАУ-ын эдийн засгийн атлас. 1936.
6. Д. Эрдэнэцэцэг. Монголын их дээд сургуулиудын сургалтанд зориулагдсан сери зургуудын зохиолтын арга зүйн асуудлууд. Докторын диссертаци. - УБ.,2000.
7. "БНМАУ-ын түүх". Нэгэн боть. - УБ.,1954.
8. "БНМАУ-ын түүх". Гурван боть. - УБ.,1966-1969.
9. "Монгол улсын түүх". - УБ.,2003.
10. Д. Гонгор. Халх товчоон. - УБ,1970.
11. Н. Ишжамц. "Монголын феодализмын нэгдсэн улс байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь" - УБ,1974.
12. Н. Ишжамц. Хилийн түүхийн найруулал. - УБ.,1962.
13. Х. Пэрлээ. "Хятан нар тэдний Монголчуудтай холбогдсон нь" - УБ,1959.
14. Н. Сэр-Оджавын " Монголын эртний түүх" - УБ,1977.
15. Б. Цэдэн-Иш. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хил хязгаар бүрэлдэн тогтож ирсэн түүхэн сурвалж баримт бичгүүдийн эмхэтгэл. - УБ.,1990.
16. Б. Цэдэн-Иш. БНХАУ-ын хил хязгаар бүрэлдэн тогтсон нь. - УБ.,1983.
17. Б. Цэдэн-Иш. Монгол улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон нь. - УБ.,2003.
18. Ш. Арвай. Монгол улсын хил хамгаалалтыг боловсронгуй болгох нь. - УБ.,2002.
19. И. Саруул, Б. Бат-Эрдэнэ. Хүннү улсын нутаг дэвсгэр, хил хязгаар, харуул хамгаалалт. - УБ.,2002.
20. И. Саруул. XX зууны эхэн үеийн Монголын нутаг дэвсгэр. – УБ.,2005.
21. И. Саруул. "Базарын Цэдэн-Иш – 100". Эрдэм шинжилгээний хурал. – УБ.,2006.
22. И. Саруул. Алтайн нурууны Тэнгэрийн хил. - "Түүхийн судлал" сэтгүүл. Боть XXX1Y. Өгүүлэл XII. ШУА. - УБ.,2004.
23. Б. Бат-Эрдэнэ. Төрөөс улсын хил, түүний хамгаалалтын талаар баримталсан бодлого. - УБ.,2003.
24. О. Батсайхан. "Хятад, Орос, Монгол гурван улсын гэрээ (өдөр тутмын тэмдэглэл) баримт бичгийн эмхэтгэл". - УБ.,1999.
25. Ж. Гэрэлбадрах. Монголын нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх (Мэө Ш-Х1Х). - УБ.,2002.

Д.Одзаяа ХЦДС-ийн ИБФ-ын багш

ХҮННҮГИЙН МОРЬТ ЦЭРЭГ

Оршил

Хүннү нь Хятадын байлдаант улсын үеийн төгсгөлд Ян, Жао, Цин улсуудын хойд нутагт оршин байсан агаад Хангийн эхэн үед хүчирхэгжин Төв Азийн тал нутагт нүүдэлчдийн их эзэнт гүрнийг цогцлоосон хойд зүгийн нүүдэлчин ард түмэн билээ. Үүнийг гэрчлэх археологийн олдвороос харвал Хүннүгийн ул мөр Байгаль нуур, Монгол, Хятадын Зүүн Хойд нутагт үлдсэн нь мэдэгдэх ба Өмнөд Сибирь, Алтай, Дундад Азийн нутагт ч илэрсээр байна.

МЭӨ II зуунд Хан улсын Уди хаан Хүннүтэй цэрэглэн тэмцэж эхэлжээ. Ийнхүү цэрэг зэвсгийн хувьд хүчирхэг байсан Хүннүг хүчээр дарах нь Хан улсын хувьд бүтэшгүй оролдлогын нэг байлаа. Тиймээс Уди хаан Хүннүг улс төрийн аргаар эзлэх бодлого баримтлах болжээ. Энэ үүднээс одоогийн Дундад Ази болон Солонгосын хойгт цэрэг оруулж Хүннүгийн баруун, зүүн гарын холбоотон улсуудыг ээлж дараалан эзлэн авч, Хүннүг ганцаардуулан хүчийг нь сулруулахад анхаарч байсан. Хүннү нар түүхийн тавцанд гарч ирснээр Зүүн Азийн түүхэнд үзүүлсэн хамгийн том нөлөөний нэг нь тэдний бий болгосон морьт цэрэг юм.



Хүннүгийн морины тухай

Монголчууд морыг зөвхөн уналга, ан ав хийхдээ хэрэглээд зогсохгүй түүний сүү, арьс ширийг ахуй амьдралдаа өргөн хэрэглэсээр ирсэн.

Хүннү морь цатгалан эсвэл өлсөж, эцэж ядарлаа ч гэлээ холын замыг туулж чаддаг бөгөөд энэ нь сайн морины нэгэн чухал шинж билээ. Иймээс монгол морь нь араб морьд шиг сайхан бие хаа, европ морьд шиг хүчтэй биш ч гэсэн Төв Азийн салхи шуурганд тэсвэртэй, туулах чадвар сайтай бөгөөд бусад морьдтой огт адилгүй тэд цасан доороос ч хоол тэжээлээ олж чаддагааараа ялгардаг. Мөн Монголчууд амжилт бүтээлээ мориноосоо хамаардаг гэдэгт итгэдэг учраас Монголын хууль цаазад морины нүдэнд цохивол цаазаар авах ял оноодог байжээ. Европын нэгэн санваартан Плано Карпини XIII зуунд Монголд ирээд маш гайхан "Тэд миний энэ дэлхий дээр байдаг гэж төсөөлж байгаагүй олон тооны морьтой..." гэж хэлсэн байдаг.

Түүнчлэн бусад үүлдрийн морьд шиг арчилгаа их шаарддаггүй, хэрэг болсон үедээ шууд унаж болдог бөгөөд гэдсээ хүүлүүлж, хөлөө тас харвуулсан ч эзнийгээ зорьсон газарт нь хүргэж өгөх үнэнч бас ухаалаг амьтан юм. Эрдэмтэн С.С.Уолкер монгол морийг тодорхойлохдоо "Хэрвээ хэрэгцээ гарсан үед унасан эзэндээ өдөрт 60-80 миль газар давхих боломж өгөөд ч зогсохгүй зарим үед халуун цусаа ч хоол болгон барьчихдаг давжаа жижигхэн хэдий ч тэсвэр хатуужил ихтэй монгол морь хэмээх дайны тийм хүчит зэвсэг гар дор нь байгаагүйсэн бол Чингис хаан түүний залгамжлагчид эрх дарх, эрхшээл, нөлөөллөө тэр их уудам газар дайтан тархааж чадаа ч билүү хэн мэдлээ. хэмээсэн байна.

Хүннүгийн цэргийн тухай

Хүннү нар түүхийн тавцанд гарч ирснээр Зүүн Азийн түүхэнд хамгийн их нөлөө үзүүлсэн эртний улсуудын нэг бөгөөд тус улсын энэхүү хүчирхэгжилтэнд нөлөөлсөн гол хүчин зүйл нь тэдний морьт цэрэг байсан юм. Энэ нь явган цэрэгтэй Хятадын байлдааны аргад томоохон нөлөө үзүүлжээ. Хүннүгийн байлдааны арга нь мориныхоо давхиан дунд чөлөөтэйгөөр нум сумаар харваж, холын зайд байгаа дайснаа устгах явдал байсан юм. Хүннүгийн 3 наснаас дээш бүх хүмүүс морь унаж чаддаг байсны зэрэгцээ дайны үед эрэгтэй, эмэгтэй хамаарахгүйгээр нум, сум харваж, бүх хүн дайн тулаанд оролцдог байжээ. Мөн эмэгтэйчүүд дайн байлдаанд амь биеэ үл хайрлан эрэгтэйчүүдээс дутахааргүй оролцдог байжээ. Тухайлбал: Чжичжи шаньюйгийн үед хятадууд шаньюйгийн хэрмийг даван орж ирэхэд эмэгтэйчүүд тэдэнтэй байлдан эзэн хаан, орд өргөөгөө хамгаалж байжээ. Түүнээс гадна Хүннүгийн морьт цэргүүд нь маш нарийн зохион байгуулалттай тэдийгүй эзэндээ үнэнч байжээ.

Хүннүгийн 24 аймаг хожим түмдэд хуваагдан түмний ноён цэргийн жанжин толгойлдог байжээ. Түмэт нь мянгат, зуут, аравтад хуваагддаг байснаас үзвэл Хүннү улс анх байгуулагдах үедээ нэгэнт 240 орчим мянган морьт цэрэгтэй

байжээ.

Тэр үед Хятадын байлдааны тэрэгт 3 цэрэг суух бөгөөд зүүн талд нь байх цэрэг нум сум харваж, баруун гар талынх нь цэрэг сэлэм эргүүлэн харин тэдний дунд суух цэрэг нь жолоо барьдаг байжээ. Эднээс нум сум харвадаг харваач нар нь тусгайлан бэлтгэгдэх бөгөөд нэг тэргэн дээр нэг харваач байдаг байв. Ийм байлдааны арга нь морь унан нум сумааараа харваад алга болдог Хүннүгийн морин цэргийн хөдөлгөөнтэй харьцуулшгүй удаан юм. Тиймээс У Ли ван морин цэрэг болон морьт харваачдыг бэлтгэн, цэргийнхээ хөдөлгөөнийг уян хатан болгохын тулд хойд зүгийн Ху нарын биед эвтэй, морь унахад тохирсон хувцсаар солих тушаал буулган, цэргийн хүчээ нэмэгдүүлэхэд анхаарсан аж. Ийнхүү Хан улс Хүннү маягийн хөнгөн морьт цэрэг бэлдүүлэн, сургуулилуулж МЭӨ 124 онд Вэй Цин жанжнаар удирдуулан Хүннүчүүд рүү довтолж байжээ. Ингээд суурин соёл иргэншилтэй тариачин улсад морьтны байлдааны арга нэвтэрснээр Хятад нь нүүдэлчтэй хийх худалдаа наймаанд адууг чухалчлах болсноор барахгүй Хятадын улсуудаас хойд нутгийн үйлдвэрлэх хүчний хөгжилд анхаарал хандуулах болсон байна. Үүний үр дүнд Хүннү нь хятад хүмүүст адуу маллах болон морьтон дайчдын байлдах урлагыг түгээж, Төв Хятадын тэрэгт цэргийн дайтах аргыг өөрчилсөн байна. Мөн тухайн үед Хятад улс хойд талаараа урт хэрэм байгуулах болсон явдал нь ч морьт цэрэгтэй холбоотой буюу тэд тал нутагт мал маллан амьдардаг нүүдэлчдийг хөөн шинэ нутаг эзэмших, морин цэрэг байгуулахад шаардлагатай адууг үржүүлэх үүднээс хийгдсэн зүйл гэж зарим эрдэмтэд тайлбарласан байдаг билээ.

Түүгээр ч үл барам Хятадын Янь улсаас Цинь Хай гэгч туршуул Хүннүчүүдэд олзлогдсон мэт дүр үзүүлэн нэг ёсондоо тагнуул хийж тэдний амьдрал ахуйд нэвтрэн орж, итгэл хүндэтгэлийг нь олж цэргийн эрдэмд сайтар суралцаж байжээ.

Дүгнэлт

1. Хүннү улс нь Модунь шаньюйгийн үед нэн хүчирхэгжиж асар уудам нутаг дэвсгэрийг эзэмшиж байсны зэрэгцээ хөрш улс орнуудыг өөрийн холбоотон болгож, өөрсдийгөө Хан улсаар хүлээн зөвшөөрүүлсэн.

2. Хүн улсын ийнхүү хүчирхэгжилтэнд нөлөөлсөн гол зүйл нь цэрэг дайны тактик, ялангуяа тэдний морин цэргийн ур чадварт оршиж байсан.

3. Энэхүү морин цэрэг нь тусгайлан бэлтгэгдсэн цэргүүд гэхээсээ илүүгээр энгийн ардууд байсан. Өөрөөр хэлбэл дайн тулаан болбол насанд хүрсэн бүх эрчүүд буюу 18-60 насны хүмүүс дайчладгаараа онцлог юм.

4. Эмэгтэйчүүд буюу тэдний хатад, эмэгтэйчүүд ч энэхүү дайн тулаанд оролцож, шаардлагатай үед эр цэргийн үүрэг гүйцэтгэдэг байсан.

5. Хүннүчүүд балчир наснаасаа эхлэн морь унаж чаддаг байсан нь тэдний морин цэрэг байгуулах үйл явцад гол түлхэц, нөлөө үзүүлсний зэрэгцээ тэдний байлдах урлагт хүчтэй нөлөөлсөн.

6. Тиймээс Хан улсын У Ли ван “Ху нарын хувцас өмсөж, морь унах” зарлиг буулгаснаараа монголчуудын соёлыг зээлдэн авч хэрэглэсэн гэж үзэж болох талтай юм.

ХИЛЧИН БА ХУУЛЬ

П.Даш МОУА-ийн академич, доктор, профессор

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮДИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн Цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгаа гэсэн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Цэцийн гишүүн гэмт хэрэгт холбогдсон бол түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг энэ тухай эрх бүхий байгууллагын санал, шийдвэрийг хүлээн авсанаас хойш 14 хоногийн дотор Цэц хэлэлцэн шийдвэрлэнэ." заасан байдаг.

Энэ нь цэцийн гишүүн хэн нэгний өшөө хонзон, атаа хослоос болж хэлмэгдэхгүй байх, бүрэн эрхээ хөндлөнгийн ямар нэг шахалт дарамтгүй хэрэгжүүлэх баталгаа болохоос биш гэмт хэрэг үйлдсэнийг нь хаацайлах, хамгаалах, ял завшуулах зорилгыг агуулаагүй билээ.

"Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна." гэж үндсэн хуульд заасан бол "Цэцийн үйл ажиллагааны үндсэн зарчим нь:

1. Цэц нь хараат бус байх, Монгол Улсын Үндсэн хуульд захирагдах, гишүүд эрх тэгш байх, асуудлыг шударга шийдвэрлэх, үйл ажиллагаа нь ил тод байх үндсэн зарчмыг баримтлана.

2. Аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн Цэц, түүний гишүүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох нөлөөлөхийг хориглоно." гэж Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд заажээ.

Цэцийн хараат бус байдал болон асуудлыг шударга шийдвэрлэх, бусдын нөлөөнд автахгүй байх дээрх нөхцлийг хангах нь төрийн нэг чухал үүрэг мөн. Чухам ингэж чадсан тохиолдолд сая үндсэн хуулийн хэрэгжилтийг чин шударгаар хангах нэг нөхцөл бүрдэнэ.

Ийм учраас Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд Цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгааг хуульчилж өгсөн байдаг.

Нийгмийн хөгжлийн явцад хүмүүсийн ухамсар, мэдлэг, зан суртахууны онцлогоос шалтгаалан тэднээс хууль бус болон шударга бус зан үйл гаргах нь цөөнгүй тохиолддог.

Ялангуяа аливаа маргааныг шийдвэрлэх явцад маргалдагч талууд өөрийн талд ашигтай шийдвэр гаргуулахын төлөө улайран тэмцэж, авилга, хээл хахууль өгөх зэргээр хууль бус ажиллагаа явуулж, түүнд нь төрийн албан хаагчид өртөх нь олонтой тохиолдох болжээ.

Мөн ямар нэгэн аргаар төрийн албанд шургалж, төрийн албаар бизнес хийх гэсэн оролдлого хэмээс хэтэрсэн нь манай нийгмийн гашуун үнэний нэг мөнөөс мөн билээ. Үүний тулд хуурамч бичиг баримт ашиглан төрийн албанд шургалах, төгссөн сургууль, хийж байсан ажил албаа худлаа мэдүүлэх, тэрч байтугай гэмт хэрэг үйлдэн шийтгэгдэж байснаа нуун дарагдуулах явдалч

байдаг.

Түүнчлэн хувийн хэвшлийг хөхүүлэн дэмждэг зах зээлийн эдийн засаг бүхий нийгэмд төрийн өндөр албан тушаалтнуудаас албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, төрийн өмч, хөрөнгийг ашиглан завших, шамшигдуулах нь элбэгшлээ.

Эдгээр нь төрийн албан хаагчдаас түүний дотор үндсэн хуулийн цэцийн гишүүдээс гэмт хэрэгт холбогдох явдлыг үгүйсгэх аргагүйд хүрч байна.

Үүний зэрэгцээ өөрийн атаг санаагаа хэрэгжүүлэх, эсвэл улс төрийн зорилгоортөрийналбыгшударгаархашиж байгаа албан хаагчдыг хэлмэгдүүлэх гэсэн оролдлого гарсаар байгаа бөгөөд арга нь улам бүр нарийссаар байна. Ингэхдээ шударгаар ажиллаж байгаа төрийн албан хаагчийн нэр төр, алдар хүндийг гутаах, эрхэлжбайгаа ажил албан тушаалаас нь зайлуулах зорилгоор гэмт хэрэгт холбогдуулан гүтгэх явдал хэмээс хэтэрлээ.

Нөгөөтэйгүүр илтэд хууль зөрчин гэмт хэрэг үйлдсэн төрийн өндөр албан тушаалтныг хаацайлан авч үлдэх замаар ял завших боломж олгох, энэ нь "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэсэн үндсэн хуулийн зарчмыг ноцтой зөрчиж байгаа баримт өнөөгийн нийгмийн амьдралд олон байна.

Иймд Цэцийн гишүүнийг хуульд заасан үндэслэлээр бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх асуудалд маш нарийн, болгоомжтой хандах хэрэгтэй.

Энэ нь нэг талаас төрийн албан хаагч шударга иргэнээ бусдын гүтгэлэгээр хэлэмэгдүүлэхгүй байх, нөгөө талаас төрийн албаны нэр барьж хууль завхруулагчидад ял завшуулахгүй байх гэсэн эсрэг тэсрэг хоёр өөр ашиг сонирхолын алинд нь ч давуу байдал олгохгүй байхыг шаардаж байгаа юм.

Гэтэл төрийн өндөр албан тушаалтныалбан тушаалыгтүдгэлзүүлэх асуудал төгс сайн зохицуулагдаагүй харилцаа болох нь гэмт хэрэгт холбогдсон УИХ-ын гишүүд, УИХ-аас томилогдсон албан тушаалтнуудыг албан тушаалаас нь түдгэлзүүлэх асуудлыг шийдвэрлэж байгаа төрийн эрх барих дээд байгууллага болох УИХ-ын сүүлийн 3 жилийн үйл ажиллагаанаас маш тодорхой харагдаж байна.

Тухайлбал, УИХ-ын нэр бүхий гишүүд, УИХ-аас томилогддог зарим албан тушаалыг түдгэлзүүлэх асуудал 7 сараас 3 жил хүртэл хугацаанд УИХ-ын янз бүрийн шатанд яригдаад одоо хэр шийдэгдээгүй байна.

Өөрөөр хэлбэл хууль тогтоох байгууллага хуулинд тодорхой хугацаа заасан асуудлаа ийнхүү шийдэж чадахгүй байгаа нь эрх зүйн зохицуулалт хангалтгүй, хуулийн хийдэл ихтэй байгааг харуулж байна.

Ашиг сонирхолын зөрчлийн улмаас хууль тогтоогч нар уг хийдлийг арилгах сонирхолгүй байгаа нь нэгэнт тодорхой болжээ. Хэрэв үндсэн хууль, бусад хуулиа дээдлэн сахих сонирхол байсан бол энэхүү хийдлийг арилгах хангалттай хугацаа өнгөрч байхад ямарч арга хэмжээ авч болох байлаа. Гэвч одоо хэр хуулийн хийдлийг арилгах талаар ямарч арга хэмжээ авахгүй байгаа нь хууль тогтоогч нар энэхүү хийдлийг арилгах сонирхолгүй байгааг харуулж байгаа юм.

Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудал яг ийм эрх зүйн зохицуулалттай байгаа тул уг хууль хэрэгжих магадлал туйлын эргэлзээтэй байна. Эрх зүйн уг зохицуулалтыг боловсронгуй болгохын тулд дараахь нөхцөл байдал үүсч

болохыг бодолцох ёстой. Үүнд:

1. Цэцийн гишүүнийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг Цэцийн аль суудлаар хэлэлцэн шийдвэрлэх нь тодорхойгүй байх тул Цэцийн гишүүний ирц хүрэхгүй байна гэсэн шалтгаанаар хуульд заасан 14 хоногийн хугацаандаа хэлэлцэн шийдвэрлэж чадахгүй хуулиа зөрчих бодит үндэслэл байна.

2. Хэрэв их суудлаар хэлэлцэн шийдвэрлэхээрхуульчилвалхэлэлцэгдэж байгаа гишүүнийг хасахаар ирц хүрэхгүй байх магадлал асар өндөр болно.

3. Хэрэв дунд суудлаар хэлэлцэн шийдвэрлэж байхаар хуульчилвал энэ хариуцлагатай, хүний эрхийг хөндөх агуулгатай асуудлыг цэцийн нийт гишүүдийн гуравны нэгийн саналаар буюу 3 хан хүний саналаар шийдвэрлэх боломж бүрдэж байгаа бөгөөд гишүүнийг хэн нэгний захиалгаар болон улс төрийн зорилгоор хэлмэгдүүлэх, эсвэл мөн зорилгоор ял завшуулах боломжийг бүрдүүлэх магадлалтай юм.

Иймд эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байна. Чухамхүү энэ зорилгоор Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд дараахь нэмэлт, өөрчлөлтийг оруулах боломжтой гэж үзэж байна.

1. Уг хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Цэц" гэсний дараагаар "их суудлаараа" гэж нэмэх,

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3-т "эцэслэн шийдвэрлэх" гэсний дараа "цэцийн гишүүнийг түдгэлзүүлэх эсэх талаар хэлэлцэх" гэж нэмж оруулах,

3. Мөн хуулийн "Цэцийн хуралдааныг зарлах" гэсэн 24 дүгээр зүйлийн дараагаар "цэцийн хуралдааныг яаралтай хуралдуулах" гэсэн шинэ зүйл нэмж түүндээ тодорхой хугацаанд шийдвэрлэхээр хуульд заасан асуудлыг хэлэлцэхийн тулд цэцийн хуралдааныг яаралтай хуралдуулах, ирцийг хэрхэн бүрдүүлэх, тэрч байтугай гишүүний саналыг хэрхэн авах талаар нарийвчлан заасан хэм хэмжээг тогтоох шаардлагатай.

4. Эцэст нь үндсэн хууль, эдгээр хуулийг зөрчсөн Цэц, түүний албан тушаалтан, гишүүдэд хэн, ямар хариуцдага, яаж тооцохыг хуульчилсан байх шаардлагатай гэж үзэж байна.

ТАНЫ БОЛОВСРОЛ, ТАНИН МЭДЭХҮЙН САНД

Д.Оюунцэцэг. Анагаах ухааны магистр

КЛОНЫ ЭТИКИЙН АСУУДАЛД

Клон гэдэг үг эртний грек klon салаа, мөчир гэсэн утгатай үгнээс гаралтай, нэг организмаас нөгөө организм тасран салах гэсэн утгатай үг юм. Үржлийн бус эснээс тухайн организмтай ижил организмыг гарган авах, ижил генетикийн мэдээлэл бүхий организм үүсгэх, нэгэн эстэй яг ижил хэсэг бүлэг эсийг клон гэдэг.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас (ДЭМБ) "Клон гэдэг нь шинжлэх ухааны ухагдахуунаар бол организмын төдийгүй, диоксирибонуклейн хүчил (ДНХ) мэт молекул болон эсийн тухайд авч үздэг ойлголт юм. Хүний клон гэдэг нь донорын биеийн эсийн бүхий мэдээллийг агуулсан бөөмийн генийг өөр эсэд суулган шинээр хүн үүсгэхийг хэлнэ" гэсэн байна. Өөрөөр хэлбэл хүний бэлгийн бус замаар яг ижил гентэй хүнийг хувилан гаргахыг хэлж байна.

ДНХ буюу молекулын, эсийн, эмбрионы гэсэн 3 төрлийн клон байдаг. ДНХ буюу молекулын клон гэдэг нь ямар нэгэн ДНХ-ийн хэсгийг өөрөө хуулбарладаг бактерийн плазмид мэтийн эсийн бус организмд генийн элемэнтэд дамжуулах процесс юм байна. Зарим плазмид 1 МВ хүртэл гадны ДНХ-г өөртөө агуулж чаддаг. Энэ технологийг 1970-аад оноос хойш молекулын биологийн лабораториудад түгээмэл хэрэглэж байгаа.

Эсийн гэдэг нь лабораторит нэг эсийг олшруулж олон эс гарган авах технолог юм, инсулин, эдийн плазмоген активиторыг гарган авахад ашигладаг.

Эмбрионы клоныг эмбрионы ямар шатанд байгаагаас хамааран бластомерийн, бластоцистийн, бөөм зөөх гэж ялгадаг. Хэрэв эмбрион үүсээд удаагүй бластомерийн шатандаа байхад хувааж ижил организм үүсгэсэн бол бластомерийн гэнэ. Бластоцидийн үе буюу үр хөврөл үүсээд хэд хоносон үед нь хувааж үүсгэсэн бол ихэрлэх буюу бластоцистийн гэж хэлдэг. Харин үржлийн бус эсийн генийг агуулсан бөөмийг урьдчилан түүнийг нь авсан өөр эсэд шилжүүлэн суулгах замаар шинэ амьтныг гарган авсан бол биеийн бөөмийг зөөвөрлөх арга гэнэ. 1996 онд Долли хонийг энэ аргаар гарган авсан.

Клон нь гэнэт үүссэн шинэ зүйл биш болохыг дараах баримтууд нотолж байгаа юм. 19 дүгээр зууны эхээр Томас Роберт Мальтус хүнийг үржлийн биш аргаар гарган авч болох тухай бичиж байжээ. Харин энэ зууны дундуур Чарлес Роберт Дарвин эволюцид олон төрлийн амьтныг гарган авах боломжийн тухай бичиж үлдээсэн байна.

1952 онд Роберт Брид, Томас Кинг нар Филаделфийн хавдар судлалын институтэд мэлхийн эсийг ашиглан нэг эсээс нөгөөд бөөм суулгаж туршсан байна.

1966 онд Нобелийн шагналт генетикч Жошуа Леденберг генийн инженерийн төрлүүд, хүний клоний талаар дэлгэрэнгүй мэдээллийг "American Naturalist" сэтгүүлд хэвлүүлсэн.

1983 онд Давос Солтер нар

цагаан хулгана дээр эсийн бөөмийг нөгөө эс рүү зөөвөрлөх туршилт хийж үзээд энэ тухайгаа 1984 онд "Шинжлэх ухаан" сэтгүүлд "Сүүн тэжээлтэнг жирийн бөөм зөөх аргаар клон хийх боломжгүй болох нь" гэдэг нийтлэл гаргасан байна.

1996 онд Шотландын Рослин институтын судлаачдын баг дэлхийд хамгийн нэр гарсан Долли хонийг клонийн аргаар гаргаж авсан явдал нь дэлхийн эрдэмтэд, судлаачид төдийгүй улс төрчдийн анхаарлыг татсан юм. Энэ мэдээ нь сайтар судлагдаагүй, маргаантай асуудал байсан клонийг шинэ түвшинд гаргасан юм. Хэн нэгний үл бүтэх мөрөөдөл, хоосон зүйл гэж үзэж байсан олон хүнийг амьдралд ойрхон боломжтой зүйл болохыг хүлээн зөвшөөрүүлсэнээрээ Долли хонь "дэлхийн хамгийн алдартай хонь" болсон. Тухайн үед АНУ-ын Ерөнхийлөгч асан Клинтон клонийн асуудлыг анхааралдаа авч "Бид өөрсдийгөө хувилан олшруулахыг хүлээзнэхийг хүсэж байна. Шинжлэх ухаан бурхан биш" гэж ард иргэддээ хандаж байсан билээ. Удалгүй АНУ-ын конгресс клонийн асуудлыг авч хэлэлцээд улсын хөрөнгөөр клон хийхийг хориглож байсан.

Хүний клонийг хориглосон хууль ихэнх туршилт хийх эдийн засгийн боломжтой хөгжингүй улс орнуудад байдаг, гэвч зарим нэгэн хангалттай мөнгөтэй хүмүүс хайртай үр хүүхэд, амьтнаа клонийн аргаар дахин төрүүлэх хүслээ гүйцэлдүүлэхийн тулд туршилт хийлгэхээр ивээн тэтгэх явдал байна. Хэдийгээр ДЭМБ-ын гишүүн орнууд хүний клонийг хийхгүйг уриалан нэгдсэн боловч зарим газарт туршилт хийж байж болох юм. 2009 онд АНУ-ын судлаач, эмч Панаётис Завос хүний эмбрионыг клонийн аргаар олшруулсан туршилт хийсэн тухайгаа "The Scotsman" дээр гаргасан юм. Клонийн аргаар гаргасан 14 эмбрионыг 11 эмэгтэйн умайд суулгасан гэж мэдээлжээ. Хэдийгээр энэ удаагийн удаагийн туршилт амжилт олоогүй боловч дараагийн удаа тэрээр 11 настай хүүгээ автомашины осолд харамсалтайгаар алдсан эхийг оролцуулан илүү олон эхэд эмбрион суулгах туршилтаа хийнэ гэсэн байна. Энэ удаагийн туршилтад орсон эмэгтэйчүүдээс нэг нь ч жирэмслээгүй байна.

Хүний клон гарган авахад нилээдгүй этикийн асуудал тулгарч болох юм.

Хамгийн хүндрэлтэй асуудал хувь хүний давтагдашгүй байдал алдагдаж мэдэх юм. Хувь хүн гэдэг бол давтагдашгүй байгалийн бүтээгдэхүүн билээ. Гэтэл түүнтэй яг ижил нэгэн хүн гаргаж авлаа гэвэл тэр шинээр төрсөн хүн яг тэр хүн мөн үү? гэдэг асуулт гарна. Одоогийн хэрэглэж байгаа аргаар гаргах юм бол жинхэнэ хуулбар бишээ, учир нь суулгаж байгаа эсийн митохондрт байгаа ДНХ-ийн хэсгүүд шинээр үүсэж байгаа организмд мэдээллээ дамжуулан өвлүүлөх боломж байна. Нөгөө талаас хувь хүнийхээ хувьд шинээр үүсэн хөгжиж байгаа хүн донор хүнээс цаг хугацааны болоод орчин нөхцөлийн хувьд өөр байдалд өсөн торних учраас ялгаа нилээд байх болно. Мөн хүний сэтгэл, тархийг хувилж болно гэж үү? Иймээс хүнийг дахин хувилах биш дахин нэгэн хүнийг гарган авах асуудал болох нь ээ.

Шинээр клонийн аргаар гарган авсан хүн жинхэнэ хүн мөн үү? Эсвэл хэн нэгний хувилбар хоёрдугаар зэргийн бүтээгдэхүүн үү гэдэг асуудал гарна. Өсөн торних

шинэ хүүхэд өөрийгөө хүн биш хэн нэгний дууриамал гэдгээ мэдвэл сэтгэхүйн хувьд ямар дарамтад орж болох вэ, ямар хариу үйлдэл үзүүлж болох вэ, нийгэм тэдгээр хүмүүсийг хэрхэн хүлээж авах вэ, энэ бүхнээс ямар сөрөг үр дагаврууд гарч болох вэ гэдгийг одоогоор хэн ч төсөөлөн хэлэх боломжгүй байна.

Түүгээр ч барахгүй зарим хүмүүс программчилсан мэргэжлийн цэргүүд, ажилчид гарган авахыг үгүйсгэхгүй хэмээн болгоомжилж байгаа юм. Хэрэв хүнийг клонийн аргаар үржүүлэх хэрэгсэл болговол хүн төрөлхтөний генийн сан багасан улмаар устаж ч болох юм.

Сүүлийн үеийн судлаачдын үзэж байгаагаар клоний аргаар бий болсон организм гажигтай болох магадлалтай талаар бичиж байна. Тухайлбал 2002 онд Био анагаах ухааны Кэмбрижийн Вайтхэдийн институтэд 10 мянган клон хулганы элэг болон ихсийн эсэд шинжилгээ хийхэд 4 хувь нь генийн гажигтай байжээ.

Японы эрдэмтэд клон хулгануул эрт үхэж, бас сонин гажиг ихтэй байдгийг тэмдэглэсэн байна.

Хүний клонийн хувьд ч генийн мутац бусад гажигууд үүсэх магадлал өндөр байгааг судлаачид таамаглан бичсээр байна. Хүнийг клонийн аргаар гарган авахыг оролдвол төрөл бүрийн гажиг үүсэх магадлал өндөр байсаар байгаа. Магадгүй хүмүүс өөрсдөө хүн мангасыг гаргаж болох юм.

Хүн болгохгүйгээр зөвхөн эрхтэн гаргаж авах хэмжээнд технолог хөгжвөл эрхтэн донорын асуудал таатай шийдэгдэж болох талтай. Тэгсэн тохиолдолд эрхтэн шилжүүлэн суулгуулахаар хүлээж очерлож байгаа олон хүний эрүүл мэндийн асуудалд санаа зовох хэрэггүй болох юм.

Харамсалтай нь одоогоор клонийн аргаар эрхтэн гаргаж авах технологийн боломж байхгүй байгаа. Харин энэ хэрэгцээг дагаад эрхтэнг авах зорилгоор хүнийг клоний аргаар үйлдвэрлэх асуудал ч гарч болох талтай, энэ бүхний үр дагавар чухам юу вэ гэдгийг тааварлан хэлэх судлаач эрдэмтэний бүтээл олсонгүй.

Хүнийг клоний аргаар гарган авах сонирхол хувь хүний хувьд нэгэн үндэстнийг олшруулах, өөрийнхөө ихрийг гарган авах, эсвэл хэн нэг хайртай хүнээ хувилан гаргах, хүний эрхтэний үйлдвэрлэл зэрэг сонирхлоор хүнийг клонийн аргаар гарган авахыг санаархах боломжтой.

Глобалчлагдсан дэлхийн нэгэн хэсэг манай улсад ч бас хүний клоний асуудлыг ярьж энэ талаар хууль гаргах цаг болж байгаа ч байж мэдэх юм шүү.

Ашигласан хэвлэл:

Amy Logston. The ethics of Human Cloning. 1999 Saint Vincent College. Fr. Thomas Hart, O.S.B. January 13, 1999

Cohen, Jacques and Giles Tomkin. "The Science, Fiction, and Reality of Embryo Cloning." Kennedy Institute of Ethics Journal 4 (1994): p193-203.

Harris, John. "Is Cloning an Attack on Human Dignity?" Nature 387 (1997): 754.

Kahn, Axel. "Clone Mammals…Clone Man?" Nature 386 (1997): 119

Kolata, Gina. Clone: The Road to Dolly, and The Path Ahead. New York:

William Morrow and Company Inc., 1998.

Macklin, Ruth. "Splitting Embryos on the Slippery Slope: Ethics and Public Policy." Kennedy Institute of Ethics Journal 4 (1994): 209-225.

McKinnell, Robert Gilmore. Cloning: Of Frogs, Mice, and Other Animals. Minneapolis: University of Minnesota Press, 1985.

Pence, Gregory E. Who's Afraid of Human Cloning? Lanham, MD: Rowman & Littlefield Publishers, Inc., 1998.

Robertson, John A. "The Question of Human Cloning." Hastings Center Report 24 (1994): p6-14.

Report of the WHO secretariat on reproductive cloning of human beings (status of the debate in the United Nations General Assembly) WHO. 1999.

Shapiro, David. "Cloning, Dignity, and Ethical Reasoning." Nature 388 (1997): p511.

The Independent, "This procedure can't be ethical until it is proven safe", London, England April 22, 2009. p2.


The Scotsman, Edinburgh, Scotland, April 23, 2009, p10.

Voelker, Rebecca. "A Clone by Any Other Name Is Still an Ethical Concern." Jama 271 (1994): p331-332.

Watson, James D. The DNA Story: A Documentary History of Gene Cloning. San Francisco: W.H. Freeman and Co., 1981.

"Will We Follow the Sheep?" Time March 10, 1997; p69, 70-72.

Д.Оргилбаатар. Нийслэлийн нэрэмжит 10 жилийн 50 дугаар сургуулийн 8-р ангийн сурагч



МОНГОЛЫН ЗОХИОЛЧДЫН ЭВЛЭЛИЙН ГИШҮҮН Л.НЯМААТАЙ ХИЙСЭН ЯРИЛЦЛАГА

Л.Нямаа: "Алдаад алдаад та нар
Адуугаа бэлчээх нутаг үлдээв үү?
Өгөөд өгөөд та нарт
Өвгөдөө оршуулах газар байна уу?"

Өнөөдрийн зочноор Монголын Зохиолчдын Эвлэлийн гишүүн, МЗЭ-ийн болон Цэдэндоржийн нэрэмжит шагналт, зохиолч, Чингис судлалын академийн судлаач, Их Засаг Их Сургуулийн багш, дэд профессор Ломбын Нямаа уригджээ. Тэр манай сурвалжлагчтай ярилцав.

Сурв: Таныг зохиол бүтээлүүдээр тань манай хилчид сайн мэднэ. Гэхдээ, Та манай хилчдэд өөрийгөө танилцуулахгүй юу? гэж хүсвэл өөрөө юу гэх бол? Монгол Улс маань зохиолч долоон Нямаатай юм гэдэг.Таныг "Хөдөөдөө дөнгүүр нь Ломбын Нямаа" гэсэн байдаг. Та хөдөө ажилласан юм уу?

Н: Би Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр сум, Өндөрхаан хотод 35 жил ажилласан.

Сурв: Та улсынхаа дархан хилд хэрхэн ханддаг вэ? Хилээр явж, хилчидтэй уулзаж байв уу?

Н: Эх орны хил бол улс орон оршин тогтнохын үндэс гэж гүн хүндэтгэлтэй ханддаг. Өмнөдэлгэр сумын дунд сургуульд багшилж байхдаа Улсын баатар Х.Дамба, эрэлхэг хилчин М.Гаасүрэн нарын дурсгалыг хүндэтгэх 14 хоногийн ажлыг жил бүр зохион байгуулж байв. Х.Дамба, М.Гаасүрэн нар Өмнөдэлгэр сумын унаган иргэд байсан бөгөөд эх орныхоо дархан хилийг хамгаалах үйлсэд алтан амиа өргөсөн баатрууд шүү дээ. Дурсгал хүндэтгэлийн ажил маань хүүхдүүдийн оюун санаанд эх орон, дархан хилийг, түүний бүрэн бүтэн байдлын тухай романтик итгэл үнэмшил төрөхөд бага ч болсон нөлөөлж байсан учраас Монгол телевизийн сэтгүүлч Р.Ганбат нар 30 минутын нэвтрүүлэг хийж орон даяар нэвтрүүлж байна.

1979 онд Халхын голын ялалтын 40 жилийн ойд зориулсан утга зохиолын өдрүүдэд Монголын зохиолчид, яруу найрагчдын хамт Халхын голын түүхт нутгаар аялж "Халхын гол" найраглал бичиж "Бид ялав" номонд хэвлүүлж байлаа.

Сурв: Өнөөдөр Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал ямар байна вэ?

Н:Аугаа их удирдагч Модун Шанюй "Хүннү гүрний нутаг дээгүүр мөлхөж өнгөрөх гүрвэл могойг ажиглаж сэрэмжил. Хүннү гүрний тэнгэр дээгүүр нисч өнгөрөх шонхор шувууг ажиглаж сэрэмжил" гэж 2220 жилийн өмнө бидэнд гэрээслэл үлдээсэн бол эзэн богд Чингис хаан: "Хөх монголын газар шорооноос уулын чинээ алт амалсан ч тохмын чинээг бүү арилж" гэсэн сургаалиас үзвэл Монголын суу билэгт охид, хөвгүүдийн амь нас, хувь заяагаар хамгаалагдсан эх орон шүү дээ. 2220 жил энх амгалан байсан Монголын газар шороо харийн болон дотоодын шуналтнуудын гар хөлд элэгдэж дуусахыг харж байна. Чингис хаандаа өргөсөн нэгэн шүлэгтээ:

"... Алдаад алдаад та нарт
Адуугаа бэлчээх нутаг байна уу
Өгөөд өгөөд та нарт
Өвгөдөө нутаглуулах газар байна уу гэж Чингис хаан Монголын төр засгийн өнөөгийн удирдагчдаас асууж байгаагаар бичсэн юм. Энэ бол эх орноо хайрладаг яруу найрагчийн халуун зүрхний эмзэглэл юм даа.

Сурв: Чингис хаан улсын хил, хязгаар нутгийн талаар хэрхэн анхаарч байсан бол?

Н: Түүхчид Чингис хааныг хил хязгаараа хамгаалах соёлыг үндэслэсэн гэж үздэг юм билээ. Их Монгол улсын үеэс эх орныхоо хил хязгаарыг алтан ургийнхаа найдвартай хүмүүсээр хамгаалуулж ирсний уламжлал 1921 он хүртэл хадгалагдаж байсан, Манай Хэнтий аймагт гурван харуул байсан. Тэр харуулд бүүр өмнөт нутаг Гадин засгийн хошуунаас (Сүхбаатар аймгийн Сүхбаатар сум орчмын) харуул авчирч, хил хязгаараа хамгаалуулж байжээ. Манжийн Энх-Амгалан хаан төв Монголын нутгаас алт ухуулахгүй гэж газар нутгаа хамгаалах зорилгоор зарлиг гарган 20 гаруй "алтны харуул" гаргаж байсан нь түүхэнд бичигдэж үлджээ. Сүүлийн 20 жилд Монголын

төр засгийн удирдагчид манжийн хаадаас долоон дор байна шүү дээ„ Бүх шатны нүгэлт удирдагчдад төр гэсгээл үзүүлж үл чадваас тэнгэр гэсгээх байх аа.

Сурв: Одоо бид Монголдоо яаж эзэн болох вэ? Таны бодол..?

Н: Тэмүүжинг төрөхөөс 3 хоногийн өмнө Хамаг Монголын их зайран Бургидай Есүхэй баатрын гэрт бөөлж: "Хөх монголын их удирдагч танай гэрт төрөх нээ. Би Монголын 33 говь, 44 их тал, 10 их уул, 10 их мөрнийг тэнгэрт даатгаж авлаа" гэж айлдсан байдаг. Бидний эх нутаг чинь тэнгэрт даатгагдсан нутаг юм шүү! гэж хэлмээр байна.

Эх орны хилд эх орны амьнасан оршмой.

Сурв:Та хилчин найз, нөхөд олонтой байх л даа. Тэднийхээ заримын талаар манай хилчдэд дурсвал:?

Н: Хилчний аугаа их үйлсийн тухай олон бүтээл туурвисан Монголын их найрагч П.Бадарч ах хилчин Х.Дамбын баатарлаг үйлсийг тодруулж улсын баатар цол хүртэхэд нь хүчин зүтгэсэн, яруу найрагч, зохиолч Жанчивын Шагдар, Яруу найрагч Барнангийн Доржпалам, хилийн сонины эрхлэгчээс Шинжлэх ухааны доктор болсон хурандаа Гэлгээгийн Дагважамц нарын олон нөхдөө энэ мөчид дурсан санаж, эх орны хил дээр өнгөрүүлсэн алтан өдрүүдийн талаар санаж, та нарынхаа өмнө мэхийн ёсолъё.

Хилийн чулуунд өргөх элегия

(эрхэм нөхөр хурандаа Г.Дагважамцдаа)

Улсын минь хил, чулуундаа амиа хадгалж

Унтдаг, сэрдэг, босдог, бас гуньдаг

Уяхан дуу сонсож сэрээд баярлан мишээдэг

Хилчний алганд хилийн чулуу дулаацаж зовлонгоо мартдаг

Хилийн минь тэнгэр чулуугаа харж амгалан оршдог

Гадагшаа тэмүүлсэн Монгол хүний зовлон

Хилийн чулуу мөргөөд эх орондоо жаргал болж ирдэг

Эх оронд минь шунасан харийн хүний жаргал

Хилийн чулуунд бүдрээд зовлон болж цаашаа оддог

Улсынхаа хил, чулуундаа амиа хадгалж

Унтдаг, босдог, бас сэрж гунигладаг

Харийн хүний хөлд үйрсэн хилийн чулуу минь

Хаан Чингисийн нэрийг дуудан мэгшин уйлдаг

2010-12-15.

Сурв: Та судлаач, их сургуулийн багш хүний хувьд өнөөгийн хилчдэд юу гэж захиж хэлмээр байна?

Н: Энэ жил монголчууд бид өвөг дээдэс болох Хүннү гүрний байгуулагдсаны 2220 жилийн ойг тэмдэглэнэ.

Умард Хүннүгийн хаан Атилла /395-453/ "Хүннү гүрний оршихуй нь хатуу сахилга, дэг журам, зохион байгуулалт, ёс суртахуун нийлээд "Хүннү ухамсар", гэж айлдаж хойчийн бидэнд гэрээслэжээ.

Сахилга, дэг журам, зохион байгуулалтыг цаг ямагт эрхэмлэж ажиллаараа гэж захья даа.

Эх орны минь хил амгалан байг!

ХИЛЭЭС ТӨРСӨН УРАН БҮТЭЭЛ



Яруу найрагч Доржпаламын Хурц

ХИЛЧНИЙ ГЭРГИЙ

Эх орны торгон хил дээр 27 жил алба хаасан
дэд хурандаа Д.Түвдэндоржийн гэргий Ч.Дуламсүрэнд

Олон олон өдөр
Нүдээ чилээж харуулдсан
Ойр ойрхон халаасан
Цайгаа аягалж хүлээсэн
Олон олон шөнө
Нойроо хулжааж ганцаардсан
Одод хөлхөх үүдээ
Задгай манаж хоносон
Холоос ирсэн бэр
Хүний түшиг хань
Хилчний гэргий чи
Хилийн жаахан чулуухай
Суурин хотын эзэгтэй нар
Оо энгэсэгт умбаж
Сувд эрдэнэс сураглан
Жиг жуг хөөрсөж явахад
Сумангийн ганц эрдэнэ
Хилчний гэргий буйдхан
Шувуудын жиргээнд уясан
Амрагийн дуу аялаж суудаг
Үеийнх нь хүүхнүүд цөмөөрөө
Нөхрийнхөө цээжинд асаж
Үдшийн бүрий нөмрөхөд
Орондоо яаран дэгэлзэж байхад

Үйл заяаны нугачаанд
Бүсээ чангалан жавхайж
Үнэн хайрын шүтээн
Ханиа хүлээн гэгэлзэж байдаг
Нараан дэлгэсэн
Гурван зуун жаран таван өглөөний
Наандаж гуравны хоёрыг нь
Ганцаараа угтаж хоймор нь ханхайсан
Сараан хөллөсөн
Гурван зуун жаран таван үдшийн
Сааж бодоход тал илүүг нь
Ганцаараа холхиж хөнжил нь задгайрсан
Сүүн цагаан дусал
Хүний сайн хань
Сүйт хайрын гэрэл
Хилчний гэргий шувуухай
Хүлээж хүлээж учирсан
Янагийн бал амттай
Хүслийн гэгээн орчлонд
Дуулж жиргэсэн азтай
Хээрийн салхи үнэртсэн
Нөхрийн нөмөр илчтэй
Хилээ бүртгэж маналцсан
Журмын тангараг үнэтэй
Онгон торгон хилийн
Чулуу бүрийг харалцаж
Омог төгөлдөр эрсийн
Зүүдийг асааж гижигдсэн
Он жилийн цувраанд
Өврөө хатлан хямгадаж
Онцлож түшсэн ханийн
Өргөөг гийгүүлж гэрэлтсэн
Гаднаас нь харахад ганцаардавч
Эх орноо багтаасан энтэй
Гараас нь хөтөлсөн хүү нь
Эцгээ дуурайсан эрдэмтэй
Гал голомтоо сахьсан
Эхнэр төдий санавал нүгэл болох
Ган сэлэм агссан
Мандухайн чинээнд бодвол яг л болох
Хүний нутгийн дээсийг
Нүдээрээ жийсэн цааз
Миний нутгийн захын
Зүрхээрээ эмжсэн цайз
Хилчний гэргий чамайг
Алтаар мөнхлөх багадна
Хилийн торгон хайчаас
Алдрыг тань түүхэд олдоно

1999-9-8 Налайх

ШИНЭ НОМ




Доктор, профессор, хурандаа Цагааны Ганболд, магистр, хурандаа Дамбын Баатар агсан нарын туурвиж, докторант, бригадын генерал Ц.Сэргэлэн ариутган шүүж Монгол улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, Мэдээлэлжүүлэлтийн олон улсын академын академич, цэргийн шинжлэх ухааны доктор, профессор Ш.Арвай өмнөтгөл бичсэн цэргийн сургалтын дээд хэлбэрүүд болох команд-штабын сургууль, штабын дадлага, бүлгийн дасгал, хээрийн сургуулийг бэлтгэх, зохион байгуулж явуулах арга зүйн асуудлаар "Штабын бэлтгэл" ном хилчин уншигч та бүгдэд толилуулагдаж байна.

Хил хамгаалах байгууллагын эрдэмтэн судлаачид бид удирдлагын бэлтгэл, команд штабын сургууль, тоглолт, дадлага, хээрийн сургууль бэлтгэн явуулах эрдэм шинжилгээ, сургалт арга зүйн шинжтэй сурах бичгийг хилчийн хамт олонд өргөн барьж байгаадаа баяртай байна

Удирдлагын бэлтгэл, штабын дадлага нь хилийн цэргийн сургалтын үндсэн хэсэг бөгөөд Хил Хамгаалах Байгууллагын анги, салбаруудыг хатуу чанд удирдан тэдний гар нийлэмжтэй ажиллагааг хангаж, байнгын бэлэн байдалд байлгахад чиглэгдсэн цогц арга хэмжээ юм.

Штаб, удирдлагын бэлтгэл нь хилийн цэргийн анги салбарыг улсын хил хамгаалах, хилийн операци бэлтгэн явуулах, байлдааны ба тусгай ажиллагааны үед тайван цагийн үйл ажиллагаанаас байлдааны цагийн байдалд шилжүүлэх, хилийн бүс, зурваст байрлаж буй зэвсэгт хүчний анги салбарууд, дотоодын цэрэг, цагдаа, тагнуулын байгууллагуудтай улсын хилийн хамгаалалтын асуудлаар уялдан зохицуулагдсан үр дүнтэй харилцан ажиллагааг хангах зорилгоор дэс дараатай, цогцолбор байдлаар явуулж буй сургалт, дадлага, алба, үйл ажиллагааны нэгдэл юм.

Сурах бичгийн агуулгыг ямар нөхцөлд, яаж үр дүнтэй ашиглаж хэрэгжүүлэх нь таны мэргэн ухаан, авъяас билэг итгэл үнэмшил, бүтээлч хандлагаас шалтгаалах нь мэдээж хэрэг.



Түүхийн ухааны доктор(Ph.D) Чогсомын Жазаг

"Гэгээн судар" номын учир

Орчлонд хүний ёсоор гэгээлэг амьдрахуйн утга учир, ариун журамт эрдэмт хүн байхуйн мөн чанар, ач тусын тухай онцолсон Өрнө, Дорнын хийгээд өөрийн орны 200 гаруй мэргэд, сод ухаантан, яруу найрагчдын 2000 гаруй ишлэл, айлдвар, сургаал, онолын дүгнэлт, тодорхойлолт зэрэг тарни мэт тансаг мөрүүдийг 60 гаруй судар номноос шүүрдэн тунгааж агуулгаар нь эрэмбэлж зохиогч өөрийн бодрол эргэцүүллээр хэлхэн, бясалгалаар нэрж дээжилсэн юм.

Энэ номын эхний онцлог бол тууний өндөр үнэ цэнэ.. Энд төгрөг мөнгөөр илэрхийлсэн үнийг хэлээгүй. Номын гол агуулга, үзэл санаа бол -Хүмүүний ёс суртахуун, хүнлэг ариун чанараа дээдлэхүй хийгээд хүн хүнээрээ оршихуй.

Ёс суртахуун, хүн чанараа гээхгүй, жинхэнэ хүнээрээ оршихуйн арга зам, байгалийн жамаар сайн сайхнаар зөв амьдрахуйн зам мөрийг гийгүүлж өгснөөрөө, бас ёс суртахуун, шударга ариун чанараа гээхлээрээ хүн гэгч ямаршуу гутамшигтай, адгийн амьтан болон хувирч байгалийн гэсгээл цээрлэл амсдаг зүй тогтолтойг анхааруулж сэрэмжлүүлсэнд энэ номын үнэ цэнэ оршимой. Ёс суртахуун, хүнлэг чанар бол ертөнц дахиныг, улс орныг ч, айл гэр, хувь хүнийг ч доройтол сүйрлээс аврах агуу хүч, эрдэнэс баялаг болой гэдгийг энэ номоос олж ухаарна.

Монголчууд амар амгалан, аз жаргалтай, чинээлэг сайхан амьдрах гол эх ундарга нь хөрөнгө мөнгө байгалийн баялаг гэхээсээ илүүтэй чин үнэн, шулуун шударга, хүнлэг чанар, зориг тэвчээр, нинжин сэтгэлээ дээдлэхүй болохыг энэ номоос гүнзгий мэдэрнэ.

Номын нөгөө нэг онцлог бол ёс суртахуун, хүнлэг чанарыг "Эрдэм"-ийн зиндаанд өргөмжилсөн мэргэдийн сургаалийг улам тод томруун дээдэлсэнд оршимуй. "Эрдэм" гэхлээр бидний ихэнх нь "мэдлэг, боловсрол" хэмээх үгүүдтэй адилтган ойлгодог бус уу? Тэгвэл ёс суртахуун бол мэдлэг боловсролоос хавьгүй дээгүүр залагдан үнэлэгдэж, хаан суудалд өргөмжлөгдөх учиртай эрдмийн дээд эрдэм гэдгийг энэ ном гүнзгий мэдрүүлнэ. "Зан суртахуунд суурилаагүй мэдлэг бол юу ч биш", "Урьдаар зөв хүмүүжлийг ол, дараа нь мэргэн ухаанд суралц. Эхнийх нь үгүй бол сүүлчийнхэд нь хүрэх хэцүү", "Эрдмийн ажилд урагштай хэрнээ зан суртахуунаар ухралтай яваа хүн урагшаа биш, харин улам хурдан хойшоо алхаж яваа хэрэг" гэх зэрэг мэргэдийн гайхамшигт айлдварууд энэ номд бий.

Шударга хийгээд үнэнээр явахын ач тус учир утгыг ухаарч, нэр алдар, зовлон гунигийг даах тэсвэр тэвчээрийг олох, өрөвч нигүүлсэнгүй, нинжин сэтгэл, эелдэг занд суралцан, өөрийгөө эзэмдэн жолоодохуйн их эрдэмд боловсрон гэгээрэхэд нийт 11 бүлэгтэй энэ ном танд тусална. Сайн сайхны мөрийн хөтөлбөрөөр зөв амьдарч, бузар бусармагт авталгүй тэнгэрийн зарлигаар хүнээрээ үлдэхийг хүсэгч хэн бүхэнд зориулсан ширээний хийгээд халаасны ном.

Эгэл жирийн хүүхэд багачууд, тэднийг сурган хүмүүнжүүлэгч аав, ээж, ах эгч, багш, ахмад , залуу үе, цэрэг, офицер, төрийн түшээд алинд нь ч өгөөжтэй, хүчтэй нөлөөлөх гэгээн судар.

Энэ номын Ерөнхий редакторoор Зохиолч, сэтгүүлч Я.Сумьяа, дэд редактораар зохиолч, сэтгүүлч Г. Дамба, Б. Чантуу, С.Дүүриймаа нар ажиллан Монгол улсын Төрийн соёрхолт, Соёлын гавьяат зүтгэлтэн, богино өгүүллэгийн нэрт мастер Балжирын Догмид мялаалгын үг өргөжээ.